

ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2024 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНД  
ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: **ӨМА-2025/001/НА-СТА-ТЭЗ**

Даланзадгад хот 2025 он



Дарга, Тэргүүлэх аудитор Ц.Өсөхбаяр  
Утас: 70533539 Цахим хаяг: [Usukhbayarts@audit.gov.mn](mailto:Usukhbayarts@audit.gov.mn)  
Аудитын менежер Т.Хонгорзул  
Утас: 70533552 Цахим хаяг: [Khongorzult@audit.gov.mn](mailto:Khongorzult@audit.gov.mn)  
Ахлах аудитор Ж.Болормаа  
Утас: 70533552 Цахим хаяг: [bolormaaja@audit.gov.mn](mailto:bolormaaja@audit.gov.mn)  
Ахлах аудитор С.Одончимэг  
Утас: 70533552 Цахим хаяг: [Odonchimegs@audit.gov.mn](mailto:Odonchimegs@audit.gov.mn)  
Аудитор Э.Жаргал  
Утас: 70533552 Цахим хаяг: [jargale@audit.gov.mn](mailto:jargale@audit.gov.mn)  
Аудитор Ө.Болортуяа  
Утас: 70533552 Цахим хаяг: [bolortuyau@audit.gov.mn](mailto:bolortuyau@audit.gov.mn)  
Аудитор П.Санчиргарав  
Утас: 70533552 Цахим хаяг: [Sanchirgaravp@audit.gov.mn](mailto:Sanchirgaravp@audit.gov.mn)  
Аудитор Т.Будсүрэн  
Утас: 70533552 Цахим хаяг: [Budsurent@audit.gov.mn](mailto:Budsurent@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг  
дараах хаягаар авна уу: Цахим хаяг: [www.audit.mn](http://www.audit.mn)

## Агуулга

1. Санал дүгнэлт .....	3
2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан.....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан.....	5
2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	6
2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	8
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан .....	9
Аудитын тайлан.....	10
3.2 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй .....	10
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт .....	10
3.4 Материаллаг байдал .....	11
3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт.....	11
3.5.1 Мөнгөн хөрөнгө .....	11
3.5.2 Авлага.....	11
3.5.3 Урьдчилгаа .....	13
3.5.4 Урт хугацаат хөрөнгө оруулалт .....	13
3.5.7 Өр төлбөр.....	15
3.5.8 Засгийн газрын хувь оролцоо.....	16
3.5.9 Орлогын данс.....	17
3.5.10 Зардлын данс.....	19
3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	20
<b>3.7.2.Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт .....</b>	<b>25</b>
<b>3.7.3. Орон нутгийн өмчит газруудын талаар .....</b>	<b>26</b>
Өмнөговь аймгийн хэмжээнд Орон нутгийн өмчийн аж ахуй нэгж 43, орон нутгийн өмчийн оролцоотой аж ахуй нэгж 2 байгууллага үйл ажиллагаа явуулж байна.....	26
<b>3.8 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....</b>	<b>26</b>
<b>3.9 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга .....</b>	<b>28</b>
3.10 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн .....	29
<b>3.11 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал</b>	<b>29</b>
3.12 Аудитын илрүүлэлт.....	29
<b>АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ .....</b>	<b>35</b>

**ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ**

АДБОУС	Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт
УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
СТОУС	Санхүүгийн тайлангийн олон улсын стандарт
ТАЗСЗ	Төрийн албаны салбар зөвлөл
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ОНӨААН	Орон нутгийн өмчит аж ахуйн нэгж
ОНӨОААН	Орон нутгийн өмчийн орлолцоотой аж ахуйн нэгж
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ОНТХО	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
АЗДТГ	Аймгийн засаг даргын тамгын газар
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ХХС	Хоршоо хөгжүүлэх сан
ОНӨҮГ	Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
УТҮГ	Улсын төсөвт үйлдвэрийн газар
НҮГ	Нийтлэг үйлчилгээ үйлдвэрийн газар
ҮХЭХАТ	Үл хөдлөх эд хөрөнгийн татвар
АТБӨЯХАТ	Автотээвэр болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар
ТТХК	Тавантолгой хувьцаат компани

## 1. Санал дүгнэлт



### ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон 304 тоот, 3 дугаар баг,  
Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 46083  
Утас: (976) 7053 3539, Цахим хуудас: www.audit.mn  
Цахим шуудан: umnugovi@audit.gov.mn

2025.04.21 № 341

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

#### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4-д заасны дагуу Өмнөговь аймгийн Засаг даргын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн байдал, тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

#### Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Мал хамгаалах сан, төсвийн хөрөнгө оруулалтын дансны 5 жилээс дээш насжилттай авлагыг барагдуулах талаар арга хэмжээ авч ажиллаагүй, өмнөх аудитаар өгсөн хоршоо хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн зээлийг барагдуулах зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, төсвийн байгууллагатай ижил чиг үүрэг бүхий орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой газар байгуулж төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан, төсөл, хөтөлбөр, арга хэмжээний үр дүнг тооцож, зарцуулалтад хяналт хэрэгжүүлээгүй, төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа газруудад илэрсэн зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн нэгтгэсэн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна.

Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.16, 5 дугаар зүйлийн 5.1.3, 5.1.5, 6 дугаар зүйлийн 6.6.6, 14 дүгээр зүйлийн 14.2.3, 14.2.12, 14.3, 41 дүгээр зүйлийн 41.2.7, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх заалт, 13 дугаар зүйлийн 13.7 дахь хэсэгтэй нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлагналын тохиолдсон байх, иж бүрэн байх, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

ҮНДЭСЛЭЛ ХАРИУЦЛАГА 4625021683

### Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Өмнөговь аймгийн ИТХ-ын 2024 оны 19/28 дүгээр тогтоол болон сумдын ИТХ-ын "2024 оны төсвийн тодотгол батлах тухай" тогтоолоор аймгийн төсөвт 2,081,354.4 сая төгрөгийн орлого төвлөрүүлэхээр баталж, гүйцэтгэлээр 1,879,083.5 сая төгрөгийн орлого төвлөрүүлэн баталсан төлөвлөгөөг 90.3 хувиар биелүүлсэн байна.

### Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хуульд заасны дагуу улсын төсөвт 1,249,676.3 сая төгрөгийн орлого төвлөрүүлсэн байна.

### Бусад асуудал

Өмнөговь аймгийн ИТХ-ын 2024 оны 03/10 дугаар тогтоолоор "Аймгийн 2024 оны хөгжлийн жилийн төлөвлөгөө"-ний хэрэгжилтийг 85 хувь буюу "тодорхой үр дүнд хүрсэн" гэж дүгнэсэн байна.

### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ӨСӨХБЯАР

## 2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

*/ мянган төгрөгөөр/*

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>		1,279,400,767.0	1,217,229,908.9
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	3а, 3б	988,674,309.0	627,721,564.5
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	5а, 5б, 6а, 6б	91,301,276.3	84,546,756.5
<b>34</b>	<b>УРЬДЧИЛГАА</b>	7а, 7б	13,191,020.4	69,035,771.9
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	8а, 8б, 8в	51,259,334.9	236,167,464.1
<b>36</b>	<b>НӨӨЦИЙН БАРАА</b>	9а	1,158,702.0	548,960.1
<b>360</b>	<b>БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ</b>	10	133,816,124.3	199,209,391.8
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>		684,488,369.4	1,060,483,342.0
<b>37</b>	<b>УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ</b>	11а, 11б	434,179.5	434,179.5
<b>37300</b>	<b>Урт хугацаат зээл</b>		434,179.5	434,179.5
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	12а, 12б, 12в	684,054,189.9	1,060,049,162.5
<b>39200</b>	<b>Биет хөрөнгө</b>		616,206,997.9	955,846,914.7
<b>39300</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	13	67,748,488.6	104,103,544.3
<b>39400</b>	<b>Бусад хөрөнгө /ТӨҮГ/</b>	14	98,703.5	98,703.5
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>		1,963,889,136.3	2,277,713,250.9
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>		636,663,314.2	538,805,720.6
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	15а, 15б	492,431,637.1	322,569,065.9
<b>41200</b>	<b>Богино хугацаат зээлийн өглөг</b>	16а, 16б	-	66,755.7
<b>41300</b>	<b>Өглөг</b>	17а, 17б	296,207,054.3	79,250,283.8
<b>41400</b>	<b>Урьдчилж орсон орлого</b>	18а, 18б	196,224,582.8	243,252,026.5
<b>42</b>	<b>УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>		144,231,677.1	216,236,654.7
<b>42200</b>	<b>Урт хугацаат зээл</b>	20а, 20б	144,231,677.1	216,236,654.7
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>		1,327,225,822.1	1,738,907,530.3
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>		1,326,885,252.3	1,738,566,960.5
<b>51100</b>	<b>Засгийн газрын оруулсан капитал</b>		113,612,804.4	110,514,896.6
<b>51101</b>	<b>Өмч /төрийн/ /ТӨҮГ/</b>		6,469,500.9	10,292,219.1
<b>51106</b>	<b>Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/</b>		1,362,945.3	1,443,072.0
<b>51200</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>		1,194,619,710.4	1,605,540,396.3
<b>51300</b>	<b>Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү</b>		10,820,291.2	10,776,376.5
<b>52</b>	<b>Хяналтын бус хувь оролцоо</b>		340,569.8	340,569.8
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>		1,963,889,136.3	2,277,713,250.9

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

*/мянган төгрөгөөр/*

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>		<b>2,269,730,000.6</b>	<b>2,776,932,957.3</b>
<b>11</b>	<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>		<b>1,007,849,159.3</b>	<b>1,647,843,366.9</b>
<b>110</b>	<b>Орлогын албан татвар</b>		778,027,536.9	1,394,412,566.2
<b>1100</b>	<b>Хувь хүний орлогын албан татвар</b>		210,835,529.4	235,190,603.1
<b>1101</b>	<b>Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт</b>		-1,663,541.3	-2,138,968.5
<b>1103</b>	<b>ААН-ын орлогын албан татвар</b>		568,855,548.8	1,161,360,931.6

Өмнөговь аймгийн Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

113	Хөрөнгийн албан татвар		173,906,652.2	204,426,300.2
118	Бусад татвар, төлбөр, хураамж		55,914,970.2	49,004,500.6
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1а, 1б	1,258,904,917.4	1,124,516,474.7
120	Нийтлэг татварын бус орлого		1,226,036,587.4	1,075,783,964.5
121	Хөрөнгийн орлого		606,147.9	206,666.7
122	Тусламжийн орлого		4,000,000.0	2,500,000.0
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг		28,262,182.0	46,025,843.5
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		2,975,923.9	4,573,115.7
II	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>2а, 2б</b>	<b>1,227,610,788.6</b>	<b>1,749,369,420.3</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>		<b>1,227,610,788.6</b>	<b>1,749,369,420.3</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>		<b>737,536,989.5</b>	<b>476,092,406.3</b>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		19,815,777.2	33,110,759.4
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		2,534,815.9	4,209,504.3
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		2,296,398.0	15,110,078.4
2104	Хангамж, бараа материалын зардал		15,266,350.3	19,855,874.8
2105	Нормативт зардал		830,628.8	929,252.3
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		1,790,076.5	3,416,523.9
2107	Томилолт, зочны зардал		418,211.5	625,235.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		531,567,991.8	196,508,835.8
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		163,016,739.5	202,326,342.4
212	ТАТААС		134,000.0	119,040.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		489,939,799.00	1,273,157,974.0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)		1,042,119,212.1	1,027,563,537.0
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН		0	84,495.4
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		153,392,904.1	305,501,169.5
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)		888,726,307.9	722,146,862.9

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>2,326,597,167.8</b>	<b>3,218,238,443.4</b>
11	ТАТВАРЫН ОРЛОГО	894,304,243.7	1,647,843,366.9
110	Орлогын албан татвар	664,482,621.2	1,394,412,566.2
1100	Хувь хүний орлогын албан татвар	210,835,529.4	235,190,603.1
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-1,663,541.3	-2,138,968.5
1103	ААН-ын орлогын албан татвар	455,310,633.2	1,161,360,931.6
113	Хөрөнгийн албан татвар	173,906,652.2	204,426,300.2
118	Бусад татвар, төлбөр, хураамж	55,914,970.2	49,004,500.6
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	3,772,193.4	3,567,806.3

Өмнөговь аймгийн Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

1181	Газрын төлбөр	17,307,366.1	15,249,809.9
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	34,459,915.6	29,790,444.5
1183	Бусад татвар	375,495.2	396,439.9
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,429,320,100.4	1,565,782,132.7
120	Нийтлэг татварын бус орлого	1,396,451,770.4	1,517,049,622.5
121	Хөрөнгийн орлого	606,147.9	206,666.7
122	Тусламжийн орлого	4,000,000.0	2,500,000.0
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	28,262,182.0	46,025,843.5
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,972,823.8	4,612,943.8
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,289,515,309.1	2,867,736,562.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,289,515,309.1	2,867,736,562.2
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>795,871,991.3</b>	<b>1,583,826,977.3</b>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	36,611,576.6	112,673,941.4
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	7,562,068.4	11,992,913.1
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	4,911,857.9	18,367,389.5
2104	Хангамж, бараа материалын зардал	173,737,154.7	20,026,522.6
2105	Нормативт зардал	604,565.1	782,369.3
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,806,389.6	3,645,361.2
2107	Томилолт, зочны зардал	418,209.0	625,235.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	440,809,583.1	1,289,857,650.8
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	129,410,586.9	125,855,594.3
211	ХҮҮ	0	0
212	ТАТААС	154,000.0	119,040.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	493,489,317.8	1,283,790,545.0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	1,037,081,858.8	350,501,881.1
IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)	1,085,908.4	6,949,930.0
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	234,212,128.2	423,173,286.2
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	234,212,128.2	423,173,286.2
2200	Дотоод эх үүсвэрээр	234,212,128.2	423,173,286.2
2260	Гадаад эх үүсвэрээр	0	0
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-233,126,219.8	-416,223,356.2
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-275,327,904.8	-295,231,269.5
14	Бусад эх үүсвэр	3,781,073.3	0
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	1,009,576.3	0
25	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	278,099,401.7	295,231,269.5
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	528,627,734.2	-360,952,744.5
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	460,046,574.8	988,674,309.0
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	988,674,309.0	627,721,564.5

## 2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	<i>/мянган төгрөгөөр/</i>	
		Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	726,497,269.8	726,497,269.8
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-293,556,770.7	-293,556,770.7
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	432,940,499.2	432,940,499.2
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	160,708.0	160,708.0
7	Өмчид гарсан өөрчлөлт	5,404,252.5	5,404,252.5
8	Зарласан ногдол ашиг	-5,945.5	-5,945.5
9	Тайлант үеийн үр дүн	888,726,307.9	888,726,307.9
10	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,327,225,822.1	1,327,225,822.1
11	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,327,225,822.1	1,327,225,822.1
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-15,750,695.5	-15,750,695.5
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,311,475,126.6	1,311,475,126.6
18	Зарласан ногдол ашиг	-294,714,459.2	-294,714,459.2
19	Тайлант үеийн үр дүн	722,146,862.9	722,146,862.9
20	2024 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	1,738,907,530.3	1,738,907,530.3

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	<i>/мянган төгрөгөөр/</i>	
		Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>2,296,856,312.9</b>	<b>1,904,418,994.8</b>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,709,099,106.0	1,459,311,873.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	219,577,497.5	170,374,448.6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	29,968,457.6	27,201,355.3
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,761,325.2	3,392,541.5
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	17,188,419.5	15,038,322.1
2104	Хангамж, бараа материалын зардал	3,901,767.5	3,383,101.8
2105	Нормативт зардал	391,039.8	314,592.6
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,480,723.7	3,607,266.0
2107	Томилот, зочны зардал	571,372.0	461,643.7
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	37,761,000.9	25,348,331.9
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	121,553,391.3	91,627,293.9
212	ТАТААС	144,000.0	119,040.0
2122	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	144,000.0	119,040.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,489,377,608.5	1,288,818,384.4
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	1,486,442,615.9	1,286,303,562.1
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,934,992.6	2,514,822.3
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	587,757,206.9	445,107,121.8
<b>III</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>2,296,856,312.9</b>	<b>1,926,045,434.3</b>
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	47,716,026.0	46,025,843.5
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,221,375,593.5	1,871,261,160.4

Өмнөговь аймгийн Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	22,214,693.4	6,258,430.5
36	ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ	5,550,000.0	2,500,000.0
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.0	22,336,935.3
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.0	43,963,374.8

**2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан**

Код	Үзүүлэлт	/ мянган төгрөгөөр/ ТЕЗ цэвэр дүн
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>52,668,767.5</b>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	28,684,545.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	25,678,280.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,506,450.1
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	298,638.4
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	4,916.5
2104	Хангамж, бараа материалын зардал	301,714.1
2105	Нормативт зардал	100,597.8
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	396,980.2
2107	Томилот, зочны зардал	154,108.4
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,673,713.5
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	18,241,161.2
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,006,265.2
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,043,981.1
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	962,284.1
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	23,984,222.1
2200	Дотоод эх үүсвэрээр	23,984,222.1
<b>I</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>52,668,767.5</b>
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	52,668,767.5

## **Аудитын тайлан**

---

### **3.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, 8 дугаар зүйлийн 8.1, 20 дугаар зүйлийн 20.1-д заасны дагуу Өмнөговь аймгийн Засаг даргын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийж аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл, баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд олон жилийн насжилттай авлага, хөрөнгийн бүртгэл, дотоод хяналттай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан.

Аудитыг 2025 оны 04 дүгээр сарын 01 өдрөөс 20-ны хооронд ахлах аудитор Ж.Болормаа, аудитор Э.Жаргал, Ө.Болортуяа, П.Санчиргарав нар гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер Т.Хонгорзул хэрэгжүүлэн, дарга, Тэргүүлэх аудитор Ц.Өсөхбаяр хянан удирдсан.

Өмнөговь аймгийн Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг 2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн 01/933 дугаар албан бичгээр ирүүлсэн.

### **3.2 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй**

Өмнөговь аймгийн Засаг даргын үйл ажиллагааны эрхэм зорилго нь “Төрийн үйлчилгээнд олон улсын менежментийн тогтолцоог нэвтрүүлж, иргэн төвтэй хариуцлагатай манлайлагч байгууллага байна” гэж тодорхойлсон байна.

Дээрх эрхэм зорилгынхоо хүрээнд дор дурдсан үйл ажиллагааны стратегийн зорилтыг хэрэгжүүлэхээр тодорхойлсон байна. Үүнд:

- Төрийн үйлчилгээний ил тод, шуурхай байдлыг тэргүүн туршлага болгоно,
- Бодлого төлөвлөлт, бодлогын хэрэгжилтийн үр дүнг сайжруулах тэргүүний туршлагыг нэвтрүүлнэ,
- Иргэд, талуудтай зөвлөлдөх, тэдний үнэлгээ, санаа бодлыг тусгах зарчмыг үйл ажиллагаанд хэвшүүлнэ,
- Төрийн албаны мэргэшсэн, чадварлаг, тогтвортой байх нөхцөлийг ТАЗСЗ-тэй хамтран бүрдүүлнэ,
- Төрийн албан дахь хариуцлагыг сайжруулах цогц арга хэмжээ хэрэгжүүлнэ.

### **3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт**

Санхүүгийн нэгтгэсэн тайлан болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцэж байна.

Монгол улсын Сангийн сайдын 2014 оны 65 дугаар тушаалаар баталсан "Төрийн сангийн үйл ажиллагааны дотоод хяналтын журам"-ыг төрийн сангийн үйл ажиллагаандаа мөрдөж ажилласан байна.

Өмнөговь аймгийн Засаг даргын дэргэдэх санхүүгийн хяналт, аудитын алба нь 2024 онд төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа 36 байгууллагад санхүүгийн хяналт шалгалт, 36 байгууллагад дотоод аудит хийсэн байна.

### 3.4 Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн нийт хөрөнгийн дүнг сонгож, эрсдэлийн түвшнийг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын түвшнийг 2024 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,749,369.4 сая төгрөгийн 1 хувь буюу 17,493.7 сая төгрөгөөр тогтоов. Гүйцэтгэлийн үе шатанд төлөвлөлтийн шатанд тогтоосон материаллаг байдлын түвшнийг өөрчлөх шаардлагагүй гэж үзсэн болно.

### 3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

#### 3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 988,674.3 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 627,721.6 сая төгрөг болж 360,952.7 сая төгрөгөөр буурсан байна.

*Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Касст байгаа бэлэн мөнгө	8.3	2.1	-6.2
Банканд байгаа бэлэн мөнгө	988,609.3	627,635.9	-360,973.4
Хадгаламж	56.7	83.6	-26.9
<b>Дүн</b>	<b>988,674.3</b>	<b>627,721.6</b>	<b>-360,952.7</b>

*Эх сурвалж: Өмнөговь аймгийн Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд байгаа 203,748.2 сая төгрөг төрийн сангийн харилцах дансанд, 382,017.8 сая төгрөг арилжааны банкны дансанд, 41,955.6 сая төгрөг бусад төсөл, нөөцийн харилцах дансанд байршиж байна. Харин “Гүний ус” ХХК-ны 83.6 сая төгрөг хадгаламжид байна. Нийт мөнгөн хөрөнгийн 60.9 хувь орон нутгийн болон орон нутгийн оролцоотой аж ахуйн нэгжүүдийн, 25.4 хувь нь төрийн сангийн, 6.7 хувь нь төсөл сангийн, 7 хувь нь төсөвт байгууллагын хөрөнгийн үлдэгдэл байна.

#### 3.5.2 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 91,301.2 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 84,546.7 сая төгрөг болж 6,754.5 сая төгрөгөөр буурсан байна.

*Хүснэгт №2 Авлагын үлдэгдэл /сая төгрөг/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	89.0	53.0	(36.0)
Төлбөртэй үйлчилгээний авлага	272.3	381.8	109.5
Зээлийн хүүгийн авлага	96.8	218.6	121.8
Дансны авлага	66,339.9	49,074.6	(17,265.3)
Татвар, НДШ-ийн авлага	465.0	4,554.3	4,089.3
Бусад авлага	23,852.0	29,849.5	5,997.5
Зээлийн авлага	186.2	414.9	228.7
<b>Дүн</b>	<b>91,301.2</b>	<b>84,546.7</b>	<b>(6,754.5)</b>

*Эх сурвалж: Өмнөговь аймгийн Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Тайлант онд үүссэн авлагаас 29,657.7 сая төгрөг буюу 35.1 хувийг төсвийн байгууллага, 54,836.7 сая төгрөг буюу 64.9 хувийг ОНӨААН болон ОНӨОААН, 2.4 сая төгрөг буюу 0.002 хувийг төсөл сан, 50.3 сая төгрөг буюу 0.06 хувийг төрийн сангийн авлага эзэлж байна.

Авлагын үлдэгдлийн насжилт дараах байдалтай байна.

Хүснэгт №3 Насжилт гаргасан судалгаа

/сая төгрөг/

№	Данс	Үлдэгдэл дүн	Авлагын насжилт		
			1 жил хүртэл	1-5 жил	5 жилээс дээш
<b>A</b>	<b>АВЛАГЫН ДҮН</b>	<b>84,546.7</b>	<b>15,311.4</b>	<b>63,913.0</b>	<b>5,322.3</b>
<b>1</b>	<b>Ажиллагсадтай холбоотой авлага</b>	53.0	11.3	41.7	-
	Төсөв байгууллага	5.5	5.5	-	-
	ОНӨААН	47.4	5.8	41.7	-
<b>2</b>	<b>Дансны авлага</b>	<b>50,195.6</b>	<b>620.7</b>	<b>49,311.4</b>	<b>263.6</b>
	Төсөв байгууллага	740.2	175.4	313.2	251.5
	ОНӨААН	49,455.4	445.3	48,998.1	12.0
<b>3</b>	<b>Татвар НДШ-ын авлага</b>	<b>4,553.7</b>	<b>4,113.9</b>	<b>439.8</b>	-
	ОНӨААН	4,553.7	4,113.9	439.8	-
<b>4</b>	<b>Байгууллагаас авах авлага</b>	<b>26,991.4</b>	<b>9,946.4</b>	<b>13,036.2</b>	<b>4,008.8</b>
	Төсөв байгууллага	26,181.7	9,236.6	13,004.4	3,940.7
	ОНӨААН	758.7	709.8	31.1	17.8
	Төсөл сан	0.7	-	0.7	-
	Төрийн сан	50.3	-	-	50.3
<b>5</b>	<b>Хувь хүмүүсээс авах авлага</b>	<b>2,752.9</b>	<b>619.0</b>	<b>1,084.0</b>	<b>1,049.9</b>
	Төсөв байгууллага	2,730.1	606.9	1,081.8	1,041.4
	ОНӨААН	21.0	10.3	2.2	8.5
	Төсөл сан	1.8	1.8	-	-

Эх сурвалж: Өмнөговь аймгийн Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Төсөвт байгууллагуудын нийт авлага өмнөх оноос 6,131.5 сая төгрөгөөр нэмэгдсэн нь АИТХ-ын 2021 оны 198 дугаар тогтоолоор баталсан “Нутгийн үйлдвэрлэгч” хөтөлбөрийн хүрээнд төсөл хэрэгжүүлэх гэрээгээр 7 жилийн хугацаатай, хүүгүйгээр олгосон дараах авлага гол нөлөө үзүүлсэн байна. Үүнд:

- Шохойн чулууны үйлдвэрийн 1,620.0 сая төгрөг,
- Ингэний сүүний үйлдвэрийн 1,500.0 сая төгрөг,
- Асфальтын үйлдвэрийн 2,019.6 сая төгрөг,
- Ноосны үйлдвэрийн 2,000.0 сая төгрөг,

Таван жилээс дээш насжилттай авлага болох 2013, 2014 онуудад “1000 айлын орон сууц хөтөлбөр”-ийн хүрээнд эргэн төлөгдөх нөхцөлтэй олгосон 5,873.4 сая төгрөгийн авлагаас тайлант онд 1,877.5 сая төгрөгийг барагдуулж ажилласан байна.

ТЕЗ-ийн харьяа аж ахуйн нэгж, байгууллагуудын авлагын данстай холбоотой аудитын илрүүлэлт:

- Номгон сумын ХХС-ийн 60.4 сая, Сэврэй сумын ХХС-ийн 121.1 сая, Ханхонгор сумын ХХС-ийн 137.0 сая, Ханбогд сумын Хандизель ОНӨААТҮГ-ын 258.0 сая, Ханбогд хот тохижилт ОНӨААТҮГ-ын 255.7 сая, Орон сууц корпораци ОНӨААТҮГ-ын 39.0 сая, Мандал-Овоо сумын ЗДТГ-ын 54.5 сая, Баян-Овоо сумын ХХС-ийн 183.8 сая, Булган сумын ХХС-ийн 88.6 сая, Мандал-Овоо сумын ХХС 168.8 сая, Ханхонгор сумын ХХС-ийн 137.0 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлж, үлдэгдлийг баталгаажуулаагүй,

- Даланзадгад сумын ХХС болон бусад сангийн 273.4 сая төгрөгийн чанаргүй зээлийн үлдэгдэл, Мандал-Овоо сумын ЗДТГ-ын малжуулах төслийн 13.6 сая, Өмнөговь корпораци

ОНӨААТҮГ-ын 286.9 сая, Цогт-Овоо сумын ОНХС-ийн 94.3 сая төгрөгийн насжилт өндөртэй авлагыг төлүүлэх талаар холбогдох арга хэмжээг авч ажиллаагүй байна.

### 3.5.3 Урьдчилгаа

Урьдчилгаа дансны эхний үлдэгдэл 13,191.0 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 69,035.8 сая төгрөг болж, 55,844.8 сая төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт №4 Урьдчилгаа дансны үлдэгдэл /сая төгрөг/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Урьдчилж гарсан зардал	13,130.2	68,981.5	55,851.3
Бараа материал бэлтгэх урьдчилгаа	60.8	54.3	-6.5
<b>Дүн</b>	<b>13,191.0</b>	<b>69,035.8</b>	<b>55,844.8</b>

*Эх сурвалж: Өмнөговь аймгийн Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Урьдчилгаа дансны үлдэгдэлд 68,891.5 сая төгрөг буюу 99.7 хувийг урьдчилж гарсан зардал эзэлж байна. Үлдэгдлийг харуулбал:

- Таван толгой ХК 68,825.7 сая төгрөг,
- Гүний ус ХХК 20.3 сая төгрөг
- Хөгжил хөрөнгө оруулалтын газар ОНӨААТҮГ 56.7 сая төгрөг,
- Байгаль орчин аялал жуулчлалын газар 37.4 сая төгрөг
- Гурвансайхан орон сууцны корпораци 5.7 сая
- 6 сумдын эрчим хүчний ОНӨААТҮГ 26.9 сая төгрөг,
- Гурвантэс сумын ЗДТГ 1.9 сая
- Гурвантэс сумын ИТХ 12.0 сая
- Ханбогд сумын ИТХ 42.6 сая төгрөг
- Баяндалай сумын нийтлэг үйлчилгээний газар 6.7 сая
- Мандал-Овоо сумын ИТХ 11.9 сая төгрөг байна.

### 3.5.4 Урт хугацаат хөрөнгө оруулалт

Урт хугацаат хөрөнгө оруулалтын дансны үлдэгдэлд өөрчлөлт ороогүй байна.

*Хүснэгт №5 Урт хугацаат хөрөнгө оруулалт дансны үлдэгдэл /сая төгрөг/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Урт хугацаат ХО-г зам гүүр	434.2	434.2	0
<b>Дүн</b>	<b>434.2</b>	<b>434.2</b>	<b>0</b>

*Эх сурвалж: Өмнөговь аймгийн Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

### 3.5.5 Бараа материал

Бараа материалын эхний үлдэгдэл 51,259.3 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 236,167.5 сая төгрөг болж 184,908.2 сая төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт №6 Бараа материалын үлдэгдэл /сая төгрөг/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Түүхий эд материал	3,903.8	4,182.0	278.2
Дуусаагүй үйлдвэрлэл	232.3	102.1	-130.2
Бэлэн бүтээгдэхүүн	33,740.8	219,588.9	185,848.1
Хангамжийн материал	12,934.4	11,913.9	-1,020.5
Мал амьтад	448.0	380.6	67.4
<b>Дүн</b>	<b>51,259.3</b>	<b>236,167.5</b>	<b>184,908.2</b>

*Эх сурвалж: Өмнөговь аймгийн Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Нийт бараа материалыг байгууллагын бүтцээр нь авч үзвэл 14,134.2 сая төгрөг буюу 6 хувийг төсөвт байгууллагууд, 222,033.3 сая төгрөг буюу 94 хувийг төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн бараа материал тус тус эзэлж байна.

ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын бараа материалын данстай холбоотой аудитын илрүүлэлт:

- Баяндалай сумын ЗДТГ- 71.5 сая, ИТХ- 4.8 сая, Ханхонгор сумын ЗДТГ-56.2 сая, Сэврэй сумын НҮГ-4.3 сая, Буянтхотхон УТҮГ-22.2 сая төгрөгийн шатахууны жолоочийн тооцооны хуудасгүй, шаардах хуудсаар олгоогүй, норм норматив тооцоогүй, хяналтгүй зарцуулсан
- Гурвантэс сумын ЗДТГ 0.6 сая, Мандал-Овоо сумын ИТХ 0.6 сая төгрөгийн шатахууныг нормоос илүү зарцуулсан, Даланзадгад сумын ЗДТГ 2.6 сая төгрөгийн шатахууны урамшуулал олгосныг бүртгэлд тусгаж, үлдэгдлээр тайлагнаагүй
- Баяндалай сумын ЗДТГ, Ханбогд сумын ИТХ, ЗДТГ, Цогт-Овоо сумын ИТХ, Сэврэй сумын Ойн анги, Ханбогд сумын Хандизель ОНӨААТҮГ, Даланзадгад сумын Зорчигч тээвэр ОНӨААТҮГ, Гүний ус ХХК жилийн эцэст бараа материалын тооллого хийж тооцоо бодоогүй,
- Баяндалай сумын ЗДТГ, Ханхонгор сумын ЗДТГ материалыг тооллогоор баталгаажуулаагүй, үлдэгдлээр тайлагнан эргэлтийн хөрөнгө дутагдах эрсдэл үүсгэсэн
- Номгон сумын Эрхэсгуа ОНӨААТҮГ өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй 42.5 сая төгрөгийн эмийн зарлагын баримт үйлдээгүй, бараа материалын тайлан гаргаагүй, эмийн зарцуулалтад хяналт тавьж ажиллаагүй
- Тавантолгой ХК "Төслийн барилга байгууламж, сэргээгдэх эрчим хүч, хөв цөөрмийн зураг төсөл боловсруулах" ажлын гэрээ дүгнэн санхүүжилтийг бүрэн олгосон боловч зураг төсөв 168.9 сая төгрөгийг бүртгээгүй

**3.5.6 Үндсэн хөрөнгө**

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 684,054.1 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 1,060,049.1 сая төгрөг болж 375,995.0 сая төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт №7 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/ Өсөлт (+), Бууралт (-)
Барилга, байгууламж, орон сууц	233,366.9	356,154.7	122,787.8
Авто-тээврийн хэрэгсэл	27,510.3	28,875.5	1,365.2
Машин тоног төхөөрөмж	39,614.1	66,249.5	26,635.4
Тавилга, аж ахуйн эд хогшил	4,290.4	5,389.7	1,099.3
Зам, гүүрний байгууламж	229,563.6	357,526.5	127,962.9
Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	397.4	397.4	
Бусад үндсэн хөрөнгө	81,342.9	141,132.1	59,789.2
Дуусаагүй барилга, байгууламж	121.5	121.5	
Программ хангамж	611.7	578.5	-33.2
Бусад биет бус хөрөнгө	67,136.6	103,525.0	36,388.4
Бусад эргэлтийн бус хөрөнгө /ТӨҮГ/	98.7	98.7	
<b>Дүн</b>	<b>684,054.1</b>	<b>1,060,049.1</b>	<b>375,995.0</b>

*Эх сурвалж: Өмнөговь аймгийн Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Үндсэн хөрөнгийн 90.1 хувийг биет хөрөнгө, 9.8 хувийг биет бус хөрөнгө эзлэх ба 28.2 хувь нь орон нутгийн өмчит үйлдвэрийн газар, 71.8 хувь нь төсвийн байгууллагын хөрөнгө эзэлж байна.

Тайлант онд худалдан авсан 33,782.9 сая, балансаас баланст шилжүүлсэн 43,990.7 сая, хандиваар, үнэ төлбөргүй хандиваар авсан 370,095.2 сая, шилжүүлэн авсан 1,323.9 сая, шилжүүлэн авсан бүтцийн өөрчлөлтөөр 793.9 сая, дахин үнэлгээний нэмэгдэл 585.3 сая төгрөгийн үндсэн хөрөнгөөр тус тус нэмэгдсэн байна.

Тайлант жилд худалдсан 321.8 сая, балансаас баланст шилжүүлсэн 3,740.2 сая төгрөг, акталсан 2,618.4 сая төгрөг, шилжүүлсэн бүтцийн өөрчлөлтөөр болон бусад шалтгаанаар 18,600.8 сая, дахин үнэлгээний хорогдол 423.3 сая төгрөгийн үндсэн хөрөнгө тус тус хасагдсан байна.

Оны эхэнд хуримтлагдсан элэгдэл 167,371.2 сая төгрөг байсан ба өмнөх оны элэгдлийн зөрүү 287.6 сая, тайлан оны элэгдэл 53,396.3 сая төгрөг нэмэгдэж, 4,811.6 сая төгрөгийн дансны хасалтаар буурч оны эцэст 216,243.5 сая төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй болсон байна.

Дуусаагүй барилга дансанд Мандал-Овоо сумын ЗДТГ-ын Өтгөн багийн өндөр хүчдэлийн 48.9 сая төгрөгийн шугамын ажил, Хүрмэн сумын Эрдэнэсийн буян ОНӨААТҮГ-ын халуун усны 52.6 сая төгрөгийн барилга, Ханбогд сумын 20.0 сая төгрөгийн гүн өрмийн худгийг улсын комисс хүлээн аваагүй шалтгаанаар бүртгэлтэй хэвээр байна.

ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын үндсэн хөрөнгийн данстай холбоотой аудитын илрүүлэлт:

- Баяндалай сумын ИТХ 11.3 сая, Ханхонгор сумын ЗДТГ 11,366.5 сая, Хүрмэн сумын ИТХ 7.5 сая, Цогт-Овоо сумын ИТХ 66.6 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн тооллого хийгээгүй,

- Мандал-Овоо сумын ИТХ, Сэврэй сумын ИТХ, ЗДТГ, Ханбогд сумын ЗДТГ, Цогт-Овоо сумын ЗДТГ, Даланзадгад Зорчигч тээвэр ОНӨААТҮГ тооллогын комисс нь тооллогын дүнг хэлэлцэж баталсан тайлан байхгүй, албан хаагчдын албан хэрэгцээнд эзэмшиж байгаа эд хөрөнгийг нэр төрлөөр ангилан бүртгэж, эд хөрөнгө ашиглалтын гэрээг байгуулаагүй,

- Кокс заг ОНӨААТҮГ эдийн засгийн зорилтод түвшинд тусгагдаагүй 2.8 сая төгрөгийн хөрөнгө худалдаж авсан,

- Баяндалай сумын 140 нэр төрлийн 350 ширхэг, Баян-Овоо сумын ИТХ 9 нэр төрлийн 58 ширхэг, ЗДТГ 63 нэр төрлийн 161 ширхэг, Шугшаа ОНӨААТҮГ 7 нэр төрлийн 7 ширхэг, Сэврэй сумын НҮГ 22 нэр төрлийн 22 ширхэг, Буянтхотхон УТҮГ /Pruis-20/ маркийн автомашин, Ахмадын хороо 10 төрлийн 10 ширхэг, Эрхэсгуа ОНӨААТҮГ 14 нэр төрлийн 14 ширхэг, Тавантолгой ХК 8 нэр төрлийн 375 ширхэг, үндсэн хөрөнгийн дансанд элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгийг дахин үнэлүүлэх саналыг холбогдох байгууллагад хүргүүлээгүй,

- Баяндалай сумын ЗДТГ 4.7 сая төгрөгийн нөтбүүк, 29.7 сая төгрөгийн пургон, 34.5 сая төгрөгийн пургон биетээр байхгүй байна.

### 3.5.7 Өр төлбөр

Өр төлбөрийн эхний үлдэгдэл 636,663.3 сая, эцсийн үлдэгдэл 538,805.8 сая төгрөг болж, өмнөх оноос 169,862.5 сая төгрөгөөр буурсан байна.

*Хүснэгт №8 Нийт өр төлбөрийн үлдэгдэл*

*/сая төгрөг/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн+ Буурсан -	Дүнд эзлэх хувь
Богино хугацаат өр төлбөр дүн	492,431.6	322,569.1	-169,862.5	60%
Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөв	275.4	183.8	-91.6	0.0%
Ажилчидтай холбоотой өглөг	11.2	17.6	6.4	

Өмнөговь аймгийн Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Хөрөнгө бэлтгэхтэй холбогдсон өглөг	116.6	310.9	194.3	0.1%
Зээлийн хүүгийн өглөг	0.0	0.0	0.0	
Бусад өглөг	295,803.8	78,804.8	-216,999.0	14.6%
Урьдчилж орсон орлого	196,224.6	243,252.0	47,027.4	45.1%
Урт хугацаат өр төлбөр дүн	<b>144,231.7</b>	<b>216,236.7</b>	<b>72,005.0</b>	<b>40%</b>
Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөв	8,543.1	7,578.0	-965.1	1%
Хойшлогдсон татварын өр /ТӨҮГ/	135,688.6	208,658.7	72,970.1	39%
Нийт дүн	<b>636,663.3</b>	<b>538,805.8</b>	<b>-97,857.6</b>	<b>100%</b>

*Эх сурвалж: Өмнөговь аймгийн Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Богино хугацаат өр төлбөрийн 42,338.8 сая төгрөг буюу 7.8 хувийг төсөл сан буюу хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний гүйцэтгэлийн баталгааны барьцаа, 489,730.7 сая төгрөг буюу 90.9 хувийг ОНӨААТҮГ болон ОНӨҮГ-ууд эзэлж байна.

Богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэлд 274,097.6 сая төгрөг буюу 84.9 хувийг Таван толгой ХК-ийн өглөг эзэлж байна.

Азийн хөгжлийн банкны нийтийн аж ахуйн 1,102.2 сая төгрөгийн төсөл тус аймагт 2004 онд хэрэгжин “Гүний ус” ХХК-ийн төлөх богино хугацаат зээлийн үлдэгдэлд 714.9 сая төгрөгөөр бүртгэлтэй байна.

Урт хугацаат өр төлбөрийн үлдэгдэлд ОНӨААТҮГ-удын хойшлогдсон өр төлбөр 208,658.7 сая төгрөг, гадаад зээлээс дамжуулан зээлдүүлсэн 7,578.0 сая төгрөгийн /Зүүн өмнөд говийн бүсийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн төсөл хүрээнд тус аймагт цэвэрлэх байгууламж барих ажил/ өр төлбөр бүртгэлтэй байна.

ТЕЗ-ийн харьяа аж ахуйн нэгж, байгууллагуудын өр төлбөр данстай холбоотой аудитын илрүүлэлт:

- Баяндалай сумын ЗДТГ-ын 110.1 сая, Ханхонгор сумын ЗДТГ-ын 24.3 сая, Ханбогд сумын ОНХС-ийн 291.2 сая, Гурвантэс Хөгшөө ОНӨААТҮГ-ын 33.6 сая, Даланзадгад зорчигч тээвэр ОНӨААТҮГ-ын 57.6 сая, Манлай сумын ЗДТГ-ын 37.6 сая, Ноён Ингэн нүд ОНӨААТҮГ-ын 27.4 сая, Хүрмэн Жанжинговь ОНӨААТҮГ-ын 28.8 сая төгрөг, “Гүний ус” ХХК-ийн санхүүгийн тайланд тусгасан 1,387.0 сая төгрөг, Тавантолгой ХК-ийн санхүүгийн тайланд тусгасан дансны өглөгийн үлдэгдэл 274,097.6 сая төгрөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.

### 3.5.8 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 1,326,885.2 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 1,735,566.9 сая төгрөг болж 411,681.7 сая төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт №8 Засгийн газрын хувь оролцоо*

*/сая төгрөг/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт/+, бууралт -/	Дүнд эзлэх хувь
Засгийн газрын оруулсан капитал	113,612.8	110,505.4	-3,107.4	6.4
Өмч /төрийн/ /ТӨҮГ/	6,469.5	10,301.7	3,832.2	0.6
Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/	1,362.9	1,443.1	80.2	0.1
Хуримтлагдсан үр дүн	<b>1,194,619.7</b>	<b>1,605,496.4</b>	410,876.7	<b>92.9</b>
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	10,820.3	10,820.3	0	0
<b>Дүн</b>	<b>1,326,885.2</b>	<b>1,738,566.9</b>	<b>411,681.7</b>	<b>100.0</b>

*Эх сурвалж: Өмнөговь аймгийн Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 1,738,566.9 сая төгрөг болж 411,681.7 сая төгрөгөөр өссөн нь тайлант оны үйл ажиллагааны үр дүнгээс шалтгаалжээ. Үүнд:

- Хуримтлагдсан үр дүн 1,605,390.0 сая төгрөг болж 410,876.7 сая төгрөгөөр өссөн нь тайлант оны үйл ажиллагааны үр дүнгээс шалтгаалсан байна.

### 3.5.9 Орлогын данс

Өмнөговь аймгийн ИТХ-ын 2024 оны 19/28 дугаар тогтоол болон сумдын ИТХ-ын “2024 оны төсвийн тодотгол батлах тухай” тогтоолоор аймгийн төсөвт 2,081,354.4 сая төгрөгийн орлого төвлөрүүлэхээр баталж, гүйцэтгэлээр 1,879,083.5 сая төгрөгийн орлого төвлөрүүлэн батлагдсан төлөвлөгөөг 90.3 хувиар биелүүлсэн байна.

Аймгийн төсвийн орлогод төвлөрүүлсэн орлогын гүйцэтгэлийг татварын нэр төрлөөр авч үзвэл дараах байдалтай байна.

*Хүснэгт №10 Аймгийн төсвийн орлогын гүйцэтгэл*

*/сая*

Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	2024 оны		
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
Б	1	2	3	4=3-2
НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	1,085,786.0	2,081,354.4	1,879,083.5	(202,270.9)
ТАТВАРЫН ОРЛОГО	894,599.0	1,864,802.1	1,647,808.0	(216,994.1)
Орлогын албан татвар	664,777.4	1,603,054.8	1,394,468.3	(208,586.4)
Хувь хүний орлогын албан татвар	211,130.3	228,542.5	235,246.4	6,703.9
Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрх	181,988.9	213,282.7	215,185.3	1,902.6
Үйл ажиллагааны орлого	1,887.8	2,045.1	1,932.4	(112.7)
Хөрөнгийн орлого	1,684.8	1,810.5	2,451.8	641.3
Хөрөнгө борлуулсны орлого	179.7	1,043.8	1,124.3	80.5
Шууд бус орлого	25,389.1	10,360.4	14,461.5	4,101.1
Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(1,663.5)	(2,137.8)	(2,139.0)	(1.2)
Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(1,663.5)	(2,137.8)	(2,139.0)	(1.2)
ААН-ын орлогын албан татвар	455,310.6	1,376,650.1	1,161,360.9	(215,289.1)
ААН-ын орлогын албан татвар	455,310.6	1,376,650.1	1,161,360.9	(215,289.1)
Хөрөнгийн албан татвар	173,906.7	215,125.5	204,426.3	(10,699.2)
Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	162,013.3	202,633.6	191,426.1	(11,207.5)
Бууны албан татвар	48.8	42.0	47.5	5.5
Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар	11,008.5	11,600.0	12,283.0	683.0
Малд ногдуулах албан татвар	836.0	849.9	669.7	(180.2)
Бусад татвар, төлбөр, хураамж	107,304.8	-	-	-
Бусад нийтлэг төлбөр, хураамж	3,770.3	3,156.8	3,567.8	411.0
Улсын тэмдэгтийн хураамж	786.7	934.4	1,332.6	398.2
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	2,363.8	1,747.7	1,613.5	(134.1)
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	619.7	474.7	621.7	147.0
Газрын төлбөр	17,307.4	14,357.5	15,249.8	892.3
Газрын төлбөр	13,203.9	14,007.5	14,599.8	592.3
Дуудлага худалдаа	4,103.5	350.0	650.0	300.0
Байгалийн нөөц ашигласны төлбөр	34,459.9	28,807.5	29,790.4	982.9
Ан амьтны нөөц ашигласны төлбөр	731.1	763.2	563.3	(200.0)
Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	33,728.8	28,044.3	29,227.2	1,182.9

Өмнөговь аймгийн Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Бусад татвар	377.4	300.0	396.4	96.4
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	158,318.7	163,111.3	182,541.1	19,429.8
Хувьцааны ногдол ашиг	148,555.9	134,189.0	150,304.6	16,115.6
Торгуулийн орлого	4,800.4	17,037.9	19,654.1	2,616.2
Төсөв байгууллагын өөрийн орлого	3,502.4	10,362.5	6,258.2	(4,104.2)
Газрын тосны орлого	-	102.3	99.3	(3.0)
Түрээсийн орлого	116.1	90.4	134.0	43.6
Бусад орлого	1,344.0	1,329.2	6,090.7	4,761.5
ХӨРӨНГИЙН ОРЛОГО	606.1	175.0	208.6	33.6
Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй хөрөнгө борлуулсны орлого	606.1	175.0	208.6	33.6
ХАНДИВ ТУСЛАМЖИЙН ОРЛОГО	4,000.0	5,550.0	2,500.0	(3,050.0)
Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	4,000.0	5,550.0	2,500.0	(3,050.0)
Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	28,262.2	47,716.0	46,025.8	(1,690.2)
Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого	28,262.2	47,716.0	46,025.8	(1,690.2)

Эх сурвалж: Өмнөговь аймгийн Төсвийн Ерөнхийлөн захираагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Төсвийн нийт орлогыг өмнөх оны гүйцэтгэлээс 91.7 хувиар буюу 995,568.4 сая төгрөгөөр нэмэгдүүлэн төлөвлөсөн нь тооцоо судалгаанд үндэслэгдсэн эсэх нь тодорхойлогдохгүй, хэт өөдрөг, орлогын төлөвлөгөө биелэхгүй байх эрсдлийг үүсгэсэн байна.

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулиар орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон улсын төсвөөс Орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлгийг 47,716.0 сая төгрөг байхаар баталсан байна.

Өмнөговь аймгийн ИТХ-ын 2024 оны 19/28 дүгээр тогтоол болон сумдын ИТХ-ын “2024 оны төсвийн тодотгол батлах тухай” тогтоолоор аймгийн төсөвт 2,081,354.4 сая төгрөгийн орлого төвлөрүүлэхээр баталж, гүйцэтгэлээр 1,879,083.5 сая төгрөгийн орлого төвлөрүүлэн батлагдсан төлөвлөгөөг 90.3 хувиар биелүүлсэн байна.

Татварын орлогын талаар:

Орон нутгийн төсвийн суурь орлогыг Сангийн яамнаас 1,549,273.8 сая төгрөгөөр хянасан байна. Үүнээс аж ахуй нэгжийн орлогын албан татварын суурь орлогыг 1,020,000.0 сая төгрөг байхаар хянаж, улсын төсөвт төвлөрүүлэх шилжүүлгийг өмнөх оноос 3.1 дахин өсгөж 1,419,975.6 сая төгрөгөөр тооцож Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулиар баталсан байна.

Аймгийн ИТХ-аас орон нутгийн чиг үүргийг хэрэгжүүлэх төсвийн эх үүсвэр бүрдүүлэхийн тулд сангийн яам хянасан аж ахуй нэгжийн орлогын албан татварын 40 хувийн орлогын дүнг 356,650.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан байна.

Татварын бус орлогын талаар:

Орон нутгийн "Тавантолгой" хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 2 дугаар сарын 21-ний өдрийн 03 тоот тогтоолоор нэгж хувьцаанд ногдох ашгийг 4996 төгрөгөөр тогтоон орон нутгийн эзэмшлийн хувьцааны 51 хувьд 150,304.6 сая төгрөгийн ногдол ашиг хуваарилсан байна.

Энэ нь Тавантолгой ХК-ны гадаад, дотоод борлуулалтын үйл ажиллагаатай холбоотойгоор борлуулалтын орлого өссөнтэй холбоотой байна.

Төсөвт байгууллагын өөрийн орлогыг 39.6 хувиар буюу 4,104.2 сая төгрөгөөр тасалсан байна. Үүний 98.3 хувийг орон нутгийн хөрөнгө оруулалт дансны авлагын үлдэгдэл буюу Өмнөговь аймгийн хэмжээнд 1000 айл орон сууц хөтөлбөрийн хүрээнд 2015 онд аж ахуй нэгж, иргэдэд олгосон зээлийн санхүүжилтийн авлагын үлдэгдэл байна.

Уг зээлийг холбогдох аж ахуй нэгжээр төлүүлэхээр Өмнөговь аймаг дахь Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн захирамж 2017, 2018, 2019 онуудад гарсан боловч одоог хүртэл шийдвэрлэгдээгүй байна.

Төрийн аудитын байгууллагаас уг авлагыг төлүүлж, төсвийн орлого бүрдүүлж ажиллах талаар удаа дараа аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчид зөвлөмж, албан шаардлага өгч ажилласан ч тодорхой үр дүнд хүрээгүй байна.

#### Тусламж санхүүжилтийн орлогын талаар:

Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 3.1.3 "ОНХС-ийн орлогын шилжүүлгийг тус санг бүрдүүлдэг эх үүсвэрүүдийн орлогын гүйцэтгэлд үндэслэн шилжүүлэх" гэж заасан итгэлцүүрийн дагуу ОНХС-ийн санхүүжилтийг тооцсон байна.

Орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлгээр 46,035.8 сая төгрөг олгож, Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд зааснаас 1,680.2 сая төгрөгийн санхүүжилт дутуу олгосон байна.

Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2.9<sup>1</sup>-д заасны дагуу Орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрт 5,550.0 сая төгрөг төлөвлөснөөс Эрдэнэс тавантолгой ТӨХК-ийн хандивын орлого 2,500.0 сая төгрөг төвлөрсөн байна.

Эрдэнэс тавантолгой ТӨХК нь байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх, хандив, тусламж өгөх асуудлаар нутгийн захиргааны байгууллагатай гэрээ байгуулж ажилласан байна.

Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1<sup>2</sup> дэх заалтын хэрэгжилтийг хангуулснаар ОНХС-ийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх боломжтой байна.

Аймгийн төсвийн нийт орлого 1,879,083.5 сая төгрөг болж өмнөх оноос 1.7 дахин өссөн нь аж ахуйн нэгжийн орлогын дахин хуваарилалттай холбоотой байна.

#### **3.5.10 Зардлын данс**

Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагуудаас зардлын данстай холбоотой төсвийг үр ашиггүй зориулалт бусаар зарцуулсан, ур чадварын нэмэгдлийг шалгуур үзүүлэлтгүй олгосон, цалин болон албан томилолтыг давхардуулан болон илүү олгосон, төрийн сангийн төлбөр тооцооны хяналт сул байгаагаас эдийн засгийн ангилал зөрчсөн зэрэг дараах зөрчлүүд илэрсэн. Тухайлбал:

- Баяндалай сумын ЗДТГ 2.3 сая, Ханхонгор сумын ЗДТГ 2.2 сая, Хаанмандал ОНӨААТҮГ 1.6 сая, Цитоговь ОНӨААТҮГ 1.1 сая төгрөгийн цалинг давхардуулан, Даланзадгад сумын ЗДТГ 7.7 сая төгрөгийн цалинг илүү тооцож олгосон,

- Булган сумын ИТХ 2.4 сая, ЗДТГ 7.6 сая төгрөгийн түлээ нүүрсний хөнгөлөлт, аймгийн ИТХ 2.0 сая, БОАЖГ 1.5 сая төгрөг, Цогт-Овоо сумын ЗДТГ 4.0 сая төгрөгийн урамшууллыг цалингийн сангаас олгосон,

- Гурвантэс сумын ЗДТГ 46.4 сая төгрөгийг бүтэц орон тоонд батлагдаагүй 3 албан тушаалтныг цалинжуулсан,

<sup>1</sup> Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлд заасан гэрээний дагуу тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нутгийн захиргааны байгууллагад өгсөн хандив, тусламж

<sup>2</sup> Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх, хандив, тусламж өгөх асуудлаар нутгийн захиргааны байгууллагатай гэрээ байгуулж ажиллана.

Өмнөговь аймгийн Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

- Гурвантэс сумын ЗДТГ шалгуур үзүүлэлтгүйгээр 6 албан албан тушаалтанд 16.5 сая төгрөгийн ур чадварын нэмэгдэл олгосон,

- Тавантолгой ХК 1,310.1 сая төгрөгийн илүү цагийн ажлын хөлс тооцож олгохдоо дундаж цалин хөлснөөс тооцоогүй олгосон,

- Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба 6.3 сая төгрөгийн цалинг эрх бүхий албан тушаалтны шийдвэргүйгээр олгосон,

- Хүрмэн ЗДТГ 17.7 сая нэг удаагийн тэтгэмж урамшууллаас ботгоны урамшуулал, шагнал олгосон, Даланзадгад сумын ИТХ 56.0 сая төгрөгөөр гадаад туршлага судлахад зарцуулсан,

- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлаас Гурвантэс сумын ЗДТГ сумын цагдаагийн тасагт 4.1 сая, Ханбогд сумын ЗДТГ 26.4 сая төгрөгийн шатахуун, 5.3 сая төгрөгийг дууны тэмцээний шагнал, 2.7 сая төгрөгийг сургалтын төлбөрт олгосон, Ноён сумын ИТХ 3.6 сая төгрөгийн медаль, өргөмжлөл, хулдаасан хэвлэл худалдан авсан,

- Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас Мандал-Овоо сумын ЗДТГ төсөл сонгон шалгаруулалт зарлаагүй, шийдвэргүйгээр "Баян гурван мандал" нөхөрлөлд 52.0 сая төгрөг шилжүүлсэн,

- Гурвантэс сумын Засаг дарга хөтөлбөр, журмаар зохицуулаагүй арга хэмжээнд 572.1 сая төгрөг зарцуулсан,

- Засаг даргын нөөц хөрөнгөөс Мандал-Овоо сумын Засаг дарга 20.0 сая төгрөг, Даланзадгад сумын Засаг дарга 52.0 сая төгрөгийг урсгал засвар үйлчилгээний зардалд зарцуулсан байна.

### **3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга**

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахдаа энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **Аймгийн төсвийн орлогын төлөвлөлт, гүйцэтгэлийн талаар**

Ерөнхийлөн захирагчийн 2024 оны төсвийг Төсвийн тухай хуулийн 57.<sup>3</sup>, 58 дугаар зүйлийн 58.<sup>4</sup>, Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар баталсан "Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах" журам, аймгийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, өмнөх оны гүйцэтгэл болон Төсвийн тухай хууль, татварын хууль тогтоомжийн хүрээнд тус тус төлөвлөжээ.

Орон нутгийн төсвийн суурь орлогыг Сангийн яамнаас 1,549,273.8 сая төгрөгөөр хянасныг Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35.1.9<sup>5</sup>-д заасан бүрэн эрхийн хүрээнд Өмнөговь аймгийн ИТХ-ын 2023 оны 15/11 дугаар "2024 төсөв батлах тухай" тогтоол, сумдын ИТХ-ын тогтоолоор 1,561,976.2 сая төгрөг болгон нэмэгдүүлэн баталсан байна.

Тайлант хугацаанд Төсвийн тухай хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1.2<sup>6</sup>-д заасны дагуу Өмнөговь аймгийн ИТХ-ын 2024 оны 19/28 дугаар "2024 оны төсвийн тодотгол батлах тухай" тогтоолоор ХХОАТ-ыг 9,999.4 сая, ААНОАТ-ыг 438,579.3 сая, ҮХЭХАТ-ыг 31,802.6 сая,

<sup>3</sup> Орон нутгийн төсөв

<sup>4</sup> Орон нутгийн чиг үүргийг санхүүжүүлэх

<sup>5</sup> Засаг даргын өргөн мэдүүлснээр тухайн аймаг, сум, нийслэл, дүүргийн төсвийг хэлэлцэж батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах, гүйцэтгэлийг батлах

<sup>6</sup> тухайн жилийн төсөв, түүний тодотголын төслийг хэлэлцэн батлах, хэрэгжилтэд хяналт тавих, нийтэд мэдээлэх

Өмнөговь аймгийн Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

АТБӨЯХАТ-ыг 600.0 сая, татварын бус орлогыг 40,575.1 сая, ОНХС-ийн шилжүүлсэн орлогыг 2,131.0 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлэн зарим орлогыг бууруулан аймаг, сумдын нийт төсвийн орлогыг 2,081,354.4 сая төгрөг байхаар тодотгон баталсан байна.

Аймаг, сумдын ИТХ-аар баталсан 2024 оны төсвийн орлогын төлөвлөлт дараах байдалтай байна.

*Хүснэгт №11 Аймгийн нийт орлогын төлөвлөлт /сая төгрөг/*

Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	2024 он		
		Сангийн яам хянасан дүн	Анх батлагдсан	Тодотгосон төсөв
Б	1	2	3	4
<b>НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН</b>	1,085,786.0	1,549,273.8	1,561,976.2	2,081,354.4
<b>УРСГАЛ ОРЛОГО</b>	1,052,917.7	1,549,203.8	1,515,986.2	2,027,913.4
<b>Татварын орлого</b>	894,599.0	1,410,692.8	1,385,998.9	1,864,802.1
<b>Татварын бус орлого</b>	158,318.7	138,511.0	129,987.3	163,111.3
<b>ТУСЛАМЖИЙН ОРЛОГО</b>	4,000.0	-	-	5,550.0
<b>ШИЛЖИХ ҮЛДЭГДЭЛ</b>	28,262.2	-	45,585.0	47,716.0

*Эх сурвалж: Өмнөговь аймгийн Төсвийн Ерөнхийлөн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулиар орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон улсын төсвөөс Орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлгийг 47,716.0 сая төгрөг байхаар баталсан байна.

Өмнөговь аймгийн ИТХ-ын 2024 оны 19/28 дүгээр тогтоол болон сумдын ИТХ-ын “2024 оны төсвийн тодотгол батлах тухай” тогтоолоор аймгийн төсөвт 2,081,354.4 сая төгрөгийн орлого төвлөрүүлэхээр баталж, гүйцэтгэлээр 1,879,083.5 сая төгрөгийн орлого төвлөрүүлэн батлагдсан төлөвлөгөөг 90.3 хувиар биелүүлсэн байна.

*Хүснэгт №12 Аймгийн төсвийн орлогын гүйцэтгэл /сая төгрөг/*

Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны			
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Б	1	2	3	4=3-2	5=3/2
<b>НИЙТ ОРЛОГО</b>	1,085,786.0	2,081,354.4	1,879,083.5	-202,270.8	90.3
<b>А. Төсвийн орлого</b>	1,052,917.7	2,027,913.4	1,832,849.1	-195,064.3	90.4
<b>I.Татварын орлого</b>	894,599.0	1,864,802.1	1,647,808.0	-216,994.0	88.4
<b>II. Татварын бус орлого</b>	158,318.7	163,111.3	182,541.1	19,429.8	111.9
<b>Б. Хөрөнгийн орлого</b>	606.1	175.0	208.6	33.6	119.2
<b>В. Тусламж, санхүүжилтийн орлого</b>	32,262.2	53,266.0	48,525.8	-4,740.2	91.1

*Эх сурвалж: Өмнөговь аймгийн Төсвийн Ерөнхийлөн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Дээрх хүснэгтээс харахад аймгийн төсвийн нийт орлого өмнөх оноос 1.73 дахин өссөн ч татварын орлого 216,994.0 сая, тусламж санхүүжилтийн орлого 4,740.2 сая төгрөгөөр тус тус тасарсан байна.

Аймгийн нийт орлогын дүнд татварын орлого 87.7 хувь, татварын бус орлого 9.7 хувь, хөрөнгийн орлого 0.01 хувь, тусламж санхүүжилтийн орлого 2.6 хувийг тус тус эзэлж байна.

Тайлант онд аймгийн ИТХ-аас Татварын ерөнхий хуулийн 8 дугаар зүйлийн 8.1<sup>7</sup>, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35.1.10<sup>8</sup>-д

<sup>7</sup> Татварын хувь, хэмжээг Улсын Их Хурал, түүний эрх олгосноор Засгийн газар болон аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, хотын Зөвлөл хууль тогтоомжийн дагуу тус тус тогтооно.

<sup>8</sup> хуулиар тогтоосон хязгаарын хүрээнд албан татвар, төлбөр, хураамжийн хувь хэмжээг тогтоох

заасан бүрэн эрхийн хүрээнд орон нутагт мөрдөгдөж буй төлбөр, хураамжид өөрчлөлт оруулаагүй байна.

Аймаг орон нутгийн зүгээс төсвийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах, орон нутгийн төсөв бүрдүүлэх, татварын бааз суурийг өргөжүүлэх, төсвийн орлогын төлөвлөгөөг биелүүлэх зорилгын хүрээнд олон талын арга хэмжээг зохион байгуулж ажилласан байна.

### Төсвийн төлөвлөлт

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35.1.9<sup>9</sup>-д гэж заасны дагуу хурлын бүрэн эрхийн хэмжээнд Сангийн яамнаас хянасан суурь зарлагыг Өмнөговь аймгийн ИТХ-ын 2023 оны 15/11 дугаар “2024 оны төсөв батлах тухай” тогтоол болон сумдын ИТХ-ын тогтоолоор төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны төсвийн нийт зарлагыг 377,614.9 сая төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан байна.

Тайлант онд төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлэх 109 хөтөлбөрт зориулан 2,296,856.3 сая төгрөг, үүнээс 1,709,099.1 сая төгрөгийг урсгал зардалд, 587,757.2 сая төгрөгийг хөрөнгийн зардалд зарцуулахаар баталсан байна.

Нийт зардлын 47,716.0 сая төгрөгийг улсын төсвөөс, 2,221,375.6 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 10,362.5 сая төгрөгийг төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогоос, 5,550.0 сая төгрөгийг тусламжийн эх үүсвэрээс, 11,852.2 сая төгрөгийг бусад эх үүсвэрээс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Оны эцэст Төсвийн тухай хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1.2<sup>10</sup>-д заасны дагуу Өмнөговь аймгийн ИТХ-ын 2024 оны 19/28 дугаар “2024 оны төсвийн тодотгол батлах тухай” тогтоол болон сумдын тодотгосон төсвийн тогтоолоор аймгийн нийт зарлагыг 423,208.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 2,296,856.3 сая төгрөгөөр тодотгон баталсан байна.

### Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр 26,262.2 сая төгрөгийг улсын төсвөөс, 863,797.7 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогоос 7,502.4 сая төгрөг нийт 899,562.3 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Төсөвт байгууллагын үйл ажиллагаа буюу үндсэн болон туслах үйл ажиллагаанаас 7,502.4 сая төгрөг бүрдүүлж, батлагдсанаас 13,442.7 сая төгрөгөөр тасарсан байна.

Хүснэгт №13. Төсвийн гүйцэтгэл

/сая төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны төлөвлөгөө	Тайлант оны гүйцэтгэл	Зөрүү +/-
<b>Б</b>	<b>1</b>	<b>2</b>	<b>3</b>	<b>4=3-2</b>
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	886,269.5	2,296,856.3	1,904,419.0	392,437.3
УРСГАЛ ЗАРДАЛ	650,374.1	1,709,099.1	1,459,311.9	249,787.2
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	158,247.1	219,577.5	170,374.4	49,203.0
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	17,522.5	29,968.5	27,201.4	2,767.1
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,208.2	3,761.3	3,392.5	368.8
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	10,036.1	17,188.4	15,038.3	2,150.1
Хангамж, бараа материалын зардал	2,959.4	3,901.8	3,383.1	518.7
Нормативт зардал	234.1	391.0	314.6	76.4
Эд хогшил, урсгал засварын зардал	2,597.0	4,480.7	3,607.3	873.5
Томиллолт, зочны зардал	319.7	571.4	461.6	109.7

<sup>9</sup> Засаг даргын өргөн мэдүүлснээр тухайн аймаг, сум, нийслэл, дүүргийн төсвийг хэлэлцэж батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах, гүйцэтгэлийг батлах;

<sup>10</sup> тухайн жилийн төсөв, түүний тодотголын төслийг хэлэлцэн батлах, хэрэгжилтэд хяналт тавих, нийтэд мэдээлэх

Өмнөговь аймгийн Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	22,188.2	37,761.0	25,348.3	12,412.7
Бараа үйлчилгээний бусад зардал	100,181.9	121,553.4	91,627.3	29,926.1
ТАТААС	154.0	144.0	119.0	25.0
Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	154.0	144.0	119.0	25.0
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	491,972.9	1,489,377.6	1,288,818.4	200,559.2
Засгийн газрын урсгал шилжүүлэг	491,012.0	1,486,442.6	1,286,303.6	200,139.1
Бусад урсгал шилжүүлэг	960.9	2,935.0	2,514.8	420.2
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	235,895.5	587,757.2	445,107.1	142,650.1
<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>899,562.3</b>	<b>2,296,856.3</b>	<b>1,926,045.4</b>	<b>370,810.9</b>
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	28,262.2	47,716.0	46,025.8	1,690.2
Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	28,262.2	47,716.0	46,025.8	1,690.2
<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>863,797.7</b>	<b>2,221,375.6</b>	<b>1,871,261.2</b>	<b>350,114.4</b>
Орон нутгийн төсвөөс	863,797.7	2,221,375.6	1,871,261.2	350,114.4
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	3,502.4	10,362.5	6,258.4	4,104.0
ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ	4,000.0	5,550.0	2,500.0	3,050.0
БУСАД ЭХ ҮҮСВЭР / шилжих үлдэгдэл/	-	11,852.2	-	11,852.2
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл			22,336.9	
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл			43,963.4	

*Эх сурвалж: Өмнөговь аймгийн Төсвийн Ерөнхийлөн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,904,419.0 сая төгрөг буюу 82.9 хувьтай байгаагийн дотор урсгал зардлын гүйцэтгэл 85.4 хувьтай, хөрөнгийн зардлын гүйцэтгэл 75.7 хувьтай байна.

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн дагуу улсын төсөвт 1,249,676.3 сая төгрөгийг орлого төвлөрүүлсэн байна.

Хөрөнгө оруулалтын 182 төсөл, арга хэмжээнд 373,610.4 сая төгрөгийн санхүүжилт батлагдсанаас гүйцэтгэлээр 235,895.5 сая төгрөгийн санхүүжилт олгож, 137,714.9 сая төгрөгөөр хэмнэсэн байна.

### Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2 “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна”-д заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламжаар 505.0 сая төгрөг, Засаг даргын нөөц хөрөнгөөс 47,221.3 сая төгрөг, дээд шатны төсвийн захирагчаас 1,097.3 сая төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 3,845.2 сая төгрөг нийт 52,668.8 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

*Хүснэгт №14. Нэмэлт төсвийн гүйцэтгэл*

*/сая төгрөг/*

№	Сумдын нэр	Өмнөх оны гүйцэтгэл	2024 он		
			Санхүүжилт	Зарцуулалт	эхний үлдэгдлээс зарцуулсан
А	Б	1	2	3	4
1	Баяндалай	355.6	195.9	195.9	-
2	Баян-Овоо	211.9	256.1	256.1	-
3	Булган	1,032.3	9,031.9	9,031.9	-
4	Гурвантэс	725.3	7,118.3	7,118.3	-
5	Мандал-Овоо	2,507.0	460.6	460.6	-
6	Манлай	916.2	2,387.5	2,387.5	-

7	Номгон	1,529.0	4,711.2	4,711.2	-
8	Ноён	3,523.4	4,665.7	4,665.7	-
9	Сэврэй	2,979.4	8,021.1	8,021.1	-
10	Ханбогд	658.8	657.9	657.9	-
11	Ханхонгор	630.2	2,788.4	2,788.4	-
12	Хүрмэн	536.6	208.9	208.9	-
13	Цогт-Овоо	1,212.9	2,433.9	2,433.9	-
14	Цогтцэций	478.2	1,085.2	1,085.2	-
15	Даланзадгад	1,270.0	1,682.7	1,682.7	-
16	Аймгийн төвийн төсвийн байгууллагууд	3,688.9	6,963.5	6,963.5	-
<b>ДҮН</b>		<b>12,556.5</b>	<b>52,668.8</b>	<b>52,668.8</b>	

Эх сурвалж: Өмнөговь аймгийн Төсвийн Ерөнхийлөн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нэмэлт санхүүжилтийн 68.5 хувийг буюу 15,267.7 сая төгрөгийг бараа үйлчилгээний зардал буюу ОНТХО, ОНХС-ийн эрх шилжсэн төсөл арга хэмжээний санхүүжилт байна.

### 3.7. Бусад хууль тогтоомжийн хүрээнд

#### 3.7.1. Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Төсвийн ерөнхийлөн захирагч Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 44 дугаар зүйлийн 44.4<sup>11</sup>-т заасны дагуу улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2024 онд хэрэгжүүлэх 411 төсөл арга хэмжээний жагсаалт, төлөвлөгөөг баталгаажуулан цахим системд нийтэлсэн байна.

Аймгийн худалдан авах ажиллагааны газраас худалдан авах ажиллагааг цахим системээр нээлттэй тендер шалгаруулалтын аргаар 335, харьцуулалтын аргаар 76 зохион байгуулсан.

Зохион байгуулсан 411 төсөл, арга хэмжээнээс 327 төсөл, арга хэмжээ амжилттай, 87 төсөл, арга хэмжээ амжилтгүй болсон байна.

Тайлант хугацаанд зохион байгуулагдсан /21/ худалдан авах ажиллагааны талаар Сангийн яаманд гаргасан нийт гомдол үндэслэлийн 33.3 хувь буюу 7 үндэслэлийг захиалагчийн шийдвэр үндэслэлгүй гэж дүгнэсэн байна.

Тайлант онд 312.0 сая төгрөгийн худалдан авалтыг ерөнхий гэрээний аргаар буюу цахим дэлгүүрээс захиалагч байгууллагын ирүүлсэн техникийн тодорхойлолтын дагуу сонгон шалгаруулалтыг зохион байгуулан шалгарсан оролцогчийн гэрээг захиалагч байгууллагад шилжүүлэн ажилласан байна.

ТЕЗ-ийн харьяа байгууллагуудад худалдан авах ажиллагаатай холбоотой 29,654.9 сая төгрөгийн 33 зөрчил илэрснээс 1,036.5 сая төгрөгийн зөрчилд 20 албан шаардлага, 28,618.1 сая төгрөгийн зөрчилд 13 зөвлөмж тус тус хүргүүлсэн байна.

#### Аудитаар илэрсэн зөрчлийг дурдвал:

- Булган, Номгон сумын Засаг дарга, Даланзадгад сумын Захирагчийн ажлын алба нь тайланд онд худалдан авах ажиллагааны төлөвлөгөө гаргаагүй худалдан авах ажиллагаа зохион байгуулсан, хэрэгжилтийг тайлагнаагүй,

- Гурвантэс, Цогт-Овоо сумын ЗДТГ, аймгийн ЗДТГ, Нийтлэг үйлчилгээний газар, Байгаль орчин аялал, жуулчлалын газар, Орон нутгийн өмчийн газар, Буянтхотхон УТҮГ, Сэврэй Дэмд-од, Хүрмэн Жанжинговь, Даланзадгад Дулаан хангамжийн газар ОНӨААТҮГ зэрэг байгууллагууд нь шууд худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн

<sup>11</sup> Төсвийн ерөнхийлөн захирагч тухайн жилийн санхүүжилтийн эх үүсвэр батлагдсанаас хойш нэг сарын дотор харьяа захиалагчийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг нэгтгэн хянаж, баталгаажуулан цахим системд нийтэлнэ.

дээд хязгаараас давсан бараа, ажил, үйлчилгээнд худалдан авах ажиллагааг зохион байгуулаагүй, шууд худалдан авалт хийсэн,

- Аймгийн ИТХ, Цогт-Овоо сумын Ойн анги, Ноён сумын ОНХС нь батлагдсан төсөвт өртгийг хувааж, шууд худалдан авалт хийсэн,

- Гурвантэс сумын ИТХ, ЗДТГ, Манлай, Ханхонгор сумын ЗДТГ, Гурвантэс сумын ОНХС, ХХС, бусад сан, Хүрмэн сумын ОНХС, Тавантолгой ХК тендер шалгаруулалтын үр дүнд байгуулсан гэрээ, гэрээний хэрэгжилт хангуулж ажиллаагүй,

- Гүний ус ХХК нь Хятад Улсаас 4 удаа 142.4 сая төгрөгийн шууд худалдан авалт хийсэн,

- Тавантолгой ХК "Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тодотгосон төлөвлөгөө"-г ТУЗ батлуулж, гүйцэтгэх захирлын тушаалаар батлаагүй, худалдан авах ажиллагааны тайланд шууд гэрээ байгуулсан бараа, ажил, үйлчилгээг тайлагнаагүй, 87.6 сая төгрөгийн засварын ажлыг худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаагүй шууд худалдан авалт хийсэн,

- Мөн хөрс хуулалт, нүүрс олборлолтын ажил /багцтай/-ын нээлттэй тендер шалгаруулалтыг 2024 оны 04 дүгээр сарын 03-ны өдөр зарласан байхад, 2024 оны 05 дугаар сарын 03-ны өдөр нэмэлт гэрээ байгуулж, гэрээний төлбөрт 26,845.7 сая төгрөг шилжүүлсэн,

- Түлш, шатахуун худалдан авах ТТХК/20240102014 дугаартай 1 дүгээр багц ажлын тендерийг хуулийн хугацаанд үнэлж, шийдвэр гаргалгүй, 2023 оны №ТТХК/202301005 дугаартай "Сод монгол групп" ХХК-тай байгуулсан гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулж, гэрээний төлбөрт 1,291.1 сая төгрөг шилжүүлсэн байна.

### 3. 7.2.Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тухайн байгууллагад хамаарал бүхий заалтуудын хүрээнд нягтлан шалгав.

Хүснэгт№15 Төрийн хэмнэлтийн тухай хуультай холбоотой илрүүлэлт /сая төгрөг/

Зөрчлийн ангилал	2023 оны зөрчлийн		2024 оны зөрчлийн		Зөрүү +/-	
	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн
Төлбөрийн акт	27	36.2	16	34.0	11	2.2
Албан шаардлага	40	1,003.6	33	732.0	7	271.6
Зөвлөмж	28	254.3	14	538.4	14	-284.1
Хариуцлага тооцох албан шаардлага	1	-	1	-	0	-
<b>Нийт дүн</b>	<b>96</b>	<b>1,294.1</b>	<b>64</b>	<b>1,304.4</b>	<b>32</b>	<b>-10.3</b>

Эх сурвалж: Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газар

ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 1,304.4 мянган төгрөгийн зөрчил илэрсэн нь өмнөх оноос 0.8 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

#### Аудитаар илэрсэн зөрчлийг дурдвал:

- Аймгийн ИТХ 75.7 сая, Ханбогд сумын Засаг дарга 100.0 сая, Цогт-Овоо сумын Засаг дарга 19.5 сая төгрөгийн контент, видео нэвтрүүлэг бэлтгэсэн,

- Даланзадгад сумын ИТХ 21.1 сая, Гурвантэс сумын ОНХС-аас 279.4 сая, хөрөнгө оруулалтаас 140.3 сая, Хүрмэн сумын ОНХС 19.7 сая, Шугшаа ОНӨААТҮГ 38.2 сая, Цог-Өрнөх ОНӨААТҮГ 46.4 сая, Гүний ус ХК 19.9 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг цахим дэлгүүрээс худалдан авалт зохион байгуулаагүй,

- Ханбогд сумын ИТХ 12.0 сая, Ханхонгор сумын ИТХ 0.4 сая, Хүрмэн сумын ИТХ 4.1 сая, Цогт-Овоо сумын ЗДТГ 3.5 сая, Баян-Овоо сумын Засаг дарга 11.7 сая, Ханбогд сумын засаг дарга 210.3 сая төгрөгийн бэлэг дурсгалын зүйл худалдан авсан,

- Даланзадгад сумын ОНХС 162.9 сая төгрөгийн төсөл арга хэмжээний жагсаалтад зураг, төсөв, техник эдийн засгийн үндэслэлгүй "Нийтийн эзэмшлийн талбайд тохижилт хийх" ажлыг тайлант онд шилжүүлэн баталж, төсвийн тодотголоор нэмэгдүүлэн баталж зарцуулсан байна.

### 3.7.3. Орон нутгийн өмчит газруудын талаар

Өмнөговь аймгийн хэмжээнд Орон нутгийн өмчийн аж ахуй нэгж 43, орон нутгийн өмчийн оролцоотой аж ахуй нэгж 2 байгууллага үйл ажиллагаа явуулж байна.

Аудитаар 25 байгууллагын санхүүгийн тайланд өгсөн дүгнэлтийн 15 өөрчлөлтгүй, 8 хязгаарлалттай, 2 санал дүгнэлт гаргахаас татгалзаж, 20 байгууллагын санхүүгийн тайланд үе шатны ажлыг хэсэгчлэн гүйцэтгэсэн.

Хүснэгт№16 ОНӨҮГ, ОНӨО аж ахуй нэгж

/сая төгрөг/

ААН-ийн төрөл	ААН-ийн тоо	Орлого	Зардал	Ашиг/алдагдал
Дулаан үйлдвэрлэх, түгээх	17	15,425,794.4	14,832,913.4	592,881.1
Эмийн сан	13	1,875,023.2	1,989,053.60	(114,030.4)
Тохижилт	6	3,373,613.5	2,978,982.4	394,631.1
Хүүхдийн зуслан	1	3,138,630.6	2,488,865.4	649,765.2
Шүдний эмнэлэг	1	259,438.6	142,754.5	116,684.1
Төсөл хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэх, Сургалт, судалгааны ажил явуулах, Зөвлөх үйлчилгээ үзүүлэх нийлүүлэх	1	2,954,376.8	3,507,040.7	(552,663.9)
Хог хаягдал дахин боловсруулах	1	541,536.7	467,036.9	74,499.6
Уул уурхай	1	1,165,163,313.8	616,003,732.8	549,159,581.0
Ус хангамж	1	2,251,595.5	2,993,619.7	(742,024.2)
Худалдаа үйлчилгээ	1	319,295.0	322,522.8	(3,227.8)
Зорчигч тээвэр	1	1,781,303.3	1,203,285.9	578,017.4
Орон сууцны өмчлөл, түрээс	1	1,959,908.3	1,420,845.7	539,062.6
	<b>45</b>	<b>1,199,043,829.6</b>	<b>648,350,653.8</b>	<b>549,576,095.8</b>

Дээрх судалгаанаас харахад Өмнөговь аймгийн сумдыг дулааны эрчим хүчээр хангаж байгаа 17 ААН-ээс 14 нь ашигтай буюу нийт дүнгээр 592.9 сая төгрөгийн ашигтай, 13 эмийн эргэлтийн сангийн үйл ажиллагаа явуулж буй 8 ААН нь алдагдалтай буюу нийт дүнгээр 114.0 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 277,142.4 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 192,200.5 сая төгрөгийн алдааг аудитын явцад залруулж, 20.8 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 40,527.9 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага, 44,393.2 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өгч, 4 албан тушаалтад хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлсэн.

### 3.8 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

#### 3.8.1 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг “Шилэн дансны цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагуудын шилэн дансны хуулийн хэрэгжилтээр илрүүлсэн зөрчил:

Хүснэгт №17 Шилэн дансны тухай хуультай холбоотой илрүүлэлт / сая төгрөг/

Төсөв захирагчийн хэлбэр	Аудитын илрүүлэлт		Үүнээс:			
			Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<b>ТШЗ</b>	9	1,537.3	4	1,340.3	5	196.9
<b>ТТЗ</b>	2	3,381.2	1	3,381.2	1	0
<b>ОНӨААН</b>	11	44.5	2	17.7	9	26.8
<b>Дүн</b>	22	4,963.0	7	4,739.2	15	223.7

Эх сурвалж: Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл дүнгээс

ТЕЗ-ийн харьяа байгууллагууд дараах зөрчлүүдтэй байна.

- Мандал-Овоо сумын ИТХ нь шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 196.9 сая төгрөгийн 14 гүйлгээ, аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний, төсвийн хэмнэлт, хэтрэлтийн шалтгаан тайлбарыг бичээгүй, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийг 12 сард бөөн мэдээлсэн, Мандал-Овоо сумын ЗДТГ 5.0 сая төгрөгөөс дээш орлогын 1,263.2 сая төгрөгийн 43 ажил гүйлгээ, хөрөнгө зарцуулсан шийдвэрийн 17.2 сая төгрөгийн 8 гүйлгээ, 54.9 сая төгрөгийн гэрээний үнэтэй 1 ажлын тендерийн ерөнхий мэдээллийг тус тус мэдээлээгүй,

- Баян-Овоо Сүжийн говь ОНӨААТҮГ төрийн өмчийн аж ахуйн нэгж байгууллагын зорилтот түвшин, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан, тайлбарын хамт мэдээллийг 7,8 дугаар сард, Дараа жилийн зорилтот түвшин, Худалдан авах ажиллагааны тайланг тус тус мэдээлээгүй,

- Ноён Ингэн нүд ОНӨААТҮГ төрийн өмчийн аж ахуйн нэгж байгууллагын зорилтот түвшин, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан, тайлбарын хамт мэдээллийг 7,8 дугаар сард, Дараа жилийн зорилтот түвшин, Худалдан авах ажиллагааны тайланг тус тус мэдээлээгүй,

- Тавантолгой ХК аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан, батлагдсан орон тоонд орсон өөрчлөлтийн мэдээллийг 9-12 дугаар сард мэдээлээгүй,

- Сэврэй сумын Засаг дарга цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 824.3 сая төгрөгийн 12 гүйлгээ, зарлагын 2,556.9 сая төгрөгийн 19 гүйлгээг тус тус мэдээлээгүй байна.

Тайлант онд төсвийн хөрөнгийг захиран зарцуулсан тушаал шийдвэрийг холбогдох хууль тогтоомжийн дагуу бэлтгэсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

Мөн Хоршоо хөгжүүлэх сангаас олгосон зээлийн үлдэгдэлд дүн шинжилгээ хийхэд 117 иргэний 1,294,916.7 мянган төгрөгийн чанаргүй зээлдэгчээс 35.0 хувь буюу 41 иргэний 527,079.3 мянган төгрөгийн зээлийг шүүхийн шийдвэр гаргуулсан, 33.3 хувь буюу 39 иргэний 495,181.9 мянган төгрөгийн зээлд арга хэмжээ авч ажиллаагүй, 22.2 хувь буюу 26 иргэний 165,023.8 мянган төгрөгийн зээл шүүхэд хандсан, 6.8 хувь буюу 8 иргэний 70,693.2 мянган төгрөгийн зээлийн эзэн холбогдогч нас барсан, 2.6 хувь буюу 3 иргэний 36,938.6 мянган төгрөгийн зээлийн эзэн холбогдогч олдохгүй байна.

Иймд эзэн холбогдогч нас барсан тохиолдолд зээлийн эргэн төлөлтөд хэрхэн арга хэмжээ авах зохицуулалтыг "Хоршоо хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам"-д өөрчлөлт оруулж тодорхой тусгах шаардлагатай байна.

### 3.9 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх аудитаар илэрсэн нийцлийн аудиттай холбоотой асуудлаарх зөрчилд 4 албан шаардлагыг хүргүүлсэн байна. Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг 2024 оны 11 дүгээр сарын 01-ны өдрийн fas.audit.mn сайтад хэрэгжилтийг оруулсан байна.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлага зөвлөмжийн хэрэгжилт:

Хүснэгт №18 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлага зөвлөмж

/сая төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Биелэгдээгүй		Хэрэгжилтийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	2	35,000.0	1	35,000.0	1	0	50.0
Албан шаардлага	12	3,566,152.2	9	3,566,152.2	3	0	75.0
Төлбөрийн акт	2	5,627.7	2	5,627.7	-	-	100.0
<b>Нийт</b>	<b>16</b>	<b>3,606,779.9</b>	<b>12</b>	<b>3,606,779.9</b>	<b>4</b>	<b>0</b>	<b>75.0</b>

Эх сурвалж: Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл дүнгээс

Аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын дагуу дараах арга хэмжээг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулалт хийх аливаа арга хэмжээ, тусламж дэмжлэгийг удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлэхийн зэрэгцээ тус сангаас хөрөнгө зарцуулах захирамжийн төсөлд аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга, бүх хэлтсийн дарга нар санал өгч Засаг зарга зөвшөөрснөөр зарцуулсан байна.

Өмнөх зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилтийг фас системээр хүлээн авч үнэлж хэрэгжилт хангуулаагүй зөрчилд албан шаардлага хүргүүлсэн. Үүнд:

- Хоршоо хөгжүүлэх сангаас 204 иргэнд олгосон 2,722,914.890 төгрөгийн зээлийн үлдэгдлээс 47.6 хувийг буюу 117 иргэний 1,294,916,734.13 төгрөгийг чанаргүй зээл эзэлж, тус хэмжээгээр хөрөнгийн эргэлт зогссон,

- Орон нутгийн нөөц хөрөнгийн зардлаас 2 байгууллагын ойн арга хэмжээний зардалд 32,645.000 төгрөгийн дэмжлэг олгосон нь өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй тул зөрчлийг дахин давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

### 3.10 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд төсвийн шууд захирагчийн 37, орон нутгийн тусгай сан 36, орон нутгийн өмчит аж ахуйн нэгж 52, орон нутгийн өмчийн оролцоотой аж ахуй нэгж 2, төсвийн төвлөрүүлэн захирагч 15, нийт 142 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 74 санхүүгийн тайланд дүгнэлт гаргаж, 68 санхүүгийн тайланг түүвэрт хамруулсан.

Аудитаар 74 байгууллагын санхүүгийн тайланд өгсөн дүгнэлтийн 43 өөрчлөлтгүй, 29 хязгаарлалттай, 2 санал дүгнэлт гаргахаас татгалзсан байна.

#### Хүснэгт №19 Аудитын дүн

Төсөв захирагчийн хэлбэр	Байгууллага нэгжийн тоо			Гаргасан санал дүгнэлтийн хэлбэр			
	Аудитад хамрагдах	Үүнээс: аудит хийсэн хэлбэр		Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
		Дүгнэлт гаргах	Түүвэрт				
ТШЗ	37	30	7	19	11		
ОНТС	36		36				
ОНӨААН	52	27	25	17	8		2
ОНӨОААН	2	2			2		
ТТЗ	15	15		7	8		
<b>Нийт дүн</b>	<b>142</b>	<b>74</b>	<b>68</b>	<b>43</b>	<b>29</b>	<b>0</b>	<b>2</b>

Эх сурвалж: Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл дүнгээс

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 370,590.4 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 276,903.0 сая төгрөгийн алдааг аудитын явцад залруулж, 128.3 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 46,752.1 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага, 46,807.0 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өгч, 4 албан тушаалтад хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлсэн.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудлаар нийт 4,963.0 сая төгрөгийн зөрчил илэрснээс 4,739.2 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага, 223.8 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өглөө.

### 3.11 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

- Эмийн эргэлтийн сангуудын төсвийн хөрөнгөөр худалдан авч байгаа болон бусад эх үүсвэрээс үнэ төлбөргүй нийлүүлэгдэж байгаа эмийн хугацаа, ашиглалт,

- Өмнөговь аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрээр 2024 онд үүсгэн байгуулсан "Итгэлтэй амьдрал" ОНӨААҮГ-т орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний зардлаас 189.1 сая төгрөгийг өр барагдуулахад, "Говь дент анхны цахиур" орон нутгийн өмчит ОНӨААТҮГ-т "Эрүүл шүд" хөтөлбөрийн зардлаас 155.8 сая төгрөгийн үйл ажиллагааны санхүүжилт тус тус олгосон нь хуулийн этгээдийн хариуцлагын хэлбэрт нийцэхгүй байгааг дараагийн аудитаар анхаарч үзэх

### 3.12 Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 5,879.3 сая төгрөгийн зөрчил<sup>12</sup> илэрснээс 24.0 сая төгрөгийн зөрчил төлбөрийн акт тогтоож, санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой 1,994.8 сая төгрөгийн

<sup>12</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

11 зөрчилд албан шаардлага, 3,860.5 сая төгрөгийн зөрчилд 6 зөвлөмж, 1 албан тушаалтанд хариуцлага тооцох албан шаардлага өглөө.

Санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа хязгаарлалттай дүгнэлт авсан байгууллагуудын 85,652.3 сая, санхүүгийн нэгтгэсэн тайлангаар 5,989.2 сая, нийт 91,641.6 сая төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшингээс өндөр байгаа тул Хязгаарлалттай дүгнэлт өглөө. Нийт зөрчлийн 86.7 хувийг орон нутгийн өмчит “Таван толгой” ХК эзэлж байна.

### 3.12.1 Төлбөрийн акт

1. Аймгийн Засаг даргын 2024 оны А/2433 дугаар захирамжаар аймгийн Засаг даргын Тамгын газрын албан хаагчдыг эрт илрүүлгийн үзлэг шинжилгээ, оношилгоонд хамруулахад 24,000,000 төгрөгийг Бүсийн оношилгоо эмчилгээний төв рүү шилжүүлсэн боловч гэрээ байгуулаагүй, албан хаагчдыг үзлэг шинжилгээнд хамруулаагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.7-д *"хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, хүрэх үр дүнг хангаж ажиллах"*, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д *"Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно"* гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

### 3.12.2 Албан шаардлага

1. ТЕЗ-ийн харьяа аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Говь гурван сайхан орон сууцны корпораци ХХК, Өмнөговь корпораци ОНӨААТҮГ, Тавантолгой ХК, Гүний ус ХХК, Баяндалай, Булган, Гурвантэс, Номгон, Ханбогд, Хүрмэн, Цогт-Овоо, Цогтцэций сумдын төсвийн төвлөрүүлэн захирагчдын 2024 оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 85,652,399,197 төгрөгийн илэрч хязгаарлалттай дүгнэлт авсан. Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3-д *"Төсвийн ерөнхийлөн захирагч өөрийн эрхлэх асуудлын төсвийн орлого, зарлагын зүй зохистой, үр ашигтай байдал, үр дүнгийн гүйцэтгэлийг хангаж, өөрт хамаарах төсвийн гүйцэтгэлийн биелэлтийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, болон Зөвлөл Засгийн газар, Улсын Их Хурлын өмнө бүрэн хариуцна"*, Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоол *"Дотоод аудитын дүрэм"*-ийн 5 дугаар зүйлийн 5.1-д *"Дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтыг дараах хүрээнд хийнэ"*, 5.2-д *"Санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагчийн эрхтэй дотоод аудитор буюу санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагч нь энэ журмын 5.1-д зааснаас гадна дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ"* гэсэн заалтыг тус тус хэрэгжүүлээгүй байна.

2. Бичил уурхай эрхлэгчдийн үйл ажиллагааг эхлүүлэхэд шаардлагатай 4 төрлийн 30,000,000 төгрөгийн хамгаалалтын хэрэгслийг Орон нутгийн өмчийн газар санхүүгийн тайландаа тоног төхөөрөмжөөр бүртгэсэн байна. Энэ нь УСННБОУС-12 *"Бараа материал"*, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д *"үнэн зөв байх"*, 20 дугаар зүйлийн 20.2.3-д *"холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах"* гэсэн заалттай тус тус нийцээгүй байна.

3. Аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөө, АИТХ-ын 2024 оны 19/28 дугаар тогтоолд аймгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр тусгасан *"Аймгийн санхүү нягтлан бодох бүртгэл, эдийн засгийн ажилтнуудын мэдлэг, боловсрол, чадавхыг дээшлүүлэх, нягтлан бодох бүртгэл хөтөлөлт, олон улсын стандартын нэвтрэлтийг нэмэгдүүлэх"* арга хэмжээнд нийт 200,000.000 төгрөгийг сумдын засаг даргын нөөц сангийн хөрөнгөөр санхүүжүүлсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.6.6-д *"Тухайн шатны төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргийг зөвхөн тухайн шатны төсвийн санхүүжилтээр хэрэгжүүлэх"* 42 дугаар зүйлийн 42.2.1.а-д *"өөрийн төсвийн багцад хамаарах хөтөлбөр хооронд"* гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

4. Орон нутгийн нөөц хөрөнгөөс уулзалт, зөвлөгөөний заалны зардалд 54,760,240 төгрөг, баяр наадмын зардалд 29,618,940 төгрөг зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3-д "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах", Сангийн сайдын 2021 оны 61 дугаар тушаалаар баталсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 1.2-д "Энэ журмын 1.1 заасан "урьдчилан төлөвлөж төсөвт тусгах боломжгүй байсан" гэдгийг жил бүр давтагддаггүй онцгой арга хэмжээ, тохиолдлыг төсвийн зардлын зүйл, арга хэмжээний ангиллын дагуу санхүүжүүлэх боломжгүй нөхцөл байдал гэж ойлгоно", 2 дугаар зүйлийн 2.1.5-д "энэ журмын 2.1.1, 2.1.2-т зааснаас бусад Засаг дарга хуулиар олгогдсон бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй холбоотой урьдчилан төлөвлөж төсөвт тусгах боломжгүй байсан нэг удаагийн шинжтэй арга хэмжээ", 3 дугаар зүйлийн 3.1.2-д "урьдчилан төлөвлөх боломжтой гадаад, дотоод албан томилолтын зардал, энэ журмын 2.1.1, 2.1.2-т зааснаас бусад зориулалтаар тоног төхөөрөмж бэлтгэх хөрөнгө оруулалтын зардлыг тусгаагүй байх", 7.1-д "төсвийн захирагч нөөц хөрөнгийн санхүүжилтийг зөвхөн зориулалтын дагуу зарцуулна" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

5. Орон нутгийн нөөц хөрөнгөөс 10 төрлийн арга хэмжээнд олгосон 124,257,420 төгрөгийн ажлын зарцуулалтын тайлан байхгүй байна. Энэ нь Сангийн сайдын 2021 оны 61 дугаар тушаалаар баталсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын журам"-ын 6 дугаар зүйлийн 6.1-д "Нөөц хөрөнгөөр хэрэгжүүлэх арга хэмжээг хариуцан гүйцэтгэж байгаа байгууллага, ажилтан хөрөнгийн зарцуулалтын тайланг уг арга хэмжээг хэрэгжүүлж дууссанаас хойш ажлын 15 хоногийн дотор гаргаж, тухайн шатны Засаг даргын Тамгын газарт ирүүлнэ" гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

6. Хоршоо хөгжүүлэх сангаас 204 иргэнд олгосон 2,722,914,890 төгрөгийн зээлийн үлдэгдлээс 47.6 хувийг буюу 117 иргэний 1,294,916,734.13 төгрөгийн чанаргүй зээл эзлэн, өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй байна. Энэ нь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны А/361 дүгээр тушаалаар баталсан "Хоршоо хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам"-ын 3.2-д "Сангийн үйл ажиллагааг аймгийн хэмжээнд нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангах чиг үүргийг тухайн аймгийн Засаг дарга, аймгийн жижиг, дунд үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг хариуцсан байгууллага хэрэгжүүлэх бөгөөд Засаг дарга нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ" гэж заасантай нийцэхгүй байна.

7. Нөөц сангийн хөрөнгөөс 2 байгууллагын ойн арга хэмжээний зардалд 32,645,000 төгрөгийн дэмжлэг олгож өмнөх оны аудитаар өгсөн 329/А1671226ӨМА-2024/01/НА-СТА-ТЕЗ дугаартай албан шаардлагыг хэрэгжүүлээгүй зөрчил давтан илэрсэн байна. Энэ нь Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.10 "аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол" заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

8. Залуус хөтөлбөрөөс монголын Залуучуудын холбоо Өмнөговь аймаг дахь салбараас зохион байгуулсан "Оны шилдгүүдийг шалгаруулах" шинэ жилийн арга хэмжээнд 26,665,000 төгрөг зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.16-д "хөтөлбөр" гэж төсөв хуваарилах зорилгоор үр дүнг нь тооцож, тайлагнаж болохуйц өөр хоорондоо уялдаа бүхий төрийн чиг үүргийг хангахад чиглэсэн багц арга хэмжээ", 24 дугаар зүйлийн 24.7-д "Төсвийн хөрөнгө, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төрд болон орон нутагт ногдох хөрөнгийг Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 3.1.2-т заасан нийтээр тэмдэглэх тэмдэглэлт өдөр, тэдгээртэй адилтгах аливаа өдөрлөгт зориулж зарцуулахыг хориглоно", Залуус хөтөлбөрийн хэрэгжүүлэх арга хэмжээний заалтуудтай нийцэхгүй байна.

9. Аймгийн Засаг даргын Тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч өндөр насны тэтгэвэрт гарах 8 төрийн албан хаагчдад нэг удаагийн

буцалтгүй тусламж олохдоо үндсэн цалингийн сүүлийн 3 жилийн дунджийг буруу тооцоолон олгож буруутай шийдвэр гаргасан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 5.1.5-д "хариуцлагатай байх", 16 дугаар зүйлийн 16.5-д "Төсвийн шууд захирагч нь төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ" 16.5.2-д "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.13-д "албан тушаалын тодорхойлолтод заасан зорилго, зорилт, чиг үүргийн хэрэгжилтийг хангах" гэж заасныг тус тус хэрэгжүүлээгүй байна.

10. Аймгийн Засаг даргын 2024 оны А/1855 дугаар захирамжаар "Энэ жилдээ-Эрүүл жиндээ аяны" хүрээнд хэрэгжүүлсэн Өмнөговь аймгийн даян хааны хүчтэн пауэрлифтинг бодибилдинг, фитнесийн холбоонд олгосон 10,000,000 төгрөгийн зарцуулалт анхан шатны баримтаар нотлогдохгүй зорилтот бүлгийн иргэдийг идэвхтэй дасгал хөдөлгөөнд хамруулаагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3-д "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах", 41 дүгээр зүйлийн 41.2.7-д "хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, хүрэх үр дүнг хангаж ажиллах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

11. Мал хамгаалах сангийн 5 жилээс насжилттай 65,213,819 төгрөгийн авлагыг барагдуулах талаар арга хэмжээ авч ажиллаагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", 14 дүгээр зүйлийн 14.2.3-д "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах" 2015 оны 483 дугаар тогтоол "Дотоод аудитын дүрэм"-ийн 5 дугаар зүйлийн 5.1-д "Дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтыг дараах хүрээнд хийнэ", 5.2-д "Санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагчийн эрхтэй дотоод аудитор буюу санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагч нь энэ журмын 5.1-д зааснаас гадна дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ" гэсэн заалтыг тус тус хэрэгжүүлээгүй байна.

12. Орон сууцны сантай холбоотой 5 жилээс дээш насжилттай 126,686,850 төгрөгийн авлагыг барагдуулах талаар арга хэмжээ авч ажиллаагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", 14 дүгээр зүйлийн 14.2.3-д "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах" 2015 оны 483 дугаар тогтоол "Дотоод аудитын дүрэм"-ийн 5 дугаар зүйлийн 5.1-д "Дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтыг дараах хүрээнд хийнэ", 5.2-д "Санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагчийн эрхтэй дотоод аудитор буюу санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагч нь энэ журмын 5.1-д зааснаас гадна дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ" гэсэн заалтыг тус тус хэрэгжүүлээгүй байна.

### **3.12.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

**Илрүүлэлт-1:** Таван жилээс дээш насжилттай авлага болох "Гал мөнх" ХХК-ийн 2,339.2 сая төгрөгийн 2013, 2014 онуудад "1000 айлын орон сууц хөтөлбөр"-ийн хүрээнд эргэн төлөгдөх нөхцөлтэй олгосон авлагын 2018 оны шүүхийн шийдвэр хэрэгжээгүй байна. Энэ нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 122 дугаар зүйл 122.5-д "Бие даасан шаардлага гаргах эрхтэй гуравдагч этгээд болон иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талууд энэ хуулийн 6.2.1, 6.2.2-д заасан шийдвэрийг үндэслэн явуулж байгаа иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талаарх гомдлоо иргэний хэргийг эцэслэн шийдвэрлэсэн шүүхэд, энэ хуулийн 6.2.3, 6.2.4-д заасан шийдвэрийг үндэслэн явуулж байгаа иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талаарх гомдлоо гүйцэтгэх хуудас олгосон шүүхэд, энэ хуулийн 6.2.5, 6.2.6-д заасан шийдвэрийг үндэслэн явуулж байгаа иргэний шийдвэр гүйцэтгэх

*ажиллагааны талаарх гомдлоо Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан нийтлэг журмын дагуу гаргана*" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийг хэрэгжүүлж, шийдвэр гүйцэтгэлийг үйл ажиллагааг эрчимжүүлэх арга хэмжээ авч ажиллах.

Илрүүлэлт-2: Тайлант онд нийтийн ахуй үйлчилгээ эрхлэгч, малчдыг бүтээгдэхүүнээ борлуулах, үйлчилгээг явуулах ажлыг зохион байгуулалтаар хангаж хэрэгжүүлэх, хяналт тавих, ашиглалт хамгаалалтыг хариуцан ажиллах чиг үүрэгтэй "Худалдааны төв зах" ОНӨААТҮГ-ийг байгуулж 320,008,870.61 төгрөгийн хөрөнгө үр ашиггүй зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "*төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах*", 14 дүгээр зүйлийн 14.2.12-д "*эрхлэх асуудлын хүрээнд хамаарах төсөвт байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, чиг үүргийн давхардлыг арилгах, ажлын ачааллыг нягтруулах, бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор чиг үүрэг, зохион байгуулалтын бүтцийг батлагдсан орон тооны хязгаар, төсөвт багтаан шинэчлэн тогтоох*" гэж заасныг тус тус хэрэгжүүлээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төсвийн байгууллагатай чиг үүргийн давхардалтай, эсхүл чиг үүрэг ойролцоо, харилцан уялдаа бүхий үйл ажиллагаа гүйцэтгэх орон нутгийн өмчит хуулийн этгээдийг үүсгэн байгуулахгүй байх

Илрүүлэлт-3: Аймгийн Засаг даргын 2024 оны А/2423 дугаар захирамжийн дагуу Түрээсийн орон сууцны зориулалтаар газар, үл хөдлөх хөрөнгийн нөхөн олговорт 665,598,573 төгрөг олгосон боловч газрыг чөлөөлж, төрийн өмчид бүртгээгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.2-д "*бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага*", Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын 2.3.1.10-д "*төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж байгаа болон санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээний өмч бүртгэл, ашиглалтыг хариуцан хэрэгжүүлэх*" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний хөрөнгийн бүртгэл, ашиглалтад хяналт тавьж захирамжийн хэрэгжилтийг хангаж ажиллах

Илрүүлэлт-4: "Цахим Өмнөговь" хөтөлбөрийн хүрээнд "Ногоон хөгжлийг түгээн дэлгэрүүлэх контентууд болон апп хөгжүүлэх" ажлыг МВМ сор ХХК-аар гүйцэтгүүлж аймгийн ЗДТГ-ын даргын 224 оны А/766 дугаар тушаалаар ажлын хэсэг байгуулан хүлээж авсан боловч Green Gobi аппликейшн 240.0 сая төгрөгийг бүртгэлд тусгаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.2 "*бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага*", Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын 2.3.1.10 "*төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж байгаа болон санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээний өмч бүртгэл, ашиглалтыг хариуцан хэрэгжүүлэх*" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний өмч бүртгэл, ашиглалтад хяналт тавих, бүртгэлд тусгах, төрийн байгууллагын уялдаа холбоог сайжруулж ажиллах

Илрүүлэлт-5: Агаарын бохирдолгүй Өмнөговь хөтөлбөрийн хүрээнд гэр хорооллын айл өрхийн энгийн галлагаатай зуухыг дэвшилтэт технологи бүхий цахилгаан зуухаар сольж, агаарын бохирдлыг бууруулах зорилгоор тайлант онд 48 ширхэг цахилгаан зуухыг худалдан авсан боловч өнөөг хүртэл иргэдэд олгоогүй, журмын дагуу өрхийн судалгааг бүрэн гаргаж дуусаагүй байна. Энэ нь Өмнөговь аймгийн Засаг даргын 2024 оны А/2336 дугаар захирамжаар баталсан "Гэр хорооллын дэвшилтэт технологи бүхий цахилгаан зуухаар хангах ажлын журам" -ын 5.1-д "*Энэхүү журмын гуравдугаар хэсэгт заасан шаардлага хангасан, хөнгөлөлттэй үнээр цахилгаан зуух авах хүсэлт гаргасан иргэний*

*материалыг Даланзадгад сумын Засаг даргын Тамгын газар хүлээн авч, иргэнийг сонгон шалгаруулна", 5.2-д "Даланзадгад сумын Засаг даргын Тамгын газар иргэний ирүүлсэн материалыг үндэслэн цахилгаан зуух олгох гэрээ байгуулна" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.*

Өгсөн зөвлөмж: Хөтөлбөрийн хэрэгжилтийг бүрэн хангуулж иргэдэд чиглэсэн үйл ажиллагааг хурдан шуурхай гүйцэтгэхэд анхаарч ажиллах

Илрүүлэлт-6: "Хүнсний хангамж - аюулгүй байдал" үндэсний хөдөлгөөнийг орон нутагт хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний зардлаас 68,100,000 төгрөгийн тусгаарлах хана, 77,612,000 төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.16-д "хөтөлбөр" гэж төсөв хуваарилах зорилгоор үр дүнг нь тооцож, тайлагнаж болохуйц өөр хоорондоо уялдаа бүхий төрийн чиг үүргийг хангахад чиглэсэн багц арга хэмжээ", 14 дүгээр зүйлийн 14.2.3-д "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төсөл, арга хэмжээний шалгуур үзүүлэлтийг оновчтой, хүрэх үр дүнг тодорхой байхаар төлөвлөн төсвийн хөрөнгийг зориулалтын дагуу, үр ашигтайгаар зарцуулан хөрөнгө оруулалтын шинж чанартай хөрөнгө бэлтгэхгүй байх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 11 дүгээр сарын 15-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

(мянган төгрөгөөр)

№	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс												
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал				
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн			
1	Аймгийн Засаг даргын 2024 оны А/2433 дугаар захирамжаар БОЭТ-ийн албан хаагчдыг эрт илрүүлэхийн үзлэг шинжилгээ, оношилгоонд хамруулахаар олгосон 24,000,000 төгрөгийн дэмжлэг олгосон ч төсвийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулаагүй, үзлэг шинжилгээнд хамруулаагүй байна.	1	24,000.0	1	24,000.0											
2	ТЕЗ-ийн харьяа аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Говь гурван сайхан орон сууцны корпораци ХХК, Өмнөговь корпораци ОНӨААТҮГ, Тавантолгой ХК, Гүний ус ХХК, Баяндалай, Булган, Гурвантэс, Номгон, Ханбогд, Хүрмэн, Цогт-Овоо, Цогтцэций сумдын төсвийн төвлөрүүлэн захирагчдын 2024 оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 85,652.4 сая төгрөгийн илэрч хязгаарлалттай дүгнэлт авсан байна	1	0			1	0									-
3	Бичил уурхай эрхлэгчдийн үйл ажиллагааг эхлүүлэхэд шаардлагатай 4 төрлийн 30.0 сая төгрөгийн хамгаалалтын хэрэгслийг Орон нутгийн өмчийн газар санхүүгийн тайландаа тоног төхөөрөмжөөр бүртгэсэн байна	1	30,000.0			1	30,000.0									-
4	"Аймгийн санхүү нягтлан бодох бүртгэл, эдийн засгийн ажилтнуудын мэдлэг, боловсрол, чадавхыг дээшлүүлэх, нягтлан бодох бүртгэл хөтлөлт, олон улсын стандартын нэвтрэлтийг нэмэгдүүлэх" арга хэмжээнд нийт 200.0 сая төгрөгийг зарим сумдын засаг даргын нөөц сангийн хөрөнгөөр санхүүжүүлсэн байна.	1	200,000.0	-	-	1	200,000.0									-
5	Орон нутгийн нөөц хөрөнгөөс уулзалт, зөвлөгөөний заалны зардалд 54.8 сая төгрөг, баяр наадмын зардалд 29.6 сая төгрөг тус тус зарцуулсан байна	1	84,379.2	-	-	1	84,379.2									-
6	Орон нутгийн нөөц хөрөнгөөс 10 төрлийн арга хэмжээнд олгосон 124.3 сая төгрөгийн ажлын зарцуулалтын тайлан байхгүй байна	1	124,257.4			1	124,257.4					-	-	-	-	-

Өмнөговь аймгийн Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

7	Хоршоо хөгжүүлэх сангаас олгосон зээлийн үлдэгдлээс 47.6 хувийг буюу 117 иргэний 1,294.9 сая төгрөгийн чанаргүй зээл эзлэн, өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй байна.	1	1,294,916.7			1	1,294,916.7			-	-	-	-
8	Нөөц сангийн хөрөнгөөс 2 байгууллагын ойн арга хэмжээний зардалд 32.6 сая төгрөгийн дэмжлэг олгож өмнөх оны аудитаар өгсөн 329/А1671226ӨМА-2024/01/НА-СТА-ТЕЗ дугаартай албан шаардлагыг хэрэгжүүлээгүй зөрчил давтан илэрсэн байна.	1	32,645.0			1	32,645.0						
9	Залуус хөтөлбөрөөс монголын Залуучуудын холбоо Өмнөговь аймаг дахь салбараас зохион байгуулсан "Оны шилдгүүдийг шалгаруулах" шинэ жилийн арга хэмжээнд 26.7 сая төгрөг зарцуулсан байна.	1	26,665.0			1	26,665.0						
10	Аймгийн Засаг даргын Тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч өндөр насны тэтгэвэрт гарах 8 төрийн албан хаагчдад нэг удаагийн буцалтгүй тусламж олохдоо үндсэн цалингийн сүүлийн 3 жилийн дунджийг буруу тооцоолон олгож буруутай шийдвэр гаргасан байна	1	0							1	1		
11	Аймгийн Засаг даргын 2024 оны А/1855 дугаар захирамжаар "Энэ жилдээ-Эрүүл жиндээ аяны" хүрээнд хэрэгжүүлсэн Өмнөговь аймгийн даян хааны хүчтэн пауэрлифтинг бодибилдинг, фитнесийн холбоонд олгосон 10,000,000 төгрөгийн зарцуулалт анхан шатны баримтаар нотлогдохгүй зорилтот бүлгийн иргэдийг идэвхтэй дасгал хөдөлгөөнд хамруулаагүй байна	1	10,000.0			1	10,000.0						
12	Таван жилээс дээш насжилттай авлага болох Гал мөнх ХХК-ийн 2,339.2 сая төгрөгийн 2013, 2014 онуудад "1000 айлын орон сууц хөтөлбөр"-ийн хүрээнд эргэн төлөгдөх нөхцөлтэй олгосон авлагын 2018 оны шүүхийн шийдвэр хэрэгжээгүй байна	1	2,339,204.2					1	2,339,204.2				
13	Тайлант онд нийтийн ахуй үйлчилгээ эрхлэгч, малчдыг бүтээгдэхүүнээ борлуулах, үйлчилгээг явуулах ажлыг зохион байгуулалтаар хангаж хэрэгжүүлэх, хяналт тавих, ашиглалт хамгаалалтыг хариуцан ажиллах чиг үүрэгтэй "Худалдааны төв зах" ОНӨААТҮГ-ийг байгуулж 320.0 сая төгрөгийн хөрөнгө үр ашиггүй зарцуулсан байна	1	320,008.9					1	320,008.9				
14	Аймгийн Засаг даргын 2024 оны А/2423 дугаар захирамжийн дагуу Түрээсийн орон сууцны зориулалтаар газар, үл хөдлөх хөрөнгийн нөхөн олговорт 665.6 сая төгрөг олгосон боловч газрыг чөлөөлж, төрийн өмчид бүртгээгүй байна	1	665,598.6					1	665,598.6				
15	"Цахим Өмнөговь" хөтөлбөрийн хүрээнд "Ногоон хөгжлийг түгээн дэлгэрүүлэх контентууд болон апп хөгжүүлэх" ажлыг МВМ сор ХХК-аар гүйцэтгүүлж аймгийн ЗДТГ-ын даргын 224 оны А/766 дугаар	1	240,000.0					1	240,000.0				

Өмнөговь аймгийн Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

	тушаалаар ажлын хэсэг байгуулан хүлээж авсан боловч Green Gobi аппликейшныг 240.0 сая төгрөгийг бүртгэлд тусгаагүй байна.											
16	Агаарын бохирдолгүй Өмнөговь хөтөлбөрийн хүрээнд гэр хорооллын айл өрхийн энгийн галлагаатай зуухыг дэвшилтэт технологи бүхий цахилгаан зуухаар сольж, агаарын бохирдлыг бууруулах зорилгоор тайлант онд 48 ширхэг цахилгаан зуухыг худалдан авсан боловч өнөөг хүртэл иргэдэд олгоогүй, журмын дагуу өрхийн судалгааг бүрэн гаргаж дуусаагүй байна.	1	150,000.0				1	150,000.0				
17	"Хүнсний хангамж - аюулгүй байдал" үндэсний хөдөлгөөнийг орон нутагт хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний зардлаас 68,1 сая төгрөгийн тусгаарлах хана, 77,6 сая төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авсан байна.	1	145,712.0				1	145,712.0				
18	Мал хамгаалах сангийн 5 жилээс насжилттай 65.2 төгрөгийн авлагыг барагдуулах талаар арга хэмжээ авч ажиллаагүй байна.	1	65,213.8			1	65,213.8					
19	Орон сууцны сантай холбоотой 5 жилээс дээш насжилттай 126.7 сая төгрөгийн авлагыг барагдуулах талаар арга хэмжээ авч ажиллаагүй байна.	1	126,686.8			1	126,686.8					
<b>Дүн</b>		<b>19</b>	<b>5,879,287.6</b>	<b>1</b>	<b>24,000.0</b>	<b>11</b>	<b>1,994,763.9</b>	<b>6</b>	<b>3,860,523.7</b>	<b>1</b>	<b>1</b>	

ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



# АУДИТЫН ТАЙЛАН

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2024 ОНЫ ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: ӨМА-2025/001/НА-СТА-ТЕЗ

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ХӨТӨЛБӨР, ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭНИЙ ЗАРЦУУЛАЛТАД ТАВИХ  
ДОТООД ХЯНАЛТЫГ САЙЖРУУЛАХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА.

Даланзадгад хот 2025 он



Дарга, Тэргүүлэх аудитор Ц.Өсөхбаяр  
Утас: 70533539 Цахим хаяг: [Usukhbayarts@audit.gov.mn](mailto:Usukhbayarts@audit.gov.mn)  
Аудитын менежер Т.Хонгорзул  
Утас: 70533552 Цахим хаяг: [Khongorzult@audit.gov.mn](mailto:Khongorzult@audit.gov.mn)  
Ахлах аудитор С.Одончимэг  
Утас: 70533552 Цахим хаяг: [Odonchimegs@audit.gov.mn](mailto:Odonchimegs@audit.gov.mn)  
Аудитор О.Чойдорж  
Утас: 70533552 Цахим хаяг: [ChoidoriO@audit.gov.mn](mailto:ChoidoriO@audit.gov.mn)  
Аудитор Т.Будсүрэн  
Утас: 70533552 Цахим хаяг: [Budsurent@audit.gov.mn](mailto:Budsurent@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу: Цахим хаяг: [www.audit.mn](http://www.audit.mn)

Аудитыг гүйцэтгэсэн:	Агуулга	Хуудас
Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Ц.Өсөхбаяр	Товчилсон үгийн тайлбар	3
Аудитын менежер: Т.Хонгорзул	Хүснэгт, график, зургийн жагсаалт	3
Ахлах аудитор: С.Одончимэг	Аудитын зорилт, арга зүй, стандартын талаарх мэдэгдэл	4
Аудитор  О.Чойдорж Т.Будсүрэн	<b>Бүлэг 1.</b> Төсвийн төсөл боловсруулахад олон нийтийн оролцоог хангаж ажиллаагүй байна.	5-7
	<b>Бүлэг 2.</b> Төсвийн орлогыг бодит тооцоо судалгаанд үндэслээгүй нь орлогын төлөвлөгөө тасрах нөхцөлийг үүсгэсэн байна.	8-15
	<b>Бүлэг 3.</b> Төсвийн хөрөнгийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах шаардлагатай байна.	16-23
	<b>Бүлэг 4.</b> ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэлд тавих хяналтыг сайжруулах шаардлагатай байна.	24-28
	<b>Бүлэг 5.</b> Төсөл хөтөлбөрийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж ажиллах шаардлагатай байна.	29-35
	<b>Дүгнэлт</b>	35-36
	<b>Зөвлөмж</b>	37
	<b>Тэргүүлэх аудиторовын тушаал</b>	38
	<b>Хавсралт</b>	39-44
2025 оны 04 дүгээр сар  Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70533539, 70533552 дугаарын утсаар харилцана уу.		
Тайланг ӨМТАГ-ын <a href="mailto:www.umnugovi@audit.gov.mn">www.umnugovi@audit.gov.mn</a> цахим хуудаснаас үзнэ үү.		
Хаяг: Нутгийн удирдлагын ордон, 3 давхар, 305 тоот		

## ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

УИХ	Улсын Их хурал
МУЗГ	Монгол Улсын Засгийн газар
АИТХ	Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ҮХЭХАТ	Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар
АТБӨЯХАТ	Автотээвэр болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар
ХШҮХ	Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэс
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ОНТХО	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
УТҮГ	Улсын төсөвт үйлдвэрийн газар
ӨЭМТ	Өрхийн эрүүл мэндийн төв
ЗДНХ	Засаг даргын нөөц хөрөнгө

Дугаар	Тайлбар	Хуудас
Хүснэгт 1	Аймгийн хөгжлийн төлөвлөгөө салбарын ангиллаар	
Хүснэгт 2	Аймгийн хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн үнэлгээ	6
Хүснэгт 3	Аймгийн нийт орлогын төлөвлөлт	9
Хүснэгт 4	Аймгийн төсвийн орлогын гүйцэтгэл	10
Хүснэгт 5	Төсвийн орлогын гүйцэтгэл татварын нэр төрлөөр	10
Хүснэгт 6	Төсвийн орлогын гүйцэтгэл аймаг, сумдаар	11
Хүснэгт 7	Сумдаас аймгийн төсөвт төвлөрүүлсэн орлого	12
Хүснэгт 8	ААНОАТ-ийн дахин хуваарилалт	13
Хүснэгт 9	Орон нутгийн төсвийн зарлагын төлөвлөлт	16
Хүснэгт 10	Орон нутгийн төсвийн зарлагын гүйцэтгэл	17
Хүснэгт 11	Аймгаас улсын төсөвт төвлөрүүлсэн дүн	18
Хүснэгт 12	ТЕЗ-ийн төсвийн гүйцэтгэл хөтөлбөрөөр	19
Хүснэгт 13	Сумдын нэмэлт төсвийн гүйцэтгэл	19
Хүснэгт 14	Төрийн хэмнэлтийн тухай хуулийн зөрчил	20
Хүснэгт 15	Төрийн хэмнэлтийн зөрчил хуулийн зүйл заалтаар	21
Хүснэгт 16	Нөөц хөрөнгийн зарцуулалт	21
Хүснэгт 17	Нөөц хөрөнгийн зориулалт	22
Хүснэгт 18	Баталсан төсөл арга хэмжээний жагсаалт	24
Хүснэгт 19	Хэрэгжүүлсэн ХО-ын төсөл арга хэмжээний жагсаалт	24
Хүснэгт 20	ОНХС-ийн хөрөнгөөр 2024 онд хийхээр төлөвлөсөн хөрөнгө оруулалтын жагсаалт	25
Хүснэгт 21	ОНХС-аар хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний гүйцэтгэл	25
Хүснэгт 22	Дэд хөтөлбөрт зарцуулсан төсөв	28
Хүснэгт 23	Дэд хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт, шинжилгээ үнэлгээний хувь	29

Аудитын зорилт, арга зүйн талаарх мэдэгдэл	
<b>Аудит хийх үндэслэл:</b>	Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4-д заасны дагуу орон нутаг дахь Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Өмнөговь аймгийн Засаг даргын 2024 оны төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийв.
<b>Аудитын зорилт:</b>	<p>Өмнөговь аймгийн Засаг даргын 2024 оны төсвийн гүйцэтгэлийн тайланг холбогдох хууль тогтоомж, стандарт, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн актын шаардлагад нийцүүлэн үнэн зөв тайлагнасан эсэхийг баталгаажуулж, дүгнэлт гарган аймгийн Засаг даргад танилцуулахад аудитын зорилт чиглэгдэв.</p> <p>Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"><li>• Хөгжлийн жилийн төлөвлөгөөний төлөвлөлт, гүйцэтгэл</li><li>• Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөлт, гүйцэтгэл</li><li>• Орон нутгийн төсвийн зарлагын төлөвлөлт, гүйцэтгэл</li><li>• Орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлт, худалдан авах ажиллагааны гүйцэтгэл</li><li>• Хөтөлбөр, төсөл арга хэмжээний гүйцэтгэл, үр дүн</li></ul>
<b>Аудитын арга зүй:</b>	Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-д заасан арга зүйг ашиглан холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга болон судалгаа авах, харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх зэрэг аудитын арга зүйг ашиглан аудитын хөтөлбөрт дурдсан хугацаанд шалгах хуудсаар нотлох зүйл цуглуулж, аудитын дүгнэлт, зөвлөмжийг боловсруулав.
<b>Хамрах хүрээ:</b>	Аудитад Өмнөговь аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, 2024 оны хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжилт, аймгийн төсвийн орлого, зарлагын гүйцэтгэл, татварын зарлагыг хуулийн этгээд, салбар бүрээр, холбогдох эрх зүйн үндэслэл, худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэл, хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулсан төсөв, хүрсэн үр дүн, түүний танилцуулга болон бусад шаардлагатай баримт материалд тулгуурлан гүйцэтгэв.
<b>Аудит хийсэн багийн бүрэлдэхүүн, хугацаа</b>	Аудитыг Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Ц.Өсөхбаяр удирдаж, аудитын менежер Т.Хонгорзул арга зүйгээр хангаж, ахлах аудитор С.Одончимэг, аудитор Т.Будсүрэн, О.Чойдорж нар 2025 оны 04 дүгээр сарын 01-ны өдрөөс 2025 оны 04 дүгээр сарын 21-ний өдөр хүртэл хугацаанд гүйцэтгэлээ.

**БҮЛЭГ 1 Төсвийн төсөл боловсруулахад олон нийтийн оролцоог хангаж ажиллаагүй байна.**

1.1 Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 2/3 дугаар тогтоолоор Өмнөговь аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийг баталсан байна.

1.2 Аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд тусгасан зорилт, арга хэмжээний санхүүжилтийг жил бүрийн хөгжлийн жилийн төлөвлөгөө, төсөвт тусган үр дүнтэй хэрэгжүүлж ажиллахыг аймгийн Засаг даргад даалгасан байна.

1.3 Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 4/02 дугаар тогтоолоор “Өмнөговь аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн хэрэгжилтийн явцыг 89.2 хувийн биелэлттэй “Тодорхой үр дүнд хүрсэн” гэж дүгнэсэн байна.

1.4 Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 2/4 дүгээр тогтоолоор Өмнөговь аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны “Нутгийн хишиг хөтөлбөр”-ийг баталсан бөгөөд 2024 оны хэрэгжилтийг 87.4 хувийн биелэлттэй “Тодорхой үр дүнд хүрсэн” гэж дүгнэсэн байна.

1.5 Өмнөговь аймгийн ИТХ-ын 2023 оны 15/09 дугаар тогтоолоор "Аймгийн 2024 оны хөгжлийн жилийн төлөвлөгөө"-г хавсралтаар баталсан байна.

Хүснэгт №1 Төлөвлөгөөг салбарын ангилалаар:

Салбарын ангилал	Төлөвлөсөн арга хэмжээний		2024 онд санхүүжүүлэх дүн
	Тоо	Төсөвт өртөг	/сая төгрөг/
Хүний хөгжлийн бодлого	97	185,353.1	144,108.8
Эдийн засгийн бодлого	112	518,833.5	473,016.0
Салбарын хяналт	3	274.5	274.5
Цахим Өмнөговь төрийн шуурхай үйлчилгээ	48	39,125.3	31,565.7
Байгаль орчны бодлого	15	31,143.7	29,481.2
<b>Нийт дүн</b>	<b>275</b>	<b>774,730.3</b>	<b>678,446.4</b>

Эх сурвалж: Өмнөговь аймгийн 2024 оны хөгжлийн жилийн төлөвлөгөө

1.6 Өмнөговь аймгийн ИТХ-ын 2024 оны 03/10 дугаар тогтоолоор "Аймгийн 2024 оны хөгжлийн жилийн төлөвлөгөө"-ний хэрэгжилтийг 85 хувь буюу “тодорхой үр дүнд хүрсэн” гэж дүгнэсэн байна.

1.7 Өмнөговь аймгийн 2024 оны хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжилт дараах байдалтай байна.

Хүснэгт №2 Аймгийн хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн үнэлгээ

Салбарын нэр	Нийт заалт	Хэрэгжилтийн хувь								Дундаж хувь
		0	30	50	60	70	80	90	100	
Нэг.Хүний хөгжлийн бодлого										
Эрүүл мэндийн бодлого	15	1	1	1			2	9	1	77.3
Биеийн тамир, спорт	9		1	2		2			4	74.4
Боловсролын салбарын бодлого	31	4	2	2		1		12	10	73.2
Шинжлэх ухаан технологи, инновац	7							2	5	97.1
Хөдөлмөр, нийгэм хамгаалал	21	1		2		4		4	10	82.9
Үндэсний бахархал өв соёл	14			1		1			12	94.3
<b>Дүн</b>	<b>97</b>	<b>6</b>	<b>4</b>	<b>8</b>	<b>0</b>	<b>8</b>	<b>2</b>	<b>27</b>	<b>42</b>	<b>83.2</b>

Өмнөговь аймгийн Засаг даргын 2024 оны нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Хоёр.Эдийн засгийн бодлого										
Санхүү, төсвийн зохицуулалт	16		2	1				2	11	91.3
Уул уурхай, хүнд үйлдвэр	10			1				1	8	94.0
Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэр	19	2		1		2		5	9	81.1
Аялал жуулчлал	4				1				3	85.0
Эрчим хүч	13		3					5	5	90.8
Тээвэр логистик	18	1	4	1			1	3	8	76.5
Газрын харилцаа, хот байгуулалт	8	1						5	2	83.8
Барилга, нийтийн аж ахуй	11		1			4		2	4	81.4
Худалдаа үйлчилгээ	6			1				1	4	90.0
Хөгжлийн бодлого, хөрөнгө оруулалт	7	1	1					1	4	74.3
<b>Дүн</b>	<b>112</b>	<b>5</b>	<b>11</b>	<b>5</b>	<b>1</b>	<b>6</b>	<b>1</b>	<b>25</b>	<b>58</b>	<b>84.8</b>
Гурав.Салбарын хяналт										
Салбарын хяналт	3							1	2	96.7
<b>Дүн</b>	<b>3</b>							<b>1</b>	<b>2</b>	<b>96.7</b>
<b>Дөрөв. Цахим Монгол, Цахим Өмнөговь төрийн шуурхай үйлчилгээ</b>										
Цахим Монгол, Цахим Өмнөговь төрийн шуурхай үйлчилгээ	4		1			1			2	82.5
Мэргэшсэн, хариуцлагатай төрийн алба	8								8	100
Амар тайван, аюулгүй нийгэм	24		2	1		2		1	18	90.4
Хараат бус, бие даасан шүүх, хүний эрхийг дээдэлсэн эрхзүйн шинэтгэл	4							2	2	97.5
Тогтвортой, нэгдмэл гадаад бодлого	1								1	100
Батлан хамгаалах	7								7	100
<b>Дүн</b>	<b>48</b>	<b>0</b>	<b>3</b>	<b>1</b>	<b>0</b>	<b>3</b>	<b>0</b>	<b>3</b>	<b>38</b>	<b>95.1</b>
Тав. Байгаль орчны бодлого										
Байгаль орчны бодлого	15		1	1		1		4	8	87.7
<b>Дүн</b>	<b>15</b>	<b>0</b>	<b>1</b>	<b>1</b>	<b>0</b>	<b>1</b>	<b>0</b>	<b>4</b>	<b>8</b>	<b>87.7</b>
<b>ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ДУНДАЖ БИЕЛЭЛТ</b>	<b>275</b>	<b>11</b>	<b>19</b>	<b>15</b>	<b>1</b>	<b>18</b>	<b>3</b>	<b>60</b>	<b>148</b>	<b>85.0</b>

Эх сурвалж: Өмнөговь аймгийн 2024 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилт

1.8 Аймаг хөгжүүлэх 2024 оны жилийн төлөвлөгөөнд 275 арга хэмжээг төлөвлөж, гүйцэтгэлээр 275 арга хэмжээг тайлагнаснаас хэрэгжээгүй 11, 30 хувьтай хэрэгжсэн 19, 50 хувьтай хэрэгжсэн 15, 60 хувьтай хэрэгжсэн 1, 70 хувьтай хэрэгжсэн 18, 80 хувьтай хэрэгжсэн 3, 90 хувьтай хэрэгжсэн 60, бүрэн хэрэгжсэн 148 ажил байна гэж үзжээ.

1.9 Төсвийн ерөнхийлөн захирагчийн хөгжлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх, төсвийг боловсруулж, батлуулахад Төсвийн тухай хуулийн 28<sup>1</sup> дүгээр зүйлд заасныг хэрэгжүүлэн олон нийтийн оролцоог хангаж ажиллаагүй байна.

1.10 УИХ-ын 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн 64 дүгээр тогтоолоор баталсан Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд бүсчлэлийн тогтолцоогоор Өмнөговь аймаг нь “Говийн бүс”-д хамаарч байна.

1.11 Бүсийн хөгжлийн зорилгыг Бүгд Найрамдах Хятад Ард Улс болон Өмнөд Азийн орнуудтай эдийн засгийн харилцааг өргөжүүлж, өндөр технологи бүхий уул уурхай, хүнд үйлдвэрлэлээр дагнан төрөлжсөн говийн унаган байгаль, түүх, соёлын өв, палеонтологийн нөөцөд түшиглэсэн аялал жуулчлал хөгжсөн “Үндэсний баялагийн санг бүрдүүлэгч бүс” болно гэж тодорхойлжээ.

1.12 Энэ зорилгын хүрээнд 39 зорилгыг дэвшүүлсэн бөгөөд үүний 48.7 хувийг Өмнөговь аймагт хэрэгжүүлэхээр тусгасан байна.

1.13 Бүсчилсэн хөгжлийн бодлоготой уялдуулан Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан дараах ажлуудыг Өмнөговь аймаг хөгжлийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Даланзадгад суманд Олон Улсын 4D ангилалтай нисэх буудал барих- Нийт 400 сая төгрөгөөр "Гурвансайхан нисэх онгоцны буудлыг Олон улсын 4DE зэрэглэлийн онгоцны буудал болгох" ажлын зураг төсөв хийгдэж, 2022 оны 12 сарын 12 нд экспертизээр батлагдсан, 2528/2022 дугаар магадлалын дүгнэлт гаргуулсан байна. "Гурвансайхан" нисэх буудалд цагт 500 зорчигчид үйлчлэх хүчин чадалтай зорчигч үйлчилгээний барилга, нислэг хөдөлгөөний цамхаг, бусад инженерингийн барилга байгууламжийг барих 127,221.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлыг 2024-2026 онд хэрэгжүүлэхээр төсөвт тусгасан байна.

- Даланзадгад суманд 50 мВт-ын хүчин чадалтай дулааны цахилгаан станц барих- Эрчим хүчний сайд болон аймгийн Засаг даргын хамтарсан захирамжаар уг төслийг хэрэгжүүлэх ажлын хэсэг томилогдон төлөвлөгөө боловсруулсан байна. Орон нутгийн бонд гаргах бэлтгэл ажлыг хангах, холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллах төсөл арга хэмжээний хүрээнд орон нутгийн төсвөөс 85.5 сая төгрөг зарцуулсан байна.

- Даланзадгад – Гурвантэс чиглэлийн 80 км автозам барих- "Даланзадгадаас Сэврэй, Ноён, Гурвантэс чиглэлийн хатуу хучилттай автозамын" трасст орсон үлдэгдэл 80 км шороон замын зураг төсөв 50.0 сая төгрөгөөр хийгдсэн байна. 2023 оны 10 сард экспертизээр батлагдсан, 231/2023 дугаар магадлалын дүгнэлттэй. Авто замын трасс 302 км, 2024 оны сүүлийн байдлаар 224 км авто зам баригдаж ашиглалтад орсон ба 80 км шороон зам үлдсэн байна. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 онд 82,446.6 сая төгрөгөөр Даланзадгад-Баяндалай-Гурвантэс чиглэлийн авто замыг үргэлжлүүлэн 50 км авто зам тавигдсан байна.

- Даланзадгад -Булган-Мандал-Овоо-Өвөрхангай, Даланзадгад-Булган-Мандал-Овоо чиглэлийн авто замын 197 км авто замын зураг төсөв хийгдсэн. 81/2023 дугаартай дүгнэлтээр баталгаажсан байна. Даланзадгад-Булган чиглэлийн хатуу хучилттай 5 км авто зам, Булган-Даланзадгад чиглэлийн 5 км авто замын ажлыг тус тус улсын комисс хүлээн авч орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаас 17,501.6 сая төгрөгийн хөрөнгө зарцуулсан байна.

- Тэрбум мод үндэсний хөдөлгөөн - Орон нутгийн төсвийн хөрөнгөөр Байгаль хамгаалах чиглэлээр 2024 онд санхүүжих төсөл арга хэмжээний жагсаалтад цөлжилт бууруулах, ойн мастер төлөвлөгөөг хэрэгжүүлэх, Тэрбум мод үндэсний хөдөлгөөнийг өрнүүлэхэд орон нутгийн төсвөөс 2,319.3 сая төгрөг зарцуулсан байна.

Зохион байгуулсан ажлуудаас дурдвал:

- "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөн, аймгийн "Ойн менежментийн мастер төлөвлөгөө"-ний хүрээнд бүх нийтээр мод тарих арга хэмжээг 2024 оны 05, 10 дугаар саруудад зохион байгуулж төр, хувийн хэвшлийн 11,000 орчим иргэн, аж ахуйн нэгж хамрагдаж, 630 мянга орчим мод тарьсан

- Даланзадгад сумын 618.7 га таримал ойн хөнөөлт шавжийн тэмцлийн ажлыг хийсэн.

- "Өмнөговь-Ногоон хэрэм" трансн дагуу Даланзадгад, Ханхонгор сумдын нутагт 100 га талбайд ойн зурвас байгуулсан.

- Мандал-Овоо сумын Онгийн гол, Сэврэй сумын Хонгорын гол, Гурвантэс сумын Баруун голд тус бүр 2 га талбайг бургасаар ойжуулсан,

Өмнөговь аймгийн Засаг даргын 2024 оны нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

- Төвийн бүсийн ойн ангийг мод тарих ажилд ашиглах 90 морины хүчтэй олон үйлдэлт трактор болон бага оврын механизмаар хангасан,
- Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 199 дүгээр тогтоолын дагуу мод тарьж ургуулсан 300 орчим иргэдийг урамшуулалд хамруулсан,
- Онцгой байдлын газрын ойн зурвасыг хашаажуулах, худаг гаргах, дэд бүтэц татах ажил бүрэн хийгдсэн,
- Ханхонгор сумын төвийн Өлзийтийн аманд услалтын систем суурилуулсан байна.

1.14 Монгол Улсын Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт нийцүүлэн Өмнөговь аймгийг хөгжүүлэх бодлогын баримт бичгүүдэд дээрх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг тусгаж, хэрэгжилтийг хангаж ажилласан байна.

1.15 Өмнөговь аймгийн 2025 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөнд бүсчилсэн хөгжлийн бодлогийн хүрээнд 22 төсөл, арга хэмжээг 7,168.4 сая төгрөгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

**БҮЛЭГ 2 Төсвийн орлогыг бодит тооцоо судалгаанд үндэслээгүй нь орлогын төлөвлөгөө тасрах нөхцөлийг үүсгэсэн байна.**

2.1 Ерөнхийлөн захирагчийн 2024 оны төсвийг Төсвийн тухай хуулийн 57.<sup>1</sup>, 58 дугаар зүйлийн 58.<sup>2</sup>, Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар баталсан "Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах" журам, аймгийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, өмнөх оны гүйцэтгэл болон Төсвийн тухай хууль, татварын хууль тогтоомжийн хүрээнд тус тус төлөвлөжээ.

2.2 Орон нутгийн төсвийн суурь орлогыг Сангийн яамнаас 1,549,273.8 сая төгрөгөөр хянасныг Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35.1.9<sup>3</sup>-д заасан бүрэн эрхийн хүрээнд Өмнөговь аймгийн ИТХ-ын 2023 оны 15/11 дугаар "2024 төсөв батлах тухай" тогтоол, сумдын ИТХ-ын тогтоолоор 1,561,976.2 сая төгрөг болгон нэмэгдүүлэн баталсан байна.

2.3 Тайлант хугацаанд Төсвийн тухай хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1.2<sup>4</sup>-д заасны дагуу Өмнөговь аймгийн ИТХ-ын 2024 оны 19/28 дугаар "2024 оны төсвийн тодотгол батлах тухай" тогтоолоор ХХОАТ-ыг 9,999.4 сая, ААНОАТ-ыг 438,579.3 сая, ҮХЭХАТ-ыг 31,802.6 сая, АТБӨЯХАТ-ыг 600.0 сая, татварын бус орлогыг 40,575.1 сая, ОНХС-ийн шилжүүлсэн орлогыг 2,131.0 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлэн зарим орлогыг бууруулан аймаг, сумдын нийт төсвийн орлогыг 2,081,354.4 сая төгрөг байхаар тодотгон баталсан байна.

2.4 Аймаг, сумдын ИТХ-аар баталсан 2024 оны төсвийн нийт орлогын төлөвлөлт дараах байдалтай байна.

Хүснэгт №3 Аймгийн нийт орлогын төлөвлөлт

/сая төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	2024 он		
		Сангийн яам хянасан дүн	Анх батлагдсан	Тодотгосон төсөв
Б	1	2	3	4
<b>НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН</b>	1,085,786.0	1,549,273.8	1,561,976.2	2,081,354.4
ТАТВАРЫН ОРЛОГО	894,599.0	1,410,692.8	1,385,998.9	1,864,802.1

<sup>1</sup> Орон нутгийн төсөв

<sup>2</sup> Орон нутгийн чиг үүргийг санхүүжүүлэх

<sup>3</sup> Засаг даргын өргөн мэдүүлснээр тухайн аймаг, сум, нийслэл, дүүргийн төсвийг хэлэлцэж батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах, гүйцэтгэлийг батлах

<sup>4</sup> тухайн жилийн төсөв, түүний тодотголын төслийг хэлэлцэн батлах, хэрэгжилтэд хяналт тавих, нийтэд мэдээлэх

Өмнөговь аймгийн Засаг даргын 2024 оны нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Орлогын албан татвар	664,777.4	1,213,073.0	1,154,603.8	1,603,054.8
Хувь хүний орлогын албан татвар	211,130.3	195,073.0	218,543.1	228,542.5
Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрх	181,988.9	178,373.0	203,401.6	213,282.7
Үйл ажиллагааны орлого	1,887.8	2,100.0	2,160.5	2,045.1
Хөрөнгийн орлого	1,684.8	1,550.0	1,558.0	1,810.5
Хөрөнгө борлуулсны орлого	179.7	650.0	343.0	1,043.8
Шууд бус орлого	25,389.1	12,400.0	11,080.0	10,360.4
Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(1,663.5)	(2,000.0)	(2,010.0)	(2,137.8)
ААН-ын орлогын албан татвар	455,310.6	1,020,000.0	938,070.7	1,376,650.1
ААН-ын орлогын албан татвар	455,310.6	1,020,000.0	938,070.7	1,376,650.1
Хөрөнгийн албан татвар	173,906.7	161,932.3	182,810.1	215,125.5
Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	162,013.3	150,790.0	170,831.0	202,633.6
Бууны албан татвар	48.8	42.3	41.9	42.0
Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар	11,008.5	11,100.0	11,000.0	11,600.0
Малд ногдуулах албан татвар	836.0	-	937.2	849.9
Бусад татвар, төлбөр, хураамж	107,304.8	2,519.5	-	-
Бусад нийтлэг төлбөр, хураамж	3,770.3	2,519.5	3,886.5	3,156.8
Улсын тэмдэгтийн хураамж	786.7	506.5	472.0	934.4
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	2,363.8	1,500.0	2,889.5	1,747.7
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	619.7	513.0	525.0	474.7
Газрын төлбөр	17,307.4	13,318.0	15,836.0	14,357.5
Газрын төлбөр	13,203.9	12,568.0	13,336.0	14,007.5
Дуудлага худалдаа	4,103.5	750.0	2,500.0	350.0
Байгалийн нөөц ашигласны төлбөр	34,459.9	19,550.0	28,562.5	28,807.5
Ан амьтны нөөц ашигласны төлбөр	731.1	550.0	550.0	763.2
Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	33,728.8	19,000.0	28,012.5	28,044.3
Бусад татвар	377.4	300.0	300.0	300.0
Бусад татвар	377.4	300.0	300.0	300.0
<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>158,318.7</b>	<b>138,511.0</b>	<b>129,987.3</b>	<b>163,111.3</b>
Хувьцааны ногдол ашиг	148,555.9	134,000.0	124,750.0	134,189.0
Торгуулийн орлого	4,800.4	3,433.7	3,615.5	17,037.9
Төсөв байгууллагын өөрийн орлого	3,502.4	45.0	-	10,362.5
Газрын тосны орлого	-	102.3	102.3	102.3
Түрээсийн орлого	116.1	80.0	89.4	90.4
Бусад орлого	1,344.0	850.0	1,430.1	1,329.2
<b>ХӨРӨНГИЙН ОРЛОГО</b>	<b>606.1</b>	<b>70.0</b>	<b>405.0</b>	<b>175.0</b>
Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй хөрөнгө борлуулсны орлого	606.1	70.0	405.0	175.0
<b>ХАНДИВ ТУСЛАМЖИЙН ОРЛОГО</b>	<b>4,000.0</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>5,550.0</b>
ОНХС-ийн хандив тусламж	4,000.0	-	-	5,550.0
Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	<b>28,262.2</b>	<b>-</b>	<b>45,585.0</b>	<b>47,716.0</b>
Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого	28,262.2	-	45,585.0	47,716.0

Эх сурвалж: Өмнөговь аймгийн Төсвийн Ерөнхийлөн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

2.5 Төсвийн нийт орлогыг өмнөх оны гүйцэтгэлээс 91.7 хувиар буюу 995,568.4 сая төгрөгөөр нэмэгдүүлэн төлөвлөсөн нь тооцоо судалгаанд үндэслэгдсэн эсэх нь тодорхойлогдохгүй, хэт өөдрөг, орлогын төлөвлөгөө биелэхгүй байх эрсдлийг үүсгэсэн байна.

2.6 Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулиар орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон улсын төсвөөс орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлгийг 47,716.0 сая төгрөг байхаар баталсан байна.

Өмнөговь аймгийн Засаг даргын 2024 оны нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2.7 Өмнөговь аймгийн ИТХ-ын 2024 оны 19/28 дүгээр тогтоол болон сумдын ИТХ-ын “2024 оны төсвийн тодотгол батлах тухай” тогтоолоор аймгийн төсөвт 2,081,354.4 сая төгрөгийн орлого төвлөрүүлэхээр баталж, гүйцэтгэлээр 1,879,083.5 сая төгрөгийн орлого төвлөрүүлэн батлагдсан төлөвлөгөөг 90.3 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт №4 Аймгийн төсвийн орлогын гүйцэтгэл

/сая төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны			
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Б	1	2	3	4=3-2	5=3/2
<b>НИЙТ ОРЛОГО</b>	1,085,786.0	2,081,354.4	1,879,083.5	-202,270.8	90.3
<b>А. Төсвийн орлого</b>	1,052,917.7	2,027,913.4	1,832,849.1	-195,064.3	90.4
<b>I.Татварын орлого</b>	894,599.0	1,864,802.1	1,647,808.0	-216,994.0	88.4
<b>II. Татварын бус орлого</b>	158,318.7	163,111.3	182,541.1	19,429.8	111.9
<b>Б. Хөрөнгийн орлого</b>	606.1	175.0	208.6	33.6	119.2
<b>В. Тусламж, санхүүжилтийн орлого</b>	32,262.2	53,266.0	48,525.8	-4,740.2	91.1

Эх сурвалж: Өмнөговь аймгийн Төсвийн Ерөнхийлөн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

2.8 Дээрх хүснэгтээс харахад аймгийн төсвийн нийт орлого өмнөх оноос 1.7 дахин өссөн ч татварын орлого 216,994.0 сая, тусламж санхүүжилтийн орлого 4,740.2 сая төгрөгөөр тус тус тасарсан байна.

2.9 Аймгийн нийт орлогын дүнд татварын орлого 87.7 хувь, татварын бус орлого 9.7 хувь, хөрөнгийн орлого 0.01 хувь, тусламж санхүүжилтийн орлого 2.6 хувийг тус тус эзэлж байна.

2.10 Тайлант онд аймгийн ИТХ-аас Татварын ерөнхий хуулийн 8 дугаар зүйлийн 8.1<sup>5</sup>, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35.1.10<sup>6</sup>-д заасан бүрэн эрхийн хүрээнд орон нутагт мөрдөгдөж буй төлбөр, хураамжид өөрчлөлт оруулаагүй байна.

2.11 Аймаг орон нутгийн зүгээс төсвийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах, орон нутгийн төсөв бүрдүүлэх, татварын бааз суурийг өргөжүүлэх, төсвийн орлогын төлөвлөгөөг биелүүлэх зорилгын хүрээнд олон талын арга хэмжээг зохион байгуулж ажилласан байна.

2.12 Аймгийн төсвийн орлогод төвлөрүүлсэн орлогын гүйцэтгэлийг татварын нэр төрлөөр авч үзвэл дараах байдалтай байна.

Хүснэгт №5 Төсвийн орлогын гүйцэтгэл татварын нэр төрлөөр

/сая төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	2024 оны		
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
Б	1	2	3	4=3-2
НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	1,085,786.0	2,081,354.4	1,879,083.5	(202,270.9)
ТАТВАРЫН ОРЛОГО	894,599.0	1,864,802.1	1,647,808.0	(216,994.1)
Орлогын албан татвар	664,777.4	1,603,054.8	1,394,468.3	(208,586.4)
Хувь хүний орлогын албан татвар	211,130.3	228,542.5	235,246.4	6,703.9
Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрх	181,988.9	213,282.7	215,185.3	1,902.6
Үйл ажиллагааны орлого	1,887.8	2,045.1	1,932.4	(112.7)
Хөрөнгийн орлого	1,684.8	1,810.5	2,451.8	641.3
Хөрөнгө борлуулсны орлого	179.7	1,043.8	1,124.3	80.5
Шууд бус орлого	25,389.1	10,360.4	14,461.5	4,101.1
Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(1,663.5)	(2,137.8)	(2,139.0)	(1.2)

<sup>5</sup> Татварын хувь, хэмжээг Улсын Их Хурал, түүний эрх олгосноор Засгийн газар болон аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, хотын Зөвлөл хууль тогтоомжийн дагуу тус тус тогтооно.

<sup>6</sup> хуулиар тогтоосон хязгаарын хүрээнд албан татвар, төлбөр, хураамжийн хувь хэмжээг тогтоох

Өмнөговь аймгийн Засаг даргын 2024 оны нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(1,663.5)	(2,137.8)	(2,139.0)	(1.2)
ААН-ын орлогын албан татвар	455,310.6	1,376,650.1	1,161,360.9	(215,289.1)
ААН-ын орлогын албан татвар	455,310.6	1,376,650.1	1,161,360.9	(215,289.1)
Хөрөнгийн албан татвар	173,906.7	215,125.5	204,426.3	(10,699.2)
Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	162,013.3	202,633.6	191,426.1	(11,207.5)
Бууны албан татвар	48.8	42.0	47.5	5.5
Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар	11,008.5	11,600.0	12,283.0	683.0
Малд ногдуулах албан татвар	836.0	849.9	669.7	(180.2)
Бусад татвар, төлбөр, хураамж	107,304.8	-	-	-
Бусад нийтлэг төлбөр, хураамж	3,770.3	3,156.8	3,567.8	411.0
Улсын тэмдэгтийн хураамж	786.7	934.4	1,332.6	398.2
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	2,363.8	1,747.7	1,613.5	(134.1)
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	619.7	474.7	621.7	147.0
Газрын төлбөр	17,307.4	14,357.5	15,249.8	892.3
Газрын төлбөр	13,203.9	14,007.5	14,599.8	592.3
Дуудлага худалдаа	4,103.5	350.0	650.0	300.0
Байгалийн нөөц ашигласны төлбөр	34,459.9	28,807.5	29,790.4	982.9
Ан амьтны нөөц ашигласны төлбөр	731.1	763.2	563.3	(200.0)
Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	33,728.8	28,044.3	29,227.2	1,182.9
Бусад татвар	377.4	300.0	396.4	96.4
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	158,318.7	163,111.3	182,541.1	19,429.8
Хувьцааны ногдол ашиг	148,555.9	134,189.0	150,304.6	16,115.6
Торгуулийн орлого	4,800.4	17,037.9	19,654.1	2,616.2
Төсөв байгууллагын өөрийн орлого	3,502.4	10,362.5	6,258.2	(4,104.2)
Газрын тосны орлого	-	102.3	99.3	(3.0)
Түрээсийн орлого	116.1	90.4	134.0	43.6
Бусад орлого	1,344.0	1,329.2	6,090.7	4,761.5
ХӨРӨНГИЙН ОРЛОГО	606.1	175.0	208.6	33.6
Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй хөрөнгө борлуулсны орлого	606.1	175.0	208.6	33.6
ХАНДИВ ТУСЛАМЖИЙН ОРЛОГО	4,000.0	5,550.0	2,500.0	(3,050.0)
Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	4,000.0	5,550.0	2,500.0	(3,050.0)
Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	28,262.2	47,716.0	46,025.8	(1,690.2)
Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого	28,262.2	47,716.0	46,025.8	(1,690.2)

Эх сурвалж: Өмнөговь аймгийн Төсвийн Ерөнхийлөн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

2.13 Аймгийн нийт орлогын төлөвлөгөө 202,270.9 сая төгрөгөөр тасарсан нь орон нутгийн төсвийн суурь орлогыг Сангийн яамнаас өндөр төлөвлөсөнтэй холбоотой байна.

2.14 Аймгийн төсвийн орлогын гүйцэтгэлийг аймаг, сумдаар харуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт №6 Төсвийн орлогын гүйцэтгэл аймаг, сумдаар

/сая төгрөг/

Д/д	Сумын нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Баяндалай	1,614.8	1,395.6	(219.2)	86.4
2	Баян-Овоо	3,579.7	3,637.9	58.2	101.6
3	Булган	1,180.9	1,259.7	78.8	106.7
4	Гурвантэс	36,682.8	40,008.2	3,325.4	109.1
5	Даланзадгад	33,707.4	42,778.7	9,071.3	126.9
6	Мандал-Овоо	1,101.2	1,413.7	312.5	128.4
7	Манлай	2,813.3	2,538.1	(275.2)	90.2
8	Ноён	4,234.1	5,498.1	1,264.0	129.9

Өмнөговь аймгийн Засаг даргын 2024 оны нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

9	Номгон	2,533.9	2,860.4	326.5	112.9
10	Сэврэй	1,349.4	1,589.4	240.0	117.8
11	Ханбогд	331,420.3	296,486.0	(34,934.3)	89.5
12	Ханхонгор	3,407.8	3,363.2	(44.6)	98.7
13	Хүрмэн	1,934.5	1,913.8	(20.7)	98.9
14	Цогт-Овоо	1,603.1	1,659.4	56.3	103.5
15	Цогтцэций	68,793.2	84,785.4	15,992.2	123.2
16	Аймаг	1,585,398.0	1,387,881.5	(197,516.5)	87.5
	Нийт дүн	2,081,354.4	1,879,083.5	(202,270.9)	90.3

Эх сурвалж: Санхүү төрийн сангийн хэлтэс

2.15 Дээрх хүснэгтээс харахад төсвийн орлогын төлөвлөгөөг Баяндалай, Манлай, Ханбогд, Ханхонгор, Хүрмэн, аймгийн төрийн сан тус тус тасалсан байна.

2.16 Сангийн сайдын 2023 оны 33 дугаар тушаалаар баталсан “Татварын улсын байцаагчид ажлын үр дүнгийн шагнал олгох журам”-ын дагуу Өмнөговь аймгийн Татварын газрын улсын байцаагчид ТЕГ-ын шийдвэрийн дагуу тайлант онд нийт 226.6 сая төгрөгийн урамшуулал авсан байна.

2.17 Өмнөговь аймгийн Татварын газар нь аймгуудаас улсын төсөвт төвлөрүүлэх орлогын 38.3 хувь, аймаг, нийслэлийн төсөвт төвлөрүүлэх орлогын 87.8 хувь, сум дүүргийн төсөвт төвлөрүүлэх орлогын 41.5 хувийг тус тус бүрдүүлсэн байна.

2.18 Гэсэн хэдий ч орлогын төлөвлөгөө биелүүлж, албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргээ хэрэгжүүлсний төлөө олгож буй энэ урамшуулал нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4<sup>7</sup>, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1<sup>8</sup>-д заасантай тус тус нийцэхгүй байна.

2.19 Өмнөговь аймгийн ИТХ-ын 2024 оны 19/28 дугаар “2024 оны төсвийн тодотгол батлах тухай” тогтоолоор Гурвантэс сум 26,689.0 сая, Ханбогд сум 272,577.9 сая, Цогтцэций сум 50,633.5 сая, Даланзадгад сум 4,079.3 сая төгрөгийг тус тус аймгийн төсөвт төвлөрүүлэхээр баталсан байна.

2.20 Сумдын суурь орлогыг бодитой төвлөөгүйгээс үндсэн тэнцлийн ашгаас дээд шатны төсөвт төвлөрүүлэх орлого бүрэн төвлөрөөгүй байна.

Хүснэгт№7 Сумдаас аймгийн төсөвт төвлөрүүлсэн орлого

/сая төгрөг/

Д/д	Сумдын нэр	Батлагдсан төсөв	Төвлөрүүлсэн дүн	Зөрүү дүн	Хувь
1	Гурвантэс	26,689.04	26,689.04	0.0	100.0
2	Ханбогд	272,577.90	198,063.72	-74,514.2	72.7
3	Цогтцэций	50,633.52	50,193.52	-440.0	99.1
4	Даланзадгад	4,079.32	4,079.32	0.0	100.0
	<b>Дүн</b>	<b>353,979.78</b>	<b>279,025.60</b>	<b>- 74,954.18</b>	<b>78.8</b>

Эх сурвалж: Санхүү төрийн сангийн хэлтэс

2.21 Ханбогд, Цогтцэций сумууд орлого бүрэн төвлөрүүлээгүйгээс дээд шатны төсөвт төвлөрүүлэх орлого 78.8 хувийн гүйцэтгэлтэй байна.

Татварын орлогын талаар:

2.22 Орон нутгийн төсвийн суурь орлогыг Сангийн яамнаас 1,549,273.8 сая төгрөгөөр хянасан байна.

2.23 Үүнээс аж ахуй нэгжийн орлогын албан татварын суурь орлогыг 1,020,000.0 сая төгрөг байхаар хянаж, улсын төсөвт төвлөрүүлэх шилжүүлгийг өмнөх оноос 3.1 дахин есгөж 1,419,975.6 сая төгрөгөөр тооцож Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулиар баталсан байна.

<sup>7</sup> хуулиар зөвшөөрөөгүй бусад.

<sup>8</sup> төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;

2.24 Аймгийн ИТХ-аас орон нутгийн чиг үүргийг хэрэгжүүлэх төсвийн эх үүсвэр бүрдүүлэхийн тулд сангийн яам хянасан аж ахуй нэгжийн орлогын албан татварын 40 хувийн орлогын дүнг 356,650.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан байна.

2.25 ААНОАТ-ын 40 хувийн хуваарилалтын 2024 оны гүйцэтгэл 1,161,360.9 сая төгрөг болж өмнөх оноос 2.6 дахин нэмэгдсэн байна.

*Хүснэгт №8 ААНОАТ-ийн дахин хуваарилалт*

*/сая төгрөг/*

Он	2023 он	2024 он	Өсөлтийн хувь
Татвар төлөгчийн тоо	2615	4042	54.6
ААНОАТ-аар дахин хуваарилагдсан дүн	568,855.5	1,161,360.9	104.2

*Эх сурвалж: Өмнөговь аймгийн татварын газар*

2.26 Төсвийн орлого бүрдүүлэх чиглэлээр уул уурхайн болон тээврийн компаниуд тэдгээрийн туслан гүйцэтгэх аж ахуйн нэгжийн санхүүгийн болон гүйцэтгэх удирдлагыг хамруулсан үе шаттай арга хэмжээний үр дүнд ААНОАТ төлөгчийн тоо 54.6 хувиар, ААНОАТ-ын дахин хуваарилалтын орлого 104.2 хувиар тус тус өссөн байна.

2.27 Орон нутагт хуваарилагдсан орлого өссөн ч орлого нэмэгдүүлж баталсантай холбоотойгоор төлөвлөгөө 215,289.1 сая төгрөгөөр тасарсан байна.

2.28 Засгийн газрын 2024 оны 128 дугаар “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” тогтоолоор төрийн албан хаагчдын болон бусад салбаруудын цалин хөлс нэмэгдсэн, мөн төсвийн орлого бүрдүүлэх арга хэмжээнүүдийн үр дүнд татвар төлөгчдийн тоо нэмэгдсэн нь тус тус хувь хүний орлогын албан татварын орлогын төлөвлөгөө биелэхэд нөлөөлсөн байна.

2.29 Шууд бус орлого 4,113.5 сая төгрөгөөр давж биелсэн нь Эрдэнэс Тавантолгой ТӨХК хувьцааны ногдол ашгийн хуваарилсантай холбоотой байна.

2.30 Аймгийн ИТХ-аар баталсан 2024 оны тодотгосон төлөвлөгөөг Ханбогд сумын ИТХ-аас Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын төлөвлөгөөг батлахдаа тооцоо, судалгаагүйгээр хэт өндөр төлөвлөгөө баталснаас болж төлөвлөгөө тасрахад хүрсэн байна.

2.31 Байгаль орчны яамнаас тогтоосон квотын дагуу Баяндалай, Баян-Овоо, Мандал-Овоо, Манлай, Ноён, Номгон, Ханбогд, Хүрмэн сумдын төсвийн орлогод ан амьтны нөөц ашигласны төлбөрийн орлогод 563.3 сая төгрөг төвлөрсөн байна.

2.32 Үйлдвэр, үйлчилгээний усны төлбөр 1,182.9 сая төгрөгөөр давж биелсэн нь уул, уурхайн компаниудаас ус ашигласны төлбөрийг урьдчилан төлсөнтэй холбоотой байна.

2.33 Малын тоо толгойн орлогын албан татварыг сумын орон нутгийн төсөвт бүрэн төвлөрүүлж ажиллаагүйгээс 2024 оны эцэст 623.2 сая төгрөгийн татварын өр үлдэгдэлтэй бөгөөд тайлант оны орлогын төлөвлөгөөг 197.5 сая төгрөгөөр тасалсан байна.

2.34 Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийг 6.3-д “Малчны амьжиргааг дэмжих зорилгоор малчны өмчилж байгаа малын тоо толгойноос хамааран ногдох албан татварын хэмжээг 0 төгрөг байхаар тогтоож болно.” гэж заасныг үндэслэн Баяндалай, Баян-Овоо, Булган, Мандал-Овоо, Номгон, Сэврэй сумууд сумын ИТХ-ын тогтоолоор 2024 оны малын тоо толгойн албан татварыг тэглэсэн нь орлого бүрдүүлэлтэд нөлөөлсөн байна.

2.35 Малын тоо толгойн орлогын албан татварыг орон нутгийн төсөвт бүрэн төвлөрүүлээгүйгээс сумдад бэлчээрийн менежментийг сайжруулах, бэлчээрийн болон газар тариалангийн усан хангамжийг нэмэгдүүлэх, малын эрүүл мэндийг хамгаалах, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, малын чанарыг сайжруулах, гэмт халдлага, гамшгаас хамгаалах, хур тунадасны хэмжээг нэмэгдүүлэх, малын тэжээлийн ургамал тариалах, тэжээлийн нөөц бүрдүүлэх, байгаль орчныг хамгаалах, хортон мэрэгчидтэй

Өмнөговь аймгийн Засаг даргын 2024 оны нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан тэмцэх, малчдад зориулсан сургалт зэрэг малчдад зориулсан хөтөлбөр төсөл, арга хэмжээ хийгдээгүй байна.

2.36 Засгийн газрын 2023 оны 463 дугаар тогтоолоор баталсан “Авто зам, төмөр замын салбарт хэрэгжүүлэх зарим төсөл, хөтөлбөрт шаардагдах түгээмэл тархацтай ашигт малтмалыг хайх, ашиглах тусгай журам”-ын 5.3-д “Улсын болон орон нутгийн төсөв, гадаадын зээл тусламжийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих, авто зам, замын байгууламжийн барилга, их засвар, ээлжит засвар, арчлалтын ажилд ашиглах түгээмэл тархацтай ашигт малтмалын төлбөр тооцох борлуулалтын үнэлгээ нь нэг шоо метр тутамд 1 төгрөг байна” гэж заасны дагуу орон нутагт хийгдэж байгаа хатуу хучилттай зам барих ажилд ашиглагдаж байгаа түгээмэл тархацтай ашигт малтмалын төлбөр өмнөх жилээс буурсан байна.

2.37 Өмнөговь аймгийн Засаг даргын 2017 оны А/137 дугаар захирамж, аймгийн ИТХ-ын 2023 оны 10/4 дүгээр тогтоолоор орон нутгийн чанартай авто зам, замын байгууламжаар зорчих ӨМ серитэй тээврийн хэрэгслээс зам ашигласны төлбөр авах журам, хураамжийн хувь хэмжээ, төлбөр хураах цэгийн байршлыг батлан орон нутгийн замын санд 2024 онд 80.0 сая төгрөгийн орлого төвлөрсөн байна.

2.38 Орон нутгийн чанартай авто зам, замын байгууламж ашигласны төлбөрийг Өмнөговь аймгийн дугаартай тээврийн хэрэгслээс жилд 1 удаа авахаар заасан нь орон нутгийн чанартай авто замыг сэргээн засварлах, зам байгууламж барих, засварлах, арчилж хамгаалахад хүрэлцээгүй бөгөөд Улаанбаатар болон өөр аймгийн дугаартай тээврийн хэрэгсэлд уг журмын заалт үйлчилдэггүй байна.

2.39 Уул уурхайд ашиглагдаж байгаа том оврын тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөс шороон болон авто замд эвдрэл үүсэх, агаар бохирдуулж тоосжилт үүсгэх зэргээр байгаль орчин, эдийн засагт үзүүлж буй сөрөг нөлөөлөл асар их байгаа тул аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2011 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Уул уурхайн ачаа тээврийн үйл ажиллагааг зохицуулах журам” баталсан байна.

2.40 Уг журмын 2.5-д “Уул уурхай, нүүрсний олборлолт, тээвэрлэлтийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуй нэгж байгууллага, иргэд эзэмшилдээ байгаа авто тээврийн хэрэгслийг Өмнөговь аймгийн бүртгэлтэй болгох үүрэг хүлээнэ” гэж тусгасан бөгөөд хэрэгжилтийг хангуулах, зохих арга хэмжээг авч ажиллах шаардлагатай байна.

2.41 АТБӨЯХАТ-ын төлөвлөгөөг 683.0 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн ч 2024 оны эцсийн өрийн үлдэгдэл 1,563.7 сая төгрөг байгаа нь өмнөх онуудын тайлангаар ногдуулсан өр барагдуулалтын хувь хангалтгүй байгааг харуулж байна.

2.42 Аймгийн Татварын газраас ирүүлсэн мэдээлэлд татварын өрийн үлдэгдэл 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 98,744.8 сая төгрөг байна. Энэ нь том татвар төлөгчдөд татварын хяналт шалгалтаар ногдуулсан 87,474.9 сая төгрөгийн татварын торгууль, алдангитай холбоотой байна.

#### Татварын бус орлогын талаар:

2.43 Орон нутгийн өмчит "Тавантолгой" хувьцаат компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 2 дугаар сарын 21-ний өдрийн 03 дугаар тогтоолоор нэгж хувьцаанд ногдох ашгийг 4996 төгрөгөөр тогтоон орон нутгийн эзэмшлийн хувьцааны 51 хувьд 150,304.6 сая төгрөгийн ногдол ашиг хуваарилсан байна.

2.44 Төсөвт байгууллагын өөрийн орлогыг 39.6 хувиар буюу 4,104.2 сая төгрөгөөр тасалсан байна. Үүний 98.3 хувийг орон нутгийн хөрөнгө оруулалт дансны авлагын үлдэгдэл буюу аймгийн хэмжээнд хэрэгжүүлсэн 1000 айл орон сууц хөтөлбөрийн хүрээнд 2015 онд аж ахуй нэгж, иргэдэд олгосон зээлийн авлагын үлдэгдэл байна.

2.45 Уг зээлийг холбогдох аж ахуй нэгжээр төлүүлэхээр Өмнөговь аймаг дахь Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн захирамж 2017, 2018, 2019 онуудад гарсан боловч одоог хүртэл шийдвэрлэгдээгүй байна.

2.46 Төрийн аудитын байгууллагаас уг авлагыг төлүүлж, төсвийн орлого бүрдүүлж ажиллах талаар удаа дараа аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчид зөвлөмж, албан шаардлага өгч байгаа хэдий ч тодорхой үр дүнд хүрээгүй байна.

Тусламж санхүүжилтийн орлогын талаар:

2.47 Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 3.1.3-д "ОНХС-ийн орлогын шилжүүлгийг тус санг бүрдүүлдэг эх үүсвэрүүдийн орлогын гүйцэтгэлд үндэслэн шилжүүлэх" гэж заасан итгэлцүүрийн дагуу ОНХС-ийн санхүүжилтийг тооцсон байна.

2.48 Орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлгээр 46,025.8 сая төгрөг олгож, Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд зааснаас 1,690.2 сая төгрөгийн санхүүжилт дутуу олгосон байна.

2.49 Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2.9<sup>9</sup>-д заасны дагуу Орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрт 5,550.0 сая төгрөг төлөвлөснөөс Эрдэнэс тавантолгой ТӨХК-ийн хандивын орлого 2,500.0 сая төгрөг төвлөрсөн байна.

2.50 Эрдэнэс тавантолгой ТӨХК нь байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх, хандив, тусламж өгөх асуудлаар нутгийн захиргааны байгууллагатай гэрээ байгуулж ажилласан байна.

2.51 Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1<sup>10</sup> дэх заалтын хэрэгжилтийг хангуулснаар ОНХС-ийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх боломжтой байна.

2.52 Аймгийн төсвийн нийт орлого 1,879,083.5 сая төгрөг болж өмнөх оноос 1.7 дахин өссөн нь аж ахуйн нэгжийн орлогын дахин хуваарилалттай холбоотой байна.

**БҮЛЭГ 3 Төсвийн хөрөнгийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах шаардлагатай байна.**

3.1 Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35.1.9<sup>11</sup>-д гэж заасны дагуу хурлын бүрэн эрхийн хэмжээнд Сангийн яамнаас хянасан суурь зарлагыг Өмнөговь аймгийн ИТХ-ын 2023 оны 15/11 дугаар "2024 оны төсөв батлах тухай" тогтоол болон сумдын ИТХ-ын тогтоолоор төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны төсвийн нийт зарлагыг 377,614.9 сая төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан байна.

3.2 Тайлант хугацаанд Төсвийн тухай хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1.2<sup>12</sup>-д заасны дагуу Өмнөговь аймгийн ИТХ-ын 2024 оны 19/28 дугаар "2024 оны төсвийн тодотгол батлах тухай" тогтоол болон сумдын тодотгосон төсвийн тогтоолоор аймгийн нийт зарлагыг 423,208.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 2,296,856.3 сая төгрөгөөр тодотгон баталсан байна.

Хүснэгт №9 Орон нутгийн төсвийн зарлагын төлөвлөлт

/сая төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Сангийн яам хянасан дүн	2024 он		
			Анх батлагдсан	Тодотгосон төсөв	Зөрүү
Б	1	2	3	4	5=4-3
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	886,269.5	76,057.8	1,873,648.3	2,296,856.3	423,208.0

<sup>9</sup> Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлд заасан гэрээний дагуу тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нутгийн захиргааны байгууллагад өгсөн хандив, тусламж

<sup>10</sup> Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх, хандив, тусламж өгөх асуудлаар нутгийн захиргааны байгууллагатай гэрээ байгуулж ажиллана.

<sup>11</sup> Засаг даргын өргөн мэдүүлснээр тухайн аймаг, сум, нийслэл, дүүргийн төсвийг хэлэлцэж батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах, гүйцэтгэлийг батлах;

<sup>12</sup> тухайн жилийн төсөв, түүний тодотголын төслийг хэлэлцэн батлах, хэрэгжилтэд хяналт тавих, нийтэд мэдээлэх

Өмнөговь аймгийн Засаг даргын 2024 оны нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

УРСГАЛ ЗАРДАЛ	650,374.1	73,664.0	1,229,695.5	1,709,099.1	479,403.6
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	158,247.1	71,122.3	225,532.7	219,577.5	(5,955.2)
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	17,522.5	15,808.7	30,470.3	29,968.5	(501.9)
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,208.2	1,976.1	3,798.9	3,761.3	(37.6)
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	10,036.1	13,820.1	16,935.0	17,188.4	253.4
Хангамж, бараа материалын зардал	2,959.4	1,260.4	3,654.5	3,901.8	247.2
Нормативт зардал	234.1	101.7	409.6	391.0	(18.5)
Эд хогшил, урсгал засварын зардал	2,597.0	673.3	3,378.2	4,480.7	1,102.5
Томилолт, зочны зардал	319.7	392.7	535.0	571.4	36.3
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	22,188.2	25,809.5	37,478.4	37,761.0	282.6
Бараа үйлчилгээний бусад зардал	100,181.9	11,279.8	128,872.8	121,553.4	(7,319.4)
ХҮҮ	-	433.7	-	-	-
Гадаад зээлийн үйлчилгээний төлбөр	-	433.7	-	-	-
ТАТААС	154.0	56.2	159.0	144.0	(15.0)
Төрийн өмчит байгууллагад олгох татаас	-	56.2	-	-	-
Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	154.0	-	159.0	144.0	(15.0)
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	491,972.9	2,051.8	1,004,003.8	1,489,377.6	485,373.9
Засгийн газрын урсгал шилжүүлэг	491,012.0	-	1,001,456.3	1,486,442.6	484,986.3
Бусад урсгал шилжүүлэг	960.9	2,051.8	2,547.5	2,935.0	387.5
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	235,895.5	2,393.8	643,952.8	587,757.2	(56,195.6)
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	-	-	-	-	-
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	899,562.3	76,057.8	1,873,648.3	2,296,856.3	423,208.0
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	28,262.2	-	45,585.0	47,716.0	2,131.1
Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	28,262.2	-	45,585.0	47,716.0	2,131.1
ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	863,797.7	76,012.8	1,805,302.1	2,221,375.6	416,073.5
Орон нутгийн төсвөөс	863,797.7	76,012.8	1,805,302.1	2,221,375.6	416,073.5
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	3,502.4	45.0	9,742.9	10,362.5	619.6
ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ	4,000.0	-	5,550.0	5,550.0	-
БУСАД ЭХ ҮҮСВЭР	-	-	7,468.4	11,852.2	4,383.8

Эх сурвалж: Өмнөговь аймгийн ТЕЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

3.3 Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн зарлагын санхүүжилтийн эх үүсвэрийн 2.1 хувийг улсын төсвөөс, 97.9 хувийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр тус тус төлөвлөсөн байна.

3.4 Төсвийн нийт зарлагыг өмнөх оны гүйцэтгэлээс 2.6 дахин нэмэгдүүлэн баталсан нь улсын төсөвт төвлөрүүлэх орлого болон уул уурхайн үйл ажиллагаа жигдэрч аж ахуйн нэгжийн орлогын дахин хуваарилалтын орлого нэмэгдсэнтэй холбоотой байна.

3.5 Сангийн яамнаас хүргүүлсэн Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2024 оны төсвийн төсөл бэлтгэх удирдамжид заасан ТЕЗ-ийн харьяанд хамаарах хуулийн зохицуулалтгүй Байгаль хамгаалах санг тусдаа дансанд төсөвлөхгүй байх чиглэлийг хэрэгжүүлээгүй байна.

**ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ГҮЙЦЭТГЭЛ**

3.6 Өмнөговь аймгийн ИТХ-ын 2024 оны 19/28 дугаар “2024 оны төсвийн тодотгол батлах тухай” тогтоол болон сумдын тодотгосон төсвийн тогтоолоор аймгийн нийт зарлагыг 2,296,856.3 сая төгрөгөөр баталж гүйцэтгэлээр 1,904,419.0 сая төгрөгийг зарцуулж, төсвийн гүйцэтгэл 82.9 хувьтай байна.

Хүснэгт №10 Орон нутгийн төсвийн зарлагын гүйцэтгэл

/сая төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны төлөвлөгөө	Тайлант оны гүйцэтгэл	Зөрүү +/-
<b>Б</b>	<b>1</b>	<b>2</b>	<b>3</b>	<b>4=3-2</b>
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	886,269.5	2,296,856.3	1,904,419.0	392,437.3
УРСГАЛ ЗАРДАЛ	650,374.1	1,709,099.1	1,459,311.9	249,787.2
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	158,247.1	219,577.5	170,374.4	49,203.0
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	17,522.5	29,968.5	27,201.4	2,767.1
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,208.2	3,761.3	3,392.5	368.8
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	10,036.1	17,188.4	15,038.3	2,150.1
Хангамж, бараа материалын зардал	2,959.4	3,901.8	3,383.1	518.7
Нормативт зардал	234.1	391.0	314.6	76.4
Эд хогшил, урсгал засварын зардал	2,597.0	4,480.7	3,607.3	873.5
Томилолт, зочны зардал	319.7	571.4	461.6	109.7
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	22,188.2	37,761.0	25,348.3	12,412.7
Бараа үйлчилгээний бусад зардал	100,181.9	121,553.4	91,627.3	29,926.1
ХҮҮ	-	-	-	-
Гадаад зээлийн үйлчилгээний төлбөр	-	-	-	-
Дотоод зээлийн үйлчилгээний төлбөр	-	-	-	-
ТАТААС	154.0	144.0	119.0	25.0
Төрийн өмчит байгууллагад олгох татаас	-	-	-	-
Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	154.0	144.0	119.0	25.0
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	491,972.9	1,489,377.6	1,288,818.4	200,559.2
Засгийн газрын урсгал шилжүүлэг	491,012.0	1,486,442.6	1,286,303.6	200,139.1
Бусад урсгал шилжүүлэг	960.9	2,935.0	2,514.8	420.2
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	235,895.5	587,757.2	445,107.1	142,650.1
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	-	-	-	-
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	<b>899,562.3</b>	<b>2,296,856.3</b>	<b>1,926,045.4</b>	<b>370,810.9</b>
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	28,262.2	47,716.0	46,025.8	1,690.2
Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	28,262.2	47,716.0	46,025.8	1,690.2
ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	863,797.7	2,221,375.6	1,871,261.2	350,114.4
Орон нутгийн төсвөөс	863,797.7	2,221,375.6	1,871,261.2	350,114.4
Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	-	-	-	-
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	3,502.4	10,362.5	6,258.4	4,104.0
ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ	4,000.0	5,550.0	2,500.0	3,050.0
БУСАД ЭХ ҮҮСВЭР / шилжих үлдэгдэл/	-	11,852.2	-	11,852.2
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл			22,336.9	
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл			43,963.4	

Эх сурвалж: Өмнөговь аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

3.7 Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн зарлагын дүнд ТЕЗ-ийн урсгал зардал 22.3 хувь, хөрөнгийн зардал 20.9 хувь, орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлэг 2.4 хувь, улсын төсөвт төвлөрүүлэх татаас 54.4 хувийг тус тус эзэлж байна.

Орон нутгийн төсвийн зарлага нэмэгдэхэд дараах хүчин зүйл нөлөөлсөн байна. Үүнд:

3.8 Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн дагуу улсын төсөвт 1,249,676.3 сая төгрөгийг орлого төвлөрүүлж, 88 хувийн гүйцэтгэлтэй байна. Өмнөговь аймгаас улсын төсөвт төвлөрүүлсэн орлого дараах байдалтай байна.

Хүснэгт №11 Улсын төсөвт төвлөрүүлсэн дүн

/сая төгрөг/

Аймаг, хотын нэр	2021 оны гүйцэтгэл	2022 оны гүйцэтгэл	2023 оны гүйцэтгэл	2024 оны			
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү +/-	Хувь
<b>Өмнөговь</b>	78,349.7	145,749.5	456,418.8	1,419,975.6	1,249,676.3	-170,299.3	88.0

Эх сурвалж: Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газар

3.9 Дээрх судалгаанаас харахад улсын төсөвт төвлөрүүлсэн орлого өмнөх оноос 2.7 дахин буюу 793,257.5 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

3.10 Улсын төсөвт 1,249,676.3 сая төгрөг төвлөрүүлсэн нь ТЕЗ-ийн нийт зарлагын 54.4 хувийг эзэлж байна.

3.11 МУЗГ-ын 2024 оны 128 дугаар “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” тогтоолоор төрийн албан хаагчид болон бусад салбарын цалин хөлс нэмэгдсэн.

3.12 Төрийн албаны тухай хуулийн 57 дугаарын зүйлийн 57.17<sup>13</sup>-д заасны дагуу Өмнөговь аймгийн Засаг даргын 2024 оны А/451 дугаар захирамжаар улсын төсвийн байгууллагын албан хаагчдад үндсэн цалингийн 25 хувиар, А/452 дугаар захирамжаар орон нутгийн төрийн захиргааны албан хаагчид сарын үндсэн цалингаас Даланзадгад суманд 80 хувь, бусад суманд 100 хувь, төрийн үйлчилгээний албан хаагчид сарын үндсэн цалингаас Даланзадгад суманд 60 хувь, бусад суманд 80 хувиар, А/463 дугаар захирамжаар улс төрийн албан хаагчид үндсэн цалингийн 100 хувиар тооцож тус тус “Орон нутгийн нэмэгдэл” сар бүр олгосон байна.

3.13 Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.3<sup>14</sup>-д заасны дагуу суманд тасралтгүй ажиллаж байгаа төрийн захиргааны албан хаагчид таван жил тутамд нэг удаа зургаан сарын үндсэн цалинтай нь тэнцэх хэмжээний мөнгөн урамшууллыг шаардлага хангасан төрийн захиргааны албан хаагчид олгосон байна.

3.14 Дээрх цалин хөлс, нэмэгдэл, урамшуулалтай холбоотойгоор цалин хөлс, шимтгэлийн зардал өмнөх оноос 10,863.2 сая төгрөгөөр өссөн байна.

3.15 Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 2/4, Тэргүүлэгчдийн 2021 оны 89 дүгээр тогтоолоор баталсан “Нутгийн дэм” хөтөлбөрт зарим улсын төсвийн байгууллагууд болон орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын албан хаагчдыг нэмж хамруулан нийт 226 байгууллагын 6700 албан хаагчид 26,154.1 сая төгрөг олгосон байна.

3.16 Эрчим хүчний зохицуулах хорооны тариф батлах тухай 2024 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн 632, 636 дугаар тогтоолын дагуу цахилгаан эрчим хүчний үнэ нэмэгдсэн нь байр ашиглалтын зардал нэмэгдэхэд нөлөөлсөн байна.

3.17 Сангийн сайдын 2024 оны А/52 дугаар тушаалаар дотоод албан томилолтын зардлын хэмжээг шинэчлэн баталсантай холбоотойгоор томилолтын зардал өмнөх оноос 141.9 сая төгрөгөөр өссөн байна.

3.18 Хөрөнгийн зардал өмнөх оны гүйцэтгэлээс 209,211.6 сая төгрөгөөр өссөн ч тайлант онд 75.7 хувийн гүйцэтгэлтэй байгаа нь орон нутгийн төсвийн хөрөнгө

<sup>13</sup> Захиргааны, үйлчилгээний болон улс төрийн албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчид орон нутгийн нэмэгдэл олгож болно.

<sup>14</sup> Сум болон нийслэлийн Багахангай, Багануур, Налайх дүүрэгт тасралтгүй ажиллаж байгаа төрийн захиргааны албан хаагчид таван жил тутамд нэг удаа зургаан сарын үндсэн цалинтай нь тэнцэх хэмжээний мөнгөн урамшууллыг олгох бөгөөд мөнгөн урамшуулал олгох журмыг Засгийн газар батална.

Өмнөговь аймгийн Засаг даргын 2024 оны нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ бүрэн хэрэгжээгүй болон төсвийн орлого бүрэн төвлөрөөгүйтэй холбоотой байна.

3.19 Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн гүйцэтгэлийг хөтөлбөрөөр харуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт №12 ТЕЗ-ийн төсвийн гүйцэтгэл хөтөлбөрөөр

/сая төгрөг/

Хөтөлбөрийн нэр	Төсвийн гүйцэтгэл			
	Төсөв	Гүйцэтгэл	Хэтрэлт, хэмнэлт	Хувь
70105 ОН-ын өөрөө удирдах ёсны байгууллага	6,765.5	6,018.9	746.6	89%
70106 ОН-ын гүйцэтгэх засаглалын удирдлага	2,201,374.0	1,846,391.7	354,982.4	84%
70429 Санхүүгийн хяналт, дотоод аудит, эрсдэлийн удирдлага	499.4	416.4	83.0	83%
70426 Төрийн өмчийн эрхийг хэрэгжүүлэх	711.5	542.9	168.6	76%
70418 Худалдан авах ажиллагаа	619.9	520.0	99.9	84%
70503 ОН-ын Хөгжлийн сан	65,823.4	36,074.3	29,749.1	55%
70709 Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх	582.4	481.1	101.2	83%
71506 Суурин газрын усан хангамж	144.0	119.0	25.0	
71101 Авто зам	10,987.2	5,788.4	5,198.8	53%
71403 Ойжуулалт	2,156.9	1,937.7	219.1	90%
71411 Хүрээлэн буй орчны бодлого	1,860.9	1,628.1	232.8	87%
71602 Эмнэлгийн тусламж үйлчилгээ	1,961.3	1,629.3	332.0	83%
71701 Биеийн тамир спорт	351.4	247.9	103.5	71%
71702 Соёл урлаг	2,273.2	1,904.7	368.6	84%
71804 Мэргэжлийн боловсрол	303.0	285.5	17.6	94%
71902 Нийгмийн халамж	148.0	147.9	0.1	100%
71806 Насан туршийн болон албан бус боловсрол	27.6	18.7	8.9	68%
72208 Ахмад настны хөгжил хамгаалал	266.8	266.5	0.3	100%
Нийт дүн	2,296,856.3	1,904,419.0	392,437.3	83%

Эх сурвалж: Аймгийн Санхүү төрийн сангийн хэлтэс

3.20 ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын нэмэлт санхүүжилтийн дансанд 52,668.8 сая төгрөгийн эх үүсвэр бүрдүүлж 962.3 сая төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Хүснэгт №13 Сумдын нэмэлт төсвийн гүйцэтгэл

/сая төгрөг/

Д/д	Сумын нэр	Нэмэлт төсвийн дүн	Төвлөрүүлсэн дүн
1	Баяндалай	195.9	0.5
2	Баян-Овоо	256.1	0.0
3	Булган	9,031.9	62.5
4	Гурвантэс	7,118.3	3.3
5	Даланзадгад	1,682.7	52.7
6	Мандал-Овоо	460.6	36.3
7	Манлай	2,387.5	0.0
8	Ноён	4,665.7	96.4
9	Номгон	4,711.2	13.4
10	Сэврэй	8,021.1	3.7
11	Ханбогд	657.9	86.2
12	Ханхонгор	2,788.4	27.1
13	Хүрмэн	208.9	2.2
14	Цогт-Овоо	2,433.9	229.4
15	Цогтцэций	1,085.2	54.0
16	Аймгийн төвийн байгууллага	6,963.5	294.6
	<b>Нийт дүн</b>	<b>52,668.8</b>	<b>962.3</b>

Эх сурвалж: Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газар

3.21 Сумдын нэмэлт санхүүжилтийн зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг ЗДНХ-өөс шилжүүлсэн бөгөөд нийт зарлагын 80.2 хувь нь эрх шилжсэн хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний санхүүжилт, 9.2 хувь нь орон нутгийн нэмэгдэл, нутгийн дэмийн санхүүжилт бөгөөд үлдсэн хэсэг нь байр ашиглалт, мал тооллого болон төрийн үйлчилгээг хэвийн хүргэхтэй холбогдсон зардлууд байна.

3.22 Сумдын орон нутгийн орлогод байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөөг баталдаг бөгөөд энэ нь хоршоо хөгжүүлэх сан, малчдаас авах өвс тэжээлийн авлагаас бүрдэж байна. Нэмэлт төсвийн гүйцэтгэлд өөрийн үйл ажиллагаанаас олсон болон давсан орлогыг урамшуулалд зарцуулсан асуудал байхгүй байна.

3.23 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 1,304.4 сая төгрөгийн зөрчил илэрсэн нь өмнөх оноос 0.8 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

**Хүснэгт№14 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн зөрчил**

Зөрчлийн ангилал	2023 оны зөрчлийн		2024 оны зөрчлийн		/сая төгрөг/ Зөрүү +/-	
	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн
Хариуцлага тооцох албан шаардлага	1	-	1	-	0	-
Төлбөрийн акт	27	36.2	16	34.0	11	2.2
Албан шаардлага	40	1,003.6	33	732.0	7	271.6
Зөвлөмж	28	254.3	14	538.4	14	(284.1)
Нийт дүн	96	1,294.1	64	1,304.4	32	(10.3)

Эх сурвалж: Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газар

3.24 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн зөрчлийн тоо 32-оор буюу 33.3 хувиар буурсан байгаа нь Төрийн аудитын байгууллагаас өмнөх аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагыг хэрэгжүүлж ажилласантай холбоотой байна.

3.25 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчлийг хуулийн зүйл заалтаар харуулбал дараах байдалтай байна.

**Хүснэгт№15 Төрийн хэмнэлтийн зөрчил хуулийн зүйл заалтаар**

Д/д	Төрийн хэмнэлтийн тухай хуулийн заалт	Зөрчлийн		
		тоо	дүн /сая/	хувь
1	8.1.Цэргийн алба хаагч, прокурор, гадаадын иргэний хяналтын улсын байцаагч, гаалийн улсын байцаагчаас бусад албан хаагч төсвийн болон байгууллагын хөрөнгөөр дүрэмт хувцас худалдан авахыг хориглоно.	7	9.6	0.7
2	12.1.1.үндсэн үйл ажиллагаа нь шуурхай албаны болон бэлэн байдлыг хангах чиг үүрэгтэй этгээдийн албаны гар утасны зардлаас бусад гар утасны зардал	3	6.6	0.5
3	12.1.3.хэвлэлийн захиалгын төлбөр	1	139.3	10.7
4	12.1.4.хуулиар зөвшөөрөөгүй бусад	2	15.7	1.2
5	13.1.2.энэ хуулийн 13.1.1-д заасан хугацаанд худалдан авах ажиллагааг зохион байгуулж дуусгаагүй бол төсөл, арга хэмжээний санхүүжилтийг төсвийн хэмнэлтэд тооцох	1	-	0.0
6	13.1.4.төсөл, арга хэмжээ төлөвлөсөн хугацаанд бүрэн хэрэгжих боломжгүй нөхцөл үүссэн тохиолдолд гэрээ байгуулах шийдвэр гаргахгүй байх	1	16.2	1.2
7	14.1.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасан захиалагч нь тухайн жилд худалдан авах 10 сая төгрөгөөс дээш өртөг бүхий бараа, үйлчилгээний жагсаалтыг цахим дэлгүүрт байршуулах хүсэлтийг өмнөх онд худалдан авсан тоо хэмжээ, нэгж үнийн хамт төрийн худалдан авах ажиллагааны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ	3	439.5	33.7
8	14.2.Худалдан авах бараа, үйлчилгээний төрөл нэмэгдэх тохиолдолд энэ хуулийн 14.1-д зааснаар хүсэлтийг тухай бүр хүргүүлнэ.	3	104.5	8.0
9	14.4.Цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно	9	24.8	1.9

**Өмнөговь аймгийн Засаг даргын 2024 оны нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

<b>10</b>	15.1.3.хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох	7	37.4	2.9
<b>11</b>	15.1.4.Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, Улсын Их Хурлаас баталсан хууль тогтоомж, Засгийн газрын болон аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын шийдвэр, тэдгээрийн хэрэгжилт, цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх, сурталчлан таниулахаас бусад зорилгоор байгууллага, хамт олныг сурталчлах, салбарын болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нэвтрүүлэг, контент, баримтат болон цуврал киноны уран бүтээл зэргийг санхүүжүүлэх	4	196.5	15.1
<b>12</b>	15.1.5.төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах	19	303.6	23.3
<b>13</b>	15.1.7.байгууллагын төсвөөр согтууруулах ундаа худалдан авах	2	0.5	0.0
<b>14</b>	15.2.6.байгууллагын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, цалин хөлсийг орлого, гүйцэтгэл, үр дүн, үр ашигтай нь уялдуулан олгох.	2	10.2	0.8
	<b>ДҮН</b>	<b>64</b>	<b>1,304.4</b>	<b>100</b>

*Эх сурвалж: Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газар*

3.26 Дээрх хүснэгтээс харвал нийт зөрчлийн 41.7 хувийг цахим дэлгүүр худалдан авалттай холбоотой зөрчил, 15.1 хувийг контент цахим мэдээлэлтэй холбоотой зөрчил, 23.3 хувийг төсвийн хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авсан зөрчил тус тус эзэлж байна.

3.27 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгахад ТЕЗ-ийн харьяа 22 байгууллагад 4,962.9 сая төгрөгийн зөрчил илэрч аудитаар 4,739.2 сая төгрөгийн зөрчилд 7 байгууллагад албан шаардлага, 223.7 сая төгрөгийн зөрчилд 15 байгууллагад зөвлөмж хүргүүлж ажилласан.

3.28 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд Өмнөговь аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба сар бүр хяналт тавьж ажиллаж байгаа боловч зөрчлийн дүн буурахгүй байна.

3.29 Өмнөговь аймгийн ИТХ-ын 2024 оны 19/28 дугаар тогтоолоор орон нутгийн нөөц хөрөнгийн санхүүжүүлэх эх үүсвэрийг 4,000.0 сая төгрөгөөр тооцон төлөвлөж баталсан байна.

3.30 Төсвийн ерөнхийлөн захирагч нь гүйцэтгэлээр тайлант онд 3,996.2 сая төгрөгийг зарцуулан оны эцэст орон нутгийн төсөвт 3.7 сая төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна

*Хүснэгт №16 Нөөц хөрөнгийн зарцуулалт*

<b>№</b>	<b>Үзүүлэлт</b>	<b>Мөнгөн дүн</b>
<b>1</b>	Эмчилгээний зардалд буцалтгүй тусламж	793.1
<b>2</b>	Тэргүүний сум, баг байгууллага хамт олон шалгаруулах зардал	50.8
<b>3</b>	Улсын аварга малчин, Улсын аварга саальчинд хүндэтгэл үзүүлэх зардал	16.9
<b>4</b>	Уулзалт, зөвлөгөөний заалны үйлчилгээний зардал	74.8
<b>5</b>	Баяр наадмын зардал	29.6
<b>6</b>	Байгалийн гамшигт үзэгдэлд зарцуулсан зардал	121.5
<b>7</b>	Ойн арга хэмжээний зардал	32.6
<b>8</b>	Ахмад настан хүндэтгэл үзүүлэх зардал	18.3
<b>9</b>	Өвсний нөөц бүрдүүлэх зардал	2,232.3
<b>10</b>	Хүндэт тэмдэг жуух бичгийн нөөц бүрдүүлэх зардал	51.9
<b>11</b>	Албан байгууллага, иргэдээс ирсэн хүсэлт шийдвэрлэх зардал	574.1
	<b>Нийт дүн</b>	<b>3,996.2</b>

*Эх сурвалж: Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газар*

ТЕЗ-ийн аудитаар дараах зөрчил илэрсэн байна. Үүнд:

- Орон нутгийн нөөц хөрөнгөөс 10 төрлийн арга хэмжээнд олгосон 124.3 сая төгрөгийн хөрөнгийн зарцуулалтын тайлан байхгүй байна. Энэ нь Сангийн сайдын 2021 оны 61 дугаар тушаалаар баталсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын журам"-ын 6 дугаар зүйлийн 6.1<sup>15</sup>-д заасныг хэрэгжүүлж ажиллаагүйд албан шаардлага хүргүүлсэн.

- Орон нутгийн нөөц хөрөнгөөс уулзалт, зөвлөгөөний заалны зардалд 54.7 сая төгрөг, баяр наадмын зардалд 29.6 сая төгрөг тус тус зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3<sup>16</sup>, Сангийн сайдын 2021 оны 61 дугаар тушаалаар баталсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 1.2<sup>17</sup>-д заасантай нийцээгүй тул албан шаардлага хүргүүлсэн.

3.31 Орон нутгийн нөөц сангийн хөрөнгийн зарцуулалтыг журмын зүйл, заалтаар ангилан үзвэл дараах байдалтай байна.

<i>Хүснэгт №17 Нөөц хөрөнгийн зориулалт</i>		<i>/сая төгрөг/</i>	
<b>Заалт</b>	<b>Үзүүлэлт</b>	<b>Мөнгөн дүн</b>	<b>Эзлэх хувь</b>
<b>2.1.1</b>	хүчтэй цасан болон шороон шуурга, ган, зуд, үер, газар хөдлөлт, цөлжилт, гал түймэр, хүн, мал, амьтны болон ургамлын гоц халдварт өвчин, хортон мэрэгчид тархах зэрэг байгалийн гамшигт үзэгдэл тохиолдсон, нийтийг хамарсан цөмийн болон цацрагийн осол гарсан үед түүний хохирлыг бууруулах, тархалтыг хязгаарлах, үр дагаврыг арилгах;	141.5	3.5
<b>2.1.3</b>	тухайн төсвийн жилийн явцад шинээр батлагдсан хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийг хэрэгжүүлэхэд шаардагдах нэмэлт зардал;	1,752.8	43.9
<b>2.1.5</b>	энэ журмын 2.1.1, 2.1.2-т зааснаас бусад Засаг дарга хуулиар олгогдсон бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй холбоотой урьдчилан төлөвлөж төсөвт тусгах боломжгүй байсан нэг удаагийн шинжтэй арга хэмжээ;	752.7	18.8
<b>2.1.6</b>	шагнал урамшуулал, нэг удаагийн буцалтгүй тусламж, дэмжлэг.	1,349.3	33.8
	Нийт дүн	3,996.2	100.0

*Эх сурвалж: Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газар*

3.32 Дээрх хүснэгтээс харахад нөөц хөрөнгийн 3.5 хувийг байгалийн давагдашгүй хүчин зүйлд, 43.9 хувийг хууль тогтоомж, засгийн газрын шийдвэрийг хэрэгжүүлэхэд, 18.8 хувийг бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй холбоотой төсөвт тусгах боломжгүй нэг удаагийн шинжтэй арга хэмжээнд, 33.8 хувийг шагнал урамшуулал, нэг удаагийн буцалтгүй тусламж дэмжлэгт тус тус зарцуулсан байна.

3.33 ТЕЗ-ийн харьяа байгууллагуудад батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулаагүй, үр ашиггүй зарцуулсан 2,121.4 сая төгрөгийн 93 зөрчил илэрснээс 31.4 сая төгрөгийн зөрчилд 15 төлбөрийн акт, 1,975.1 сая төгрөгийн зөрчилд 63 албан шаардлага, 114.8 сая төгрөгийн зөрчилд 15 зөвлөмж тус тус хүргүүлсэн байна.

Аудитаар илэрсэн зөрчлийг дурдвал:

- Баяндалай, Гурвантэс, Манлай, Ханбогд, Хүрмэн, Цогт-Овоо, Цогтцэций сумын ИТХ, аймгийн ИТХ, Баяндалай, Ханбогд сумын ЗДТГ, Мандал-Овоо сумын Хаан мандал, Цогтцэций сумын Тэгшдүүрэн ОНӨААТҮГ, Тост тосон бумбын нурууны байгалийн нөөц газрын хамгаалалтын захиргаа, Ноён, Ханбогд, Даланзадгад сумын Засаг дарга зэрэг

<sup>15</sup> Нөөц хөрөнгөөр хэрэгжүүлэх арга хэмжээг хариуцан гүйцэтгэж байгаа байгууллага, ажилтан хөрөнгийн зарцуулалтын тайланг уг арга хэмжээг хэрэгжүүлж дууссанаас хойш ажлын 15 хоногийн дотор гаргаж, тухайн шатны Засаг даргын Тамгын газарт ирүүлнэ

<sup>16</sup> өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах

<sup>17</sup> Энэ журмын 1.1 заасан "урьдчилан төлөвлөж төсөвт тусгах боломжгүй байсан" гэдгийг жил бүр давтагддаггүй онцгой арга хэмжээ, тохиолдлыг төсвийн зардлын зүйл, арга хэмжээний ангиллын дагуу санхүүжүүлэх боломжгүй нөхцөл байдал гэж ойлгоно

Өмнөговь аймгийн Засаг даргын 2024 оны нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан байгууллагууд төсвийн хөрөнгөөр 372.4 сая төгрөгийн бэлэг дурсгалын зүйлс худалдан авсан,

- Аймгийн ИТХ, Цогт-Овоо сумын Засаг дарга төсвийн хөрөнгөөр 186.8 сая төгрөгөөр видео нэвтрүүлэг, контент бэлтгэсэн,

- Ханбогд, Хүрмэн сумын ИТХ 1.7 сая төгрөгөөр утасны төлбөр төлсөн,

- Баяндалай, Ноён, Хүрмэн, Цогтцэций, Даланзадгад сумдын ИТХ, Гурвантэс, Ханбогд, Цогт-овоо сумдын ЗДТГ, Баяндалай, Баян-Овоо, Гурвантэс, Мандал-Овоо, Манлай, Номгон, Ноён, Ханбогд, Цогт-Овоо, Цогтцэций сумын Засаг дарга нар 796.4 сая төгрөгөөр тэмцээн, уралдаан, ой, тэмдэглэлт баярын өдрүүдийн арга хэмжээг зохион байгуулсан,

- Булган сумын ЗДТГ, Баян овоо сумын Долоо шар заг, Цогтцэций сумын Тэгш дүүрэн ОНӨААТҮГ, Шим билэг, Энхийн хүслэн ӨЭМТ, Ханбогд, Цогт-Овоо сумын Засаг дарга төсвийн хөрөнгөөр 9.8 сая төгрөгийг хувцас худалдаж авсан,

- Гүний ус ХХК, Ханбогд, Даланзадгад сумын Засаг дарга 436.8 сая төгрөгөөр гадаадад туршлага судлуулах арга хэмжээг зохион байгуулсан ч орон нутагт нэвтрүүлсэн шинэ санаачилга, үр дүнг тооцоогүй,

- Баян-Овоо, Булган сумын ЗДТГ, Булган, Номгон, Ханбогд сумын ИТХ, Орон нутгийн өмчийн газар, Энхийн хүслэн ӨЭМТ, Таван толгой ХК, Ноён сумын Засаг дарга 37.4 сая төгрөгийн дэмжлэг, урамшуулал олгосон,

- Сэврэй, Ханхонгор, Хүрмэн сумын ЗДТГ, Ханбогд, Хүрмэн, Цогт-Овоо, Даланзадгад сумдын ИТХ, аймгийн ИТХ зэрэг байгууллагууд эдийн засгийн ангилал зөрчиж 140.9 сая төгрөг зарцуулсан,

- Манлай, Ноён, Ханхонгор сумын ЗДТГ, Цогт-Овоо сумын ИТХ, Сэврэй сумын ОНХС, Мандал-Овоо сумын Хаан мандал, Өмнөговь корпораци ОНӨААТҮГ, Энхийн хүслэн ӨЭМТ, Мандал-Овоо, Ханхонгор, Цогт-Овоо, Даланзадгад сумын Засаг дарга 138.8 сая төгрөгийн төсвийн хөрөнгийг зориулалт бусаар, үр ашиггүй зарцуулсан байна.

#### ТАТВАРЫН ЗАРЛАГА

3.34 Өмнөговь аймгийн ИТХ-ын 2024 оны 19/28 дугаар “2024 оны төсвийн тодотгол батлах тухай” тогтоолоор хувь хүний орлогын албан татварын буцаан олголтыг 1.2 сая төгрөгөөр дутуу буюу 2,137.8 сая төгрөгөөр баталсан байна.

3.35 Өмнөговь аймгийн Засаг даргын 2024 оны 01/1459 дугаар албан бичгээр Сангийн яамны төрийн сангийн газарт хүргүүлсэн 2023 оны татварын хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлэх, хувь хүний орлогын албан татварын буцаан олголтын 1023 иргэний 2,319.0 сая төгрөгийг Төв төрийн санд шилжүүлсэн байна.

3.36 Төсвийн урсгал зардлын төлөвлөлт, зарцуулалтад тавих дотоод хяналтыг сайжруулах шаардлагатай байна.

#### **БҮЛЭГ 4**

**ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэлд тавих хяналтыг сайжруулах шаардлагатай байна.**

4.1 Өмнөговь аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 01-ны 15/11 дугаар тогтоолоор 2023 онд хийгдэх хөрөнгийн зардлын дээд хэмжээг 537,144.0 сая төгрөгөөр баталсан байна.

Өмнөговь аймгийн Засаг даргын 2024 оны нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

4.2 Аймгийн ИТХ-ын 2024 оны 09 дүгээр сарын 1-ны өдрийн 19/28 дугаар “2024 оны төсвийн тодотгол батлах тухай” тогтоолоор аймгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтыг 47,516.7 сая төгрөгөөр бууруулан баталсан байна.

*Хүснэгт№18 Баталсан төсөл арга хэмжээний жагсаалт ( сая.төгрөг)*

Төсөл, арга хэмжээний нэр	2023 оны ИТХ-ын тогтоол №15/11		2024 оны ИТХ-ын тогтоол №19/28 тодотгол	
	Тоо	санхүүжих дүн	Тоо	санхүүжих дүн
Орон нутгийн хөгжлийн сангаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ	12	25,363.7	12	28,222.4
Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ	152	484,399.4	174	435,683.9
Байгаль хамгаалах чиглэлийн хөрөнгөөр хийгдэх хөрөнгө оруулалт	26	16,393.7	26	14,733.7
Замын сангийн хөрөнгөөр хийгдэх хөрөнгө оруулалт	2	10,987.2	2	10,987.2
<b>Нийт дүн</b>	<b>192</b>	<b>537,144.0</b>	<b>214</b>	<b>489,627.2</b>

*Эх сурвалж: Аймгийн ИТХ-ын тогтоол*

4.3 Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэлд 384,949.1 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

*Хүснэгт№19 Хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний жагсаалт*

*( сая.төгрөг)*

Нэр	Төлөвлөгөө		Гүйцэтгэл	
	Арга хэмжээний тоо	Баталсан төсөв	Арга хэмжээний тоо	Олгосон санхүүжилт
Орон нутгийн хөгжлийн сангаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ	12	28,222.4	7	10,645.8
Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ	174	435,683.9	128	361,594.6
Байгаль хамгаалах чиглэлийн хөрөнгөөр хийгдэх хөрөнгө оруулалт	26	14,733.7	21	6,920.3
Замын сангийн хөрөнгөөр хийгдэх хөрөнгө оруулалт	2	10,987.2	2	5,788.4
<b>Нийт дүн</b>	<b>214</b>	<b>489,627.2</b>	<b>158</b>	<b>384,949.1</b>

*Эх сурвалж: Аймгийн Санхүү төрийн сангийн хэлтэс*

4.4 Монгол Улсын Ерөнхий аудиторын 2024 оны А/108 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын жилийн төлөвлөгөө”-ийн дагуу “Орон нутгийн төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилтэд”-д гүйцэтгэлийн аудит хийгдэж байна

4.5 Гүйцэтгэлийн аудит хийгдэж дуусаагүй байгаа тул орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний гүйцэтгэл үр дүнг тайлагнах боломжгүй байна.

4.6 Өмнөговь аймгийн 2024 оны ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт дараах байдалтай байна.

*Хүснэгт№20. ОНХС-ийн хөрөнгөөр 2024 онд хийхээр төлөвлөсөн хөрөнгө оруулалтын*

*жагсаалт /сая төгрөг/*

д/д	Төсөл, арга хэмжээний нэр	Хэрэгжих хугацаа		Анх баталсан	Тодотгол	Өөрчлөлт
		Эхлэх	Дуусах			
1	Баян-Овоо сумын сургуулийн спорт заалны шалыг засварлах	2024	2024	201.50	201.50	-
2	Ноён сумын сургуулийн гадна тохижилт	2024	2024	518.00	518.00	-
3	Номгон суманд нийтийн биеийн тамир, урлаг, соёл, спортын арга хэмжээ зохион байгуулах цэцэрлэгт хүрээлэн, цэнгэлдэх байгуулах	2024	2024	2,456.60	2,456.60	-

Өмнөговь аймгийн Засаг даргын 2024 оны нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

4	Бэлчээр усжуулалтын хоёрдугаар аяны хүрээнд инженерийн хийцтэй худаг шинээр гаргах, хуучин худгийг засварлаж бэлчээр усжуулалтыг нэмэгдүүлэх	2024	2024	2,326.60	2,326.60	-
5	Манлай сумын төвийн цэвэр, бохир усны шугам	2024	2024	700.00	666.10	-33.9
6	Ханхонгор сумын төвийн гэр хорооллыг цэвэр, бохир усны сүлжээнд холбох	2024	2024	932.90	932.90	-
7	Цогт-Овоо сумын төвийн дэд бүтцийн шугам сүлжээний өргөтгөл	2024	2024	1,100.00	1,100.00	-
8	Гурвантэс сумын дулааны эх үүсвэр	2024	2024	4,300.00	3,616.20	-683.8
9	Сэврэй сумын төвийн автозам	2024	2024	7,124.70	7,124.70	-
10	Даланзадгад сумын төвийн дулаан, цэвэр, бохир усны шугамын ажил	2024	2024	1,696.70	5,376.70	3,679.9
11	Цогт-Овоо сумын төвийн цэвэрлэх байгууламжийн шинэчлэл	2024	2024	2,006.30	1,902.80	-103.5
12	Ханбогд сумын төвийн гудамж, хорооллын хяналтын камер суулгах	2024	2024	2,000.30	2,000.30	-
	ДҮН			25,363.60	28,222.40	2,858.8

Эх сурвалж: Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газар

4.7 Тодотголоор 3 төсөл арга хэмжээний санхүүжих дүнг нийт 821.1 сая төгрөгөөр бууруулж, 1 төсөл арга хэмжээний санхүүжих дүнг 3,679.9 сая төгрөгөөр нэмж нийт дүнг 2,858.8 сая төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.6.а<sup>18</sup>, 29 дүгээр зүйлийн 29.3.6<sup>19</sup>-д заасантай тус тус нийцэхгүй байна.

4.8 Тодорхой төсөл, хөтөлбөр, арга хэмжээний зарлагыг нэмэгдүүлэхээр бол бусад төсөл, хөтөлбөр, арга хэмжээний зардлыг мөн хэмжээгээр бууруулж, нийт зарлагын хэмжээг нэмэгдүүлэхгүй байхад анхаарч ажиллах шаардлагатай байна.

4.9 Тайлант онд ОНХС-ийн хөрөнгөөр 7 төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхэд 10,645.8 сая төгрөг олгосон бөгөөд гүйцэтгэл 37.7 хувьтай байна.

Хүснэгт №21 ОНХС-аар хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний гүйцэтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Төсөл, арга хэмжээний нэр	Хэрэгжих хугацаа		Баталсан төсөв	Олгосон санхүүжилт	Хувь
		Эхлэх	Дуусах			
1	Баян-Овоо сумын сургуулийн спорт заалны шалыг засварлах	2024	2024	201.5	-	-
2	Ноён сумын сургуулийн гадна тохижилт	2024	2024	518.0	509.8	98.4
3	Номгон суманд нийтийн биеийн тамир, урлаг, соёл, спортын арга хэмжээ зохион байгуулах цэцэрлэгт хүрээлэн, цэнгэлдэх байгуулах	2024	2024	2,456.6	2,454.3	99.9
4	Бэлчээр усжуулалтын хоёрдугаар аяны хүрээнд инженерийн хийцтэй худаг шинээр гаргах, хуучин худгийг засварлаж бэлчээр усжуулалтыг нэмэгдүүлэх	2024	2024	2,326.6	1,882.4	80.9
5	Манлай сумын төвийн цэвэр, бохир усны шугам	2024	2024	666.1	666.1	100.0
6	Ханхонгор сумын төвийн гэр хорооллыг цэвэр, бохир усны сүлжээнд холбох	2024	2024	932.9	-	-
7	Цогт-Овоо сумын төвийн дэд бүтцийн шугам сүлжээний өргөтгөл	2024	2024	1,100.0	-	-
8	Гурвантэс сумын дулааны эх үүсвэр	2024	2024	3,616.2	3,616.2	100.0
9	Сэврэй сумын төвийн автозам	2024	2024	7,124.7	-	-

<sup>18</sup> тодорхой төсөл, хөтөлбөр, арга хэмжээний зарлагыг нэмэгдүүлэхээр бол бусад төсөл, хөтөлбөр, арга хэмжээний зардлыг мөн хэмжээгээр бууруулж, нийт зарлагын хэмжээг нэмэгдүүлэхгүй байх

<sup>19</sup> тухайн жилд батлагдсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг төсвийн тодотголоор бууруулахгүй байх

Өмнөговь аймгийн Засаг даргын 2024 оны нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

10	Даланзадгад сумын төвийн дулаан, цэвэр, бохир усны шугамын ажил	2024	2024	5,376.7	19.6	0.4
11	Цогт-Овоо сумын төвийн цэвэрлэх байгууламжийн шинэчлэл	2024	2024	1,902.8	1,497.4	78.7
12	Ханбогд сумын төвийн гудамж, хорооллын хяналтын камер суулгах	2024	2024	2,000.3	-	-
	ДҮН			28,222.4	10,645.8	37.7

Эх сурвалж: Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газар

4.10 Цогт-Овоо сумын төвийн гэр хорооллын ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээг өргөтгөх, цэвэрлэх байгууламжийг шинэчлэх ажлын 405.4 сая төгрөгийн санхүүжилтийг ОНТХО-ын данснаас шилжүүлсэн байна.

4.11 Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хийж гүйцэтгэхээр төлөвлөсөн Ханхонгор сумын төвийн гэр хорооллыг цэвэр, бохир усны сүлжээнд холбох 932.9 сая, Цогт-Овоо сумын төвийн дэд бүтцийн шугам сүлжээний өргөтгөл 1,100.0 сая, Сэврэй сумын төвийн автозам 7,124.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлуудыг аймгийн ОНТХО-аар хийж гүйцэтгэсэн байна. Энэ нь Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 4.1.4<sup>20</sup>-д заасантай нийцэхгүй байна.

4.12 Дээрх асуудлыг “Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн”, “ОНХС-ийн бүрдүүлэлт, зарцуулалт, үр нөлөө” сэдэвт гүйцэтгэлийн аудитаар нарийвчлан шалгах нь зүйтэй байна.

4.13 Ханбогд сумын төвийн гудамж, хорооллын хяналтын камер суулгах ажил, Баян-Овоо сумын сургуулийн спорт заалны шалыг засварлах зэрэг ажлууд зураг төсөв хийгдэж дуусаагүй шалтгаанаар хэрэгжээгүй байна. Энэ нь Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 4.1.3<sup>21</sup>-т заасныг хэрэгжүүлээгүй байна.

4.14 Аймгийн Засаг даргын 2023 оны А/2361 дугаар захирамжаар “Булган сумын Хонь бордох газарт гарсан инженерийн хийцтэй худагт цооног өрөмдлөгийн ажил, суурилуулах тоног төхөөрөмжийг хүчилтгэж холбож суурилуулах” ажлын санхүүжилтийг ОНТХО-ын Төрийн сангийн 100110051300 тоот дансаар дамжуулан гүйцэтгэгч компанид олгосон байна. Энэ нь Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 8.1<sup>22</sup>-д заасантай нийцэхгүй байна.

4.15 ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний төлөвлөлтийг сайжруулах, санхүүжилтийн гүйцэтгэлд тавих хяналт сул байна.

ТЕЗ-ийн Худалдан авах ажиллагааны талаар:

4.16 Төсвийн ерөнхийлөн захирагч Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 44 дугаар зүйлийн 44.4<sup>23</sup>-т заасны дагуу улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2024 онд хэрэгжүүлэх 411 төсөл арга хэмжээний жагсаалт, төлөвлөгөөг баталгаажуулан цахим системд нийтэлсэн байна.

4.17 Аймгийн худалдан авах ажиллагааны газраас цахим системээр нээлттэй тендер шалгаруулалтын аргаар 335, харьцуулалтын аргаар 76 худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байна.

4.18 Зохион байгуулсан 411 төсөл, арга хэмжээнээс 327 төсөл, арга хэмжээ амжилттай, 87 төсөл, арга хэмжээ амжилтгүй болсон байна.

<sup>20</sup> ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх эх үүсвэрийг өөр бусад эх үүсвэртэй уялдуулан төлөвлөсөн байх;

<sup>21</sup> ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь хуульд заасны дагуу зураг төсөв, техник, эдийн засгийн үндэслэлтэй, байгаль орчны төлөв байдлын үнэлгээ хийгдсэн, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон байх

<sup>22</sup> ОНХС нь аймаг, нийслэл, сум, дүүргийн төрийн санд данстай байх бөгөөд сангийн орлого, зарлагыг зөвхөн энэхүү дансаар дамжуулан гүйцэтгэнэ

<sup>23</sup> Төсвийн ерөнхийлөн захирагч тухайн жилийн санхүүжилтийн эх үүсвэр батлагдсанаас хойш нэг сарын дотор харьяа захиалагчийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг нэгтгэн хянаж, баталгаажуулан цахим системд нийтэлнэ.

4.19 Тайлант онд 312.0 сая төгрөгийн худалдан авалтыг ерөнхий гэрээний аргаар буюу цахим дэлгүүрээс захиалагч байгууллагын ирүүлсэн техникийн тодорхойлолтын дагуу сонгон шалгаруулалтыг зохион байгуулан шалгарсан оролцогчийн гэрээг захиалагч байгууллагад шилжүүлэн ажилласан байна.

4.20 Тайлант хугацаанд зохион байгуулагдсан худалдан авах ажиллагаатай холбоотой 21 гомдол Сангийн яаманд гаргасан бөгөөд нийт гомдол үндэслэлийн 66.6 хувь буюу 14 үндэслэлийг захиалагчийн шийдвэр үндэслэлгүй гэж дүгнэсэн байна.

4.21 Энэ нь өмнөх оноос өссөн байх тул Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.8<sup>24</sup> болон худалдан авах ажиллагаанд мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, үйл ажиллагаанд нь хяналт тавьж хуулийн хэрэгжилтийг хангуулж ажиллах шаардлагатай байна.

4.22 ТЕЗ-ийн харьяа байгууллагуудад худалдан авах ажиллагаатай холбоотой 29,654.9 сая төгрөгийн 33 зөрчил илэрснээс 1,036.5 сая төгрөгийн зөрчилд 20 албан шаардлага, 28,618.1 сая төгрөгийн зөрчилд 13 зөвлөмжийг хүргүүлсэн.

Аудитаар илэрсэн зөрчлийг дурдвал:

- Булган, Номгон сумын Засаг дарга, Даланзадгад сумын Захирагчийн ажлын алба нь тайланд онд худалдан авах ажиллагааны төлөвлөгөө гаргаагүй худалдан авах ажиллагаа зохион байгуулсан, хэрэгжилтийг тайлагнаагүй,
- Гурвантэс, Цогт-Овоо сумын ЗДТГ, аймгийн ЗДТГ, Нийтлэг үйлчилгээний газар, Байгаль орчин аялал, жуулчлалын газар, Орон нутгийн өмчийн газар, Буянтхотхон УТҮГ, Сэврэй Дэмд-од, Хүрмэн Жанжинговь, Даланзадгад Дулаан хангамжийн газар ОНӨААТҮГ зэрэг байгууллагууд нь шууд худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаараас давсан бараа, ажил, үйлчилгээнд худалдан авах ажиллагааг зохион байгуулаагүй, шууд худалдан авалт хийсэн,
- Аймгийн ИТХ, Цогт-Овоо сумын Ойн анги, Ноён сумын ОНХС нь батлагдсан төсөвт өртгийг хувааж, шууд худалдан авалт хийсэн,
- Гурвантэс сумын ИТХ, ЗДТГ, Манлай, Ханхонгор сумын ЗДТГ, Гурвантэс сумын ОНХС, ХХС, бусад сан, Хүрмэн сумын ОНХС, Тавантолгой ХК тендер шалгаруулалтын үр дүнд байгуулсан гэрээ, гэрээний хэрэгжилт хангуулж ажиллаагүй,
- Гүний ус ХХК нь Хятад Улсаас 4 удаа 142.4 сая төгрөгийн шууд худалдан авалт хийсэн,
- Тавантолгой ХК "Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тодотгосон төлөвлөгөө"-г ТУЗ батлуулж, гүйцэтгэх захирлын тушаалаар батлаагүй, худалдан авах ажиллагааны тайланд шууд гэрээ байгуулсан бараа, ажил, үйлчилгээг тайлагнаагүй, 87.6 сая төгрөгийн засварын ажлыг худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаагүй шууд худалдан авалт хийсэн, хөрс хуулалт, нүүрс олборлолтын ажил /багцтай/-ын нээлттэй тендер шалгаруулалтыг 2024 оны 04 дүгээр сарын 03-ны өдөр зарласан байхад, 2024 оны 05 дугаар сарын 03-ны өдөр нэмэлт гэрээ байгуулж, гэрээний төлбөрт 26,845.7 сая төгрөг шилжүүлсэн, Түлш, шатахуун худалдан авах ТТХК/20240102014 дугаартай 1 дүгээр багц ажлын тендерийг хуулийн хугацаанд үнэлж, шийдвэр гаргалгүй, 2023 оны №ТТХК/202301005 дугаартай "Сод монгол групп" ХХК-тай байгуулсан гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулж, гэрээний төлбөрт 1,291.1 сая төгрөг шилжүүлсэн зэрэг зөрчлүүд илэрсэн байна.

<sup>24</sup> Худалдан авах ажиллагааны мэргэжлийн байгууллагын аймаг, нийслэл, дүүрэг дэх нэгж дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ

**БҮЛЭГ 5**

**Төсөл хөтөлбөрийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж ажиллах шаардлагатай байна.**

5.1 Өмнөговь аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 2/4 дүгээр тогтоолоор Өмнөговь аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны “Нутгийн хишиг” хөтөлбөрийг баталсан байна.

5.2 Өмнөговь аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 15/11 дугаар тогтоолоор орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2024 онд хэрэгжих хөтөлбөр, төсөл, арга хэмжээнд 105,403.9 сая төгрөгөөр 115 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

5.3 Төсвийн тухай хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1.2<sup>25</sup>-д заасны дагуу аймгийн ИТХ-ын 2024 оны 19/28 дугаар тогтоолоор 2024 онд хэрэгжих хөтөлбөр, төсөл арга хэмжээний тоог 118 болгон 107,850.3 сая төгрөгөөр баталсан бөгөөд АИТХ-ын төлөөлөгчдийн 2024 оны 03/04 дугаар “Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” тогтоолоор 108,133.0 сая төгрөг болгож өөрчилсөн байна.

5.4 ТЕЗ-ийн 2024 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл арга хэмжээнд гүйцэтгэлээр 81,956.2 сая төгрөг зарцуулж 97 арга хэмжээг хэрэгжүүлж ажилласан байна. Энэ нь Төсвийн ерөнхийлөн захирагчийн нийт төсвийн зарлагын 12.5 хувийг эзэлж байна. (Хавсралт №01)

5.5 “Нутгийн хишиг” хөтөлбөрийн зорилго, зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэсэн 25 дэд хөтөлбөрийг баталж, 24 хөтөлбөрийг хэрэгжүүлсэн байна.

5.6 Тайлант жил дэд хөтөлбөрүүдэд 74,542.6 сая төгрөг зарцуулахаар баталж гүйцэтгэлээр 68,366.3 сая төгрөг зарцуулсан байна.

Хүснэгт № 22 Дэд хөтөлбөрүүдийн батлагдсан төсөв, гүйцэтгэл /сая төгрөг/

№	Хөтөлбөрийн нэр	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Зөрүү	Гүйцэтгэлийн хувь
<b>1.Нийгмийн салбарын чиглэл</b>					
1	Говийн ирээдүй- Хүүхэд	450.0	456.0	(6.0)	101%
2	Цахим Өмнөговь	1,550.0	474.0	1,076.0	31%
3	Залуус	500.0	349.9	150.1	70%
4	Чадварлаг багш	750.0	681.6	68.4	91%
5	Сүү тараг	250.0	232.3	17.7	93%
6	Эрүүл шүд	200.0	42.4	157.6	21%
7	Эрүүл элэг	100.0	21.0	79.0	21%
8	Сурагч солилцоо	350.0	276.3	73.7	79%
9	Эх хүүхдийн эрүүл мэнд	100.0	69.1	30.9	69%
10	Харшлын эсрэг	50.0	15.2	34.8	30%
<b>2. Хөдөө аж ахуй, хөрөнгө оруулалт, байгаль орчны чиглэл</b>					
11	Өсөлтийг өрх бүрд	2,000.0	1,021.9	978.1	51%
12	Шинэ мянган айл	22,142.8	33,598.9	(11,456.1)	152%
13	Агаарын бохирдолгүй Өмнөговь	3,000.0	105.0	2,895.0	3%
14	Говь+Ус	2,150.0	2,000.0	150.0	93%
15	Цэгцтэй гэр хороолол	990.0	409.6	580.4	41%
16	Нутгийн үйлдвэрлэгч	1,281.8	-	1,281.8	-
17	Эко жорлон	690.0	352.5	337.5	51%
18	Чинээлэг малчин	4,788.0	569.1	4,218.9	12%
<b>3. Хүний нөөцийн хөгжлийн чиглэл</b>					
19	Нутгийн дэм	31,000.0	26,154.1	4,845.9	84%
20	Эзэмшсэн мэргэжлээрээ эх нутагтаа ажиллая	300.0	240.6	59.4	80%

<sup>25</sup> тухайн жилийн төсөв, түүний тодотголын төслийг хэлэлцэн батлах, хэрэгжилтэд хяналт тавих, нийтэд мэдээлэх

Өмнөговь аймгийн Засаг даргын 2024 оны нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

21	Хөгжлийн гүүр	1,500.0	1,151.4	348.6	77%
22	Нээлттэй Өмнөговь	100.0	-	100.0	-
<b>4. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэл</b>					
23	Ээлтэй Өмнөговь	150.0	105.3	44.7	70%
24	"Гэр бүл, хүүхэд, эмэгтэйчүүдийг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх"	150.0	40.1	109.9	27%
<b>Жилийн дүн</b>		<b>74,542.6</b>	<b>68,366.3</b>	<b>6,176.3</b>	<b>56%</b>

Эх сурвалж: Аймгийн Хяналт шинжилгээ үнэлгээний хэлтэс

5.7 Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн 17/11 дүгээр тогтоолоор “Математик боловсролын хөгжил” хөтөлбөрийг баталсан ч тайлант онд төсөв батлаагүйгээс хэрэгжээгүй байна.

5.8 Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хууль, Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”, аймгийн Засаг даргын 2024 оны “Аргачлал батлах тухай” А/423 дугаар захирамжийг тус тус үндэслэн Өмнөговь аймгийг 2020-2024 онд хөгжүүлэх аймгийн Засаг даргын үйл ажиллагааны “Нутгийн хишиг” хөтөлбөрийн зорилго, зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэсэн хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээг хийж дүгнэсэн байна.

5.9 Төсвийн ерөнхийлөн захирагчаас 2020-2024 онд хэрэгжүүлсэн хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ дараах байдалтай байна.

*Хүснэгт 23 Дэд хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт, шинжилгээ үнэлгээ*

№	Хөтөлбөрийн нэр	1-р зорилт	2-р зорилт	3-р зорилт	4-р зорилт	5-р зорилт	6-р зорилт	Хэрэгжилт
1	"Цэгцтэй гэр хороолол"	12.5%	46.6%	44.4%	86.6%	-	-	45%
2	"Нутгийн дэм"	100%	100%	-	-	-	-	100%
3	"Эх хүүхдийн эрүүл мэнд"	85%	96%	82,5%	-	-	-	88%
4	"Харшлын эсрэг"	70%	50%	70%	-	-	-	61.6%
5	"Сүү тараг"	88.9%	88.6%	94%	-	-	-	90%
6	"Гэр бүл, хүүхэд, эмэгтэйчүүдийг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх"	80%	75%	70%	58%	-	-	70.5%
7	"Цахим Өмнөговь"	60.5%	60%	47.5%	63.3%	70%	-	60.2%
8	"Өсөлтийг өрх бүрд"	63.3%	71.4%	52%	65%	70%	-	64.8%
9	"Залуус"	85.7%	90%	88%	87%	-	-	87.6%
10	"Эзэмшсэн мэргэжлээрээ эх нутагтаа ажиллая"	59%	30%	42.9%	-	-	-	49.5%
11	"Сурагч солилцоо"	10%	62.5%	85%	-	-	-	56.4%
12	"Чадварлаг багш"	76.3%	80%	85.7%	-	-	-	80.5%
13	"Эрүүл элэг"	80.8%	78.8%	76.6%	-	-	-	78.7%
14	"Шинэ мянган айл"	70%	66.6%	80%	70%	-	-	71.7%
15	"Агаарын бохирдолгүй Өмнөговь"	45.5%	17.1%	90%	31.4%	57.5%	25%	33.1%
16	"Говь+Ус"	80%	76.6%	83.3%	-	-	-	80%
17	"Чинээлэг малчин"	76%	70%	70%	75%	60%	-	70.5%
18	"Ээлтэй Өмнөговь"	71.5%	44.3%	81.4%	-	-	-	67.0%
19	"Говийн ирээдүй- Хүүхэд"	73.7%	67.5%	70%	62.5%	-	-	70.8%
20	"Эрүүл шүд"	69.8%	70.7%	70%	-	-	-	70.1%
21	"Эко жорлон" хөтөлбөр	55%	57%	43.3%	66.6%	60%	-	55.4%
22	"Хөгжлийн гүүр"	35%	30%	81%	50%	-	-	46.9%
23	"Нээлттэй Өмнөговь"	68.1%	-	-	-	-	-	68.1%
24	"Нутгийн үйлдвэрлэгч"	66%	45.5%	48.3%	24.4%	-	-	46.4%
25	"Математикийн боловсролын хөгжил"	-	-	-	-	-	-	-

5.10 “Нутгийн хишиг” хөтөлбөрт тусгагдан батлагдсан хөтөлбөрийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан, дүгнэлтийг үндэслэн хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөлт, үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэх, хэрэгжилт зохион байгуулалтыг сайжруулах зөвлөмжийг хүргүүлж ажилласан байна. Үүнд:

Аймгийн Засаг даргын Тамгын газрын хэлтсийн дарга нарт:

- Хөтөлбөрийн хэрэгжилтийг хугацаанд нь ирүүлэх тал дээр онцгой анхаарах,
- Хэлтсийн холбогдох мэргэжилтнүүдийн гаргаж байгаа тайланд хяналт тавьж, нэг бүрчлэн уншиж, сайжруулах зүйлсийг тухай бүр нь засаж сайжруулан баталгаажуулж ирүүлэх,
- Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн судалгаа, тооцоог үнэн бодит тооцоолон төлөвлөн, төсвийг үр ашигтай зарцуулах, төлөвлөсөн ажил, арга хэмжээг шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин, үр дүнд чиглэсэн байдлаар зохион байгуулахад анхаарах.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын хөтөлбөр хариуцсан мэргэжилтнүүдэд:

- Хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулж батлахдаа зорилт, үйл ажиллагааны шалгуур үзүүлэлт, зорилтот түвшинг тодорхой, хэмжигдэхүйц, хэрэгжихүйц, ач холбогдолтой, цаг хугацаатай байхаар төлөвлөн, гол үр дүнг харуулсан 1-2 шалгуур үзүүлэлтийг тоон болон чанарын утгаар оновчтой тодорхойлж, төлөвлөх,
- Хөтөлбөрийн хэрэгжилтийг тайлагнахдаа гүйцэтгэлтэй тулган хянаж, цаашид бодитой, тодорхой, нотлогдохуйц байх шаардлагыг хангаж иж бүрэн тайлагнах,
- Хэрэгжилт нь зорилт, үйл ажиллагааны үр дүнд чиглэх бөгөөд тухайн үйл ажиллагаа төлөвлөсөн үр дүндээ хүрсэн эсэх, хүрээгүй бол шалтгаан нөхцөлийг тодорхой дурдаж, иж бүрэн, алдаагүй, үнэн зөв, үр дүнг дүгнэн тайлагнах,
- Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн судалгаа, тооцоог нарийн төлөвлөн, төсвийг үр ашигтай зарцуулж, төлөвлөсөн ажил, арга хэмжээг чанартай, сайн зохион байгуулах,
- Зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.2 хэсэгт заасны дагуу бодитой үнэлэх,
- Батлагдсан удирдамжид заагдсан хугацаанд тайланг үнэн зөв бодитой, үр дүнгийн талаар оновчтой, тодорхой бичиж ирүүлж хэвших,
- Цаашид бодлого, хөтөлбөр боловсруулахдаа холбогдох хууль, тогтоомжид заасан төлөвлөлтийн шаардлагыг хангаж, зорилго, зорилтоо оновчтой тодорхойлон, үр дүнд чиглэсэн үйл ажиллагаа, арга хэмжээг зохион байгуулахад анхаарч ажиллах зөвлөмжийг өгсөн байна.

5.11 Өмнөговь аймгийн Төсвийн Ерөнхийлөн захирагчаас орон нутагт хэрэгжүүлсэн хөтөлбөр, төсөл арга хэмжээний үр дүнд хийсэн аудитаар нийт 37,172.1 сая төгрөгийн зөрчил илрүүлэн 81.1 сая төгрөгийн зөрчилд 10 төлбөрийн акт, 33,626.8 сая төгрөгийн зөрчилд 88 албан шаардлага, 8 зөвлөмж, 3,464.2 сая төгрөгийн зөрчилд 9 хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлэн, 5 зөрчлийг гэмт хэргийн шинжтэй байж болзошгүй гэж үзэж хууль хяналтын байгууллагад шилжүүлэхээр МУЕА-т уламжилсан.

Аудитаар дараах зөрчилд илэрсэн. Тухайлбал:

- Иргэдийн орон сууцны нөхцөлийг сайжруулах, хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор шинээр 10 айлын орон сууцны барилгыг барихаар төлөвлөж хэрэгжүүлснээс Ноён, Сэврэй,

Өмнөговь аймгийн Засаг даргын 2024 оны нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан  
Ханхонгор, Номгон, Цогтцэций сумдын барилгууд гэрээний хугацаанд баригдаж дуусаагүй,  
гэрээнд заасны дагуу алданги тооцоогүй,

- "Цогтцэций суманд 10 айлын орон сууц барих" ажлын гүйцэтгэгч Донж Өргөө ХХК-тай холбоотой Дорнод аймаг дахь сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн 2023 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн 138/ШШ2023/00147 дугаартай захирамжид тусгасны дагуу гэрээний үнийн дүнгийн 20 хувь буюу 142,7 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлэх талаар арга хэмжээ авч ажиллаагүй,

- Хөтөлбөрийн хүрээнд аймаг, сумын ерөнхий төлөвлөгөөнд тусгасан газар болон ашиглалтын шаардлага хангахгүй болсон барилгыг дахин төлөвлөх, барилгажуулах, Даланзадгад суманд түрээсийн орон сууцны сан бүрдүүлэх, хувийн хэвшлийг бодлогоор дэмжих ТАХ-ний хүрээнд гэрээ байгуулсан "Язгууртны говь" ХХК, "Эрхэст баян говь" ХХК, "Бизнес фокус" ХХК, "Евро ази констракшн" ХХК, "Ивээл хос жаргалууд" ХХК-ууд гэрээний хугацаанд ажлаа хэрэгжүүлж дуусаагүй,

- "Нанзад хорооллын газрыг дахин төлөвлөж барилгажуулах ажлыг дуусгаж, иргэд хувийн хэвшлийн оролцоотойгоор зарим гэр хорооллыг дахин төлөвлөх" ажлын хүрээнд 2020 онд 72 айлын орон сууцыг эхлүүлэн 2021 оны 10 сарын 01-д дуусгаж хүлээлгэж өгөхөөр байгуулсан ДТ2020-03 дугаар гэрээний хэрэгжилт одоог хүртэл хангаагүй байхад "Эрхэст баян говь" ХХК-тай компанитай төсөл сонгон шалгаруулалтаар 2022 онд 1,799.5 сая, 2023 онд 1,636.2 сая, 2024 онд 998.7 сая төгрөгийн ажил гүйцэтгэх гэрээ байгуулсан бол 2023 онд 1,299.7 сая төгрөгийн шууд гэрээ байгуулж 2020-2024 онуудад нийтдээ орон нутгийн төсвөөс 6,479.6 сая төгрөгийн санхүүжилт олгосон,

- Шинэ мянган айл хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлж буй орон сууцны барилга байгууламжид зөвлөх үйлчилгээ үзүүлэх эрхгүй Өмнөговь корпораци ОНӨААТҮГ барилгын ажилд захиалагчийн хяналт хэрэгжүүлсэн,

- ОНӨГ-т бүртгэлтэй дахин төлөвлөлтийн 3 дугаар байрын оффис, 2 дугаар байрын В1 давхрын өрөөнүүдийг "Болор үнэлгээ" ХХК-аар 2023 оны 11 сард үнэлгээ хийлгэн 307 тоот 62.16м2 талбайтай, 149.5 сая төгрөгийн балансын үнэтэй оффисын өрөөг 2024 оны 07 сард дуудлага худалдаагаар 128.0 сая төгрөгөөр худалдан борлуулсан,

- Зах зээлийн ханшнаас хямд өртөгтэй (өмнөх онуудад тухай үеийн зах зээлийн ханшаар бүртгэлд тусгасан) АЗДТГ-т бүртгэлтэй албан тушаалын байрыг эрх бүхий албан хаагчдад түрээслүүлэн өмчлүүлж, бусдад давуу байдал олгосон,

- Аймгийн Засаг даргын захирамжаар орон сууцны нөхцөлөө сайжруулах дэмжлэгийг 2021-2024 онд 833 төрийн албан хаагчдад нийт 4,962.3 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн боловч дэмжлэгт хамрагдсан төрийн албан хаагчдын нэгдсэн мэдээллийн сан үүсгээгүйгээс шалтгаалан өмнө нь энэ төрлийн тусламж, дэмжлэг авсан, гэр бүлийн гишүүн давхардаж байгаа эсэхэд хяналт хийгдээгүй олгосон,

- Орон сууцны нөхцөлөө сайжруулах дэмжлэгт хамрагдсан 833 төрийн албан хаагчдын төрийн албан хаасан хугацаа, орон сууц худалдан авах, шинээр бариулах, хашаандаа байшин барих зориулалтаар авсан эсэх нь нотлогдохгүй,

- Аймгийн Засаг даргын захирамжаар эмчилгээний тусламжийг 2021-2024 онд нийт 146.0 сая төгрөгийг 28 төрийн албан хаагчдад үзүүлсэн боловч өвчний онош, эмчлүүлэх хугацаа зэрэг нь баримтаар нотлогдохгүй,

- Аймгийн Засаг даргын захирамжаар мэргэжлээ дээшлүүлэх, мэргэшихэд нь сургалтын төлбөрийн дэмжлэгийг 2021-2024 онд 44 төрийн албан хаагчдад нийт 185.9 сая төгрөг олгосон ба дэмжлэгийг орон нутагт хэрэгцээтэй мэргэжил мөн эсэхийг харгалзаж үзээгүй,

- Мэргэжлээ дээшлүүлэх, мэргэшихэд нь сургалтын төлбөрийн дэмжлэг авсан 44 төрийн албан хаагчийг төрийн албанд ажиллаж байгаа, сурч байгаа эсэхэд хяналт хэрэгжүүлээгүй, үр дүнг тооцоогүй,

- Баяр наадмын арга хэмжээнд зарцуулахаар төсөв батлагдсан ч дахин арга хэмжээний зардлаас 140.0 сая төгрөгийг "Баяр наадам"-ын үйл ажиллагаанд зарцуулсан,
- Уран бүтээлчдэд тайлан тоглолт, бүтээл туурвих дэмжлэгийг гэрээгүй, хийсэн ажлын тайлан, нотлох баримтгүй 107.1 сая төгрөг зарцуулсан,
- Арга хэмжээний зардлаас 500.0 сая төгрөгийг тендер шалгаруулалт зохион байгуулаагүй байхад барьцаа хөрөнгийн дансанд шилжүүлсэн,
- Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд олон нийт, хувийн хэвшлийн сургалт, хичээлээс гадуур хөтөлбөрийн сургалтын байгууллагыг бодлогоор дэмжих ажлын хүрээнд нэг удаагийн буцалтгүй дэмжлэг олгох арга хэмжээг тооцоо судалгаагүй 1,500.0 сая төгрөг баталсан,
- 40-өөс дээш настай иргэд, хөгжлийн бэрхшээлтэй, зорилтот бүлгийн иргэдийн хөдөлмөр эрхлэлт, хөгжил хамгааллыг сайжруулах арга хэмжээний зардлаас 31.7 сая төгрөгийг анхан шатны баримтын иж бүрдэлгүйгээр зарцуулсан,
- Олон улсын болон дотоодын үзэсгэлэн, уулзалт, зөвлөгөөн, сургалтад оролцох арга хэмжээний зардлаас Баяндалай, Булган сумын баяр наадмын зардалд 19.9 сая төгрөгийг олгосон,
- Зорилтот бүлгийн иргэдийн амьдрах орчин, амьдралын чанарыг сайжруулах арга хэмжээний зардлаас хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч хөдөлмөр эрхлэх боломжгүй эцэг, эхийн НДШ болон ЭМД-д 28.1 сая төгрөг төлсөн,
- Орон нутгийн бичил болон жижиг, дунд үйлдвэрлэлийг санхүү, хөрөнгө оруулалтын бодлогоор дэмжин өргөжүүлэн хөгжүүлэх, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг хөнгөлөлттэй зээл, төслийн хэрэгжилт, зарцуулалтад хяналт хэрэгжүүлээгүй,
- Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан болон аймгийн төсвийн байгууллагуудад мөрдөгдөх "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг" боловсруулах ажлыг Актив аудит ХХК, Адвэнсэд адвайсори ХХК-тай 2023 оны 12 дугаар сарын 14 өдөр нийт 38.9 сая төгрөгийн гэрээ байгуулж, гэрээний төлбөрийг барьцаа хөрөнгийн дансанд шилжүүлсэн,
- "Мал эмнэлгийн дуудлага үйлчилгээний чанар хүртээмж, ажиллах нөхцөлийг бүрдүүлэх" арга хэмжээний зардлаас 113.9 сая төгрөгийн хөрөнгө /34 ширхэг мотоцикл/ худалдан авсан.
- Орон нутгийн төсвийн орлого нэмэгдсэнтэй холбоотойгоор ТАХ-ний төсвийг жил бүр нэмэгдүүлэн баталсан боловч төсөл арга хэмжээний хүрэх үр дүнг тодорхойлдоггүй,
- Үндэсний болон орон нутгийн онцлогтой спортыг хөгжүүлэх ТАХ-ний хүрээнд спортын холбоо, төрийн бус байгууллагууд, мэргэжлийн клубүүдэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх шалгуур үзүүлэлт, тоо хэмжээ, давтамжийг журмаар зохицуулаагүй,
- Хөтөлбөр, арга хэмжээний баримт материалуудыг архивын нэгж үүсгэдэггүй,
- Аймгийн Засаг даргын Тамгын газрын болон Биеийн тамир спортын газрын мэргэжилтэн нарыг БНСУ-д туршлага судлахад Аймгийн Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 12-ны А/2335 дугаар захирамжаар тус бүрд 5.0 сая төгрөгийн дэмжлэг олгосон боловч явсан эсэх нь нотлогдоогүй байна.

5.12 Хөтөлбөрүүдийг хэрэгжих хугацаанд хяналт, шинжилгээ, үнэлгээ хийсэн боловч хэрэгжилтийг бодитой үнэлээгүй байна. Аудитаар дараах зөвлөмж хүргүүлсэн байна. Үүнд:

Аймгийн ИТХ-ын даргад

- Төсөл, хөтөлбөрүүдийн шалгуур үзүүлэлтийг оновчтой, хүрэх үр дүнг тодорхой байхаар батлах,

- АЗДТГ-т бүртгэлтэй зах зээлийн үнээс хямд өртөгтэй албан тушаалын байрыг Гурван сайхан орон сууцны корпорац ОНӨААТҮГ-т шилжүүлж эрх бүхий албан тушаалтанд түрээслүүлж, өмчлүүлж бусдад давуу эрх олгохгүй байх,

Аймгийн Засаг даргад

- Хөтөлбөрийн шалгуур үзүүлэлтийг оновчтой, үр дүнг нь тооцож, тайлагнаж болохуйц өөр хоорондоо уялдаатай байхаар төлөвлөх,
- Хөтөлбөрийн бүрэлдэхүүнд багтах арга хэмжээний тоо хэмжээ, цаг хугацаа, чанарын шалгуур үзүүлэлтээр тодорхойлж төлөвлөх,
- Хөтөлбөр, арга хэмжээний үр дүнг тооцож гүйцэтгэлд суурилсан санхүүжилт олгох,
- Хөтөлбөр, арга хэмжээг боловсруулах, зориулалтын дагуу зарцуулах, бүртгэх, тайлагнах, хяналт тавих үйл ажиллагааг сайжруулах,

Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн даргад

- Бодлогын баримт бичигт хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ урьдчилан тодорхойлсон шалгуур үзүүлэлтийн дагуу зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг нотлох баримтыг үндэслэн үнэлэх,
- Баримт бичгийн төлөвлөлт, биелэлтэд чанарын үнэлгээ хийх, хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, шийдвэр нь үр дүнтэй байсан эсэхэд чанарын үнэлгээ хийх, үр нөлөөг үнэлж ажиллах зөвлөмжүүдийг өгч ажилласан.

5.13 “Орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2020-2024 онд хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй байгаа тул ТЕЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд зөрчлийг давхардуулж оруулаагүй бөгөөд 2024 оны хагас жилээс хойш хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээг аудитад хамруулсан.

5.14 ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар дараах зөрчил, дутагдал илэрсэн байна. Үүнд:

- "Архинд донтох өвчтэй иргэдэд үйлчилгээ үзүүлэх арга хэмжээ"-ний зардлаас Аймгийн Засаг даргын 2024 оны А/2453 дугаар захирамжийн дагуу "Итгэлтэй амьдрал" ОНӨААТҮГ-ын үүссэн өр төлбөрийг барагдуулахад 109.9 сая төгрөг зарцуулсан нь баримтаар нотлогдоогүй,
- Аймгийн Засаг даргын 2024 оны А/2433 дугаар захирамжаар БОЭТ-ийн албан хаагчдыг эрт илрүүлгийн үзлэг шинжилгээ, оношилгоонд хамруулахаар олгосон 24.0 сая төгрөгийн дэмжлэг олгосон ч төсвийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулаагүй, үзлэг шинжилгээнд хамруулаагүй,
- Аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөө, АИТХ-ын 2024 оны 19/28 дугаар тогтоолд аймгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр тусгасан "Аймгийн санхүү нягтлан бодох бүртгэл, эдийн засгийн ажилтнуудын мэдлэг, боловсрол, чадавхыг дээшлүүлэх, нягтлан бодох бүртгэл хөтлөлт, ОУ-ын стандартын нэвтрэлтийг нэмэгдүүлэх" арга хэмжээг 200.0 сая төгрөгөөр сумдын засаг даргын нөөц сангийн хөрөнгөөр санхүүжүүлсэн,
- Залуус хөтөлбөрөөс монголын Залуучуудын холбоо Өмнөговь аймаг дахь салбараас зохион байгуулсан "Оны шилдгүүдийг шалгаруулах" шинэ жилийн арга хэмжээнд 26.7 сая төгрөг зарцуулсан,
- Аймгийн Засаг даргын 2024 оны А/1855 дугаар захирамжаар "Энэ жилдээ-Эрүүл жиндээ аяны" хүрээнд хэрэгжүүлсэн Өмнөговь аймгийн даян хааны хүчтэн пауэрлифтинг бодибилдинг, фитнесийн холбоонд олгосон 10.0 сая төгрөгийн зарцуулалт анхан шатны баримтаар нотлогдохгүй зорилтот бүлгийн иргэдийг идэвхтэй дасгал хөдөлгөөнд хамруулаагүй,

Өмнөговь аймгийн Засаг даргын 2024 оны нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

- "Цахим Өмнөговь" хөтөлбөрийн хүрээнд "Ногоон хөгжлийг түгээн дэлгэрүүлэх контентууд болон апп хөгжүүлэх" ажлыг МВМ сор ХХК-аар гүйцэтгүүлж аймгийн ЗДТГ-ын даргын 2024 оны А/766 дугаар тушаалаар ажлын хэсэг байгуулан хүлээж авсан боловч бүртгэлд тусгаагүй,
- "Хүнсний хангамж-аюулгүй байдал" үндэсний хөдөлгөөнийг орон нутагт хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний зардлаас 68.1 сая төгрөгийн тусгаарлах хана, 77.6 сая төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авсан,
- Аймгийн Засаг даргын 2024 оны А/2423 дугаар захирамжийн дагуу Түрээсийн орон сууцны зориулалтаар газар, үл хөдлөх хөрөнгийн нөхөн олговорт 665.6 сая төгрөг олгосон боловч газрыг чөлөөлж, төрийн өмчид бүртгээгүй,
- Агаарын бохирдолгүй Өмнөговь хөтөлбөрийн хүрээнд гэр хорооллын айл өрхийн энгийн галлагаатай зуухыг дэвшилтэт технологи бүхий цахилгаан зуухаар сольж, агаарын бохирдлыг бууруулах зорилгоор тайлант онд 48 ширхэг цахилгаан зуухыг худалдан авсан боловч өнөөг хүртэл иргэдэд олгоогүй, журмын дагуу өрхийн судалгааг бүрэн гаргаж дуусаагүй байна

5.15 Хөтөлбөр, төсөл арга хэмжээний зардлаас дараах байгууллагуудад санхүүжилт олгосон байна. Үүнд:

- Нийгмийн эрүүл мэндийн болон эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор архи, согтууруулах ундаа, мансууруулах бодисын хамаарал бүхий иргэдэд биеийн болон сэтгэл зүйн эмчилгээ, үйлчилгээ үзүүлэх чиг үүрэг бүхий Сэтгэж нийгмийн сэргээн засах "Итгэл дүүрэн амьдрал төв" улсын төсөвт үйлдвэрийн газрыг аймгийн Засаг даргын 2024 оны А/232 дугаар захирамжаар байгуулан тайлант онд 361.6 сая төгрөг,

- Эрүүл шүд" хөтөлбөрийн хүрээнд дэвшүүлсэн амны хөндийн шүдний өвчлөлийг бууруулах чиглэлээр байгуулсан "Говь дент" ОНӨААТҮГ шүдний төвийг 2023 онд үүсгэн байгуулж хөтөлбөр, төсөл арга хэмжээний зардлаас санхүүжүүлж ажилласан бөгөөд 2024 онд 241.3 сая төгрөг,

- ШУТИС-ийн харьяа Өмнөговь аймаг дахь Технологийн дээд сургуулийн багш нарын цалин, томилолтын зардалд 272.9 сая төгрөг,

- Энгийн хог хаягдлын төвлөрсөн цэг байгуулах, ангилан ялгах, устгах, дахин боловсруулах, менежментийг хэрэгжүүлэхээр Цэмцгэр Өмнөговь ОНӨААТҮГ-ыг үүсгэн байгуулж 455.4 сая төгрөгийн санхүүжилт тус тус олгосон байна.

5.16 "Орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2020-2024 онд хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн"-д хийсэн гүйцэтгэлийн аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах шаардлагатай байна.

## АУДИТЫН ДҮГНЭЛТ

Аудитаар илрүүлсэн зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- Өмнөговь аймгийн ИТХ-ын 2024 оны 03/10 дугаар тогтоолоор "Аймгийн 2024 оны хөгжлийн жилийн төлөвлөгөө"-ний хэрэгжилтийг 85 хувь буюу "тодорхой үр дүнд хүрсэн" гэж дүгнэсэн байна.
- Өмнөговь аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл"-д тусгасан зарим ажлууд огт хэрэгжээгүй 11, хэрэгжилт удааширалтай байгаа 35 арга хэмжээ байгааг анхаарах шаардлагатай байна.
- Төсвийн ерөнхийлөн захирагчийн хөгжлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх, төсвийг боловсруулж, батлуулахад Төсвийн тухай хуулийн 28<sup>1</sup> дүгээр зүйлд заасныг хэрэгжүүлэн олон нийтийн оролцоог хангаж ажиллаагүй байна.
- Монгол Улсын Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт нийцүүлэн Өмнөговь аймгийг хөгжүүлэх бодлогын баримт бичгүүдэд хөрөнгө оруулалтын 5 төсөл, арга хэмжээг тусгаж, хэрэгжилтийг хангаж ажилласан байна.
- Төсвийн орлогыг бодит тооцоо судалгаанд үндэслээгүй нь орлогын төлөвлөгөө тасрах нөхцөлийг үүсгэсэн байна.
- Аймаг орон нутгийн зүгээс төсвийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах, орон нутгийн төсөв бүрдүүлэх, татварын бааз суурийг өргөжүүлэх, төсвийн орлогын төлөвлөгөөг биелүүлэх зорилгын хүрээнд олон талын арга хэмжээг зохион байгуулж ажилласан байна.
- Төсвийн орлогын төлөвлөгөөг Баяндалай, Манлай, Ханбогд, Ханхонгор, Хүрмэн, аймаг тус тус тасалсан байна.
- Ханбогд, Цогтцэций сумууд орлого бүрэн төвлөрүүлээгүйгээс дээд шатны төсөвт төвлөрүүлэх орлого 78.8 хувийн гүйцэтгэлтэй байна.
- Орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлгээр 46,025.8 сая төгрөг олгож, Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд зааснаас 1,690.2 сая төгрөгийн санхүүжилт дутуу олгосон байна.
- Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1<sup>26</sup> дэх заалтын хэрэгжилтийг хангуулж ОНХС-ийн хандивын эх үүсвэрийг нэмэгдүүлж ажиллаагүй байна.
- Аймгийн төсвийн нийт орлого 1,879,083.5 сая төгрөг болж өмнөх оноос 1.7 дахин өссөн нь аж ахуйн нэгжийн орлогын дахин хуваарилалттай холбоотой байна.
- Төсвийн хөрөнгийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах шаардлагатай байна.
- Улсын төсөвт 1,249,676.3 сая төгрөг төвлөрүүлсэн нь ТЕЗ-ийн нийт зарлагын 54.4 хувийг эзэлж байна.
- Хөрөнгийн зардал өмнөх оны гүйцэтгэлээс 209,211.6 сая төгрөгөөр өссөн ч тайлант онд 75.7 хувийн гүйцэтгэлтэй байгаа нь орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар

<sup>26</sup> Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх, хандив, тусламж өгөх асуудлаар нутгийн захиргааны байгууллагатай гэрээ байгуулж ажиллана.

Өмнөговь аймгийн Засаг даргын 2024 оны нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ бүрэн хэрэгжээгүй болон төсвийн орлого бүрэн төвлөрөөгүйтэй холбоотой байна.

- Төрийн хэмнэлтийн тухай хуулийн зөрчлийн тоо 32-оор буюу 33.3 хувиар буурсан байгаа нь Төрийн аудитын байгууллагаас өмнөх аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагыг хэрэгжүүлж ажилласантай холбоотой байна.
- Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд Өмнөговь аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба сар бүр хяналт тавьж ажиллаж байгаа ч зөрчлийн дүн буурахгүй байна.
- Төсвийн урсгал зардлын төлөвлөлт, зарцуулалтад тавих дотоод хяналт сул байна.
- ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний төлөвлөлтийг сайжруулах, санхүүжилтийн гүйцэтгэлд тавих хяналтыг сайжруулах шаардлагатай байна.
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.8<sup>27</sup> болон худалдан авах ажиллагаанд мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, үйл ажиллагаанд нь хяналт тавьж хуулийн хэрэгжилтийг хангуулж ажиллах шаардлагатай байна.
- Орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2020-2024 онд хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн"-д хийсэн гүйцэтгэлийн аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах шаардлагатай байна.
- ХШҮХ-ээс “Нутгийн хишиг” хөтөлбөрт тусгагдан батлагдсан хөтөлбөрийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан, дүгнэлтийг үндэслэн хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөлт, үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэх, хэрэгжилт зохион байгуулалт сайжруулах зөвлөмжийг АЗДТГ-ын хэлтэс, мэргэжилтнүүдэд хүргүүлсэн байна.
- Хөтөлбөр, төсөл арга хэмжээний зардлаас ОНӨААТҮГ-уудад санхүүжилт олгосон байна.

---

<sup>27</sup> Худалдан авах ажиллагааны мэргэжлийн байгууллагын аймаг, нийслэл, дүүрэг дэх нэгж дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ

## АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна.

### Өмнөговь аймгийн Засаг даргад

- Төсвийн төсөл боловсруулахад олон нийтийн оролцоог хангаж ажиллах,
- Төсвийн хөрөнгийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах,
- Төсвийн хөрөнгө оруулалт, хөтөлбөр арга хэмжээний төлөвлөлтийг хуульд тогтоомжид нийцүүлэх, хөтөлбөр, арга хэмжээний зардлаас байгууллагын санхүүжилт гаргахгүй байх,
- ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэлд тавих хяналтыг сайжруулах,
- Татварын бааз суурийг үндэслэн төсвийн орлогыг бодитой төлөвлөх, гүйцэтгэлийг хангах
- “Орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2020-2024 онд хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж ажиллах,
- Төсвийн төлөвлөлт, зарцуулалтад тавих дотоод хяналтыг сайжруулах, зөрчил дутагдлыг бууруулах, хариуцлагын тогтолцоог нэмэгдүүлэх,
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах, төсвийн шууд захирагч нарт арга зүйн зөвлөгөө өгөх, худалдан авах ажиллагааны чиглэлээр мэргэшүүлэх, сургалтад хамруулах бусад арга хэмжээг авч ажиллах,

## ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ



### ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2025 оны 04 сарын 21 өдөр

Дугаар А/06

Даланзадгад сум

#### Аудитын тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, 9 дүгээр зүйлийн 9.1, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын 18.9, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2023 оны А/102 дугаар “Эрх шилжүүлэх тухай” тушаалын дөрөвдүгээр хавсралтын 1.4-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Өмнөговь аймгийн Засаг даргын 2024 оны нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайланг хавсралтаар баталгаажуулсугай.
2. Аудитын тайланг Санхүү-нийцлийн аудитын газар болон Өмнөговь аймгийн Засаг даргад тус тус хүргүүлэхийг ахлах аудитор (С.Одончимэг)-т үүрэг болгосугай.
3. Аудиттай холбоотой ажлын нотлох баримтыг архивын нэгж болгон хүлээлгэн өгөхийг ахлах аудитор (С.Одончимэг)-т даалгасугай.



Ц.ӨСӨХБЯЯР

4625010920

Улаанбаатар, 2025 оны 04 сарын 21 өдөр

## ХАВСРАЛТ 1

Хүснэгт № 1 Төлөвлөсөн хөтөлбөр, төсөл арга хэмжээний жагсаалт

(сая.төгрөг)

№	Төсөл, арга хэмжээний нэр	2024 оны төлөвлөгөө	2024 оны гүйцэтгэл
1	Нөхөн үржихүйн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлж, эх хүүхдийн эндэгдэл, үр хөндөлтийг бууруулах зорилгоор "Эх хүүхдийн эрүүл мэнд" хөтөлбөрийг хэрэгжүүлэх	100.0	100.0
2	Хүн амын шүд, амны хөндийг эрүүлжүүлэх хүрээнд "Эрүүл шүд" хөтөлбөрийн хэрэгжүүлэх	398.0	213.6
3	Хүн амын дунд Гепатит вирусийн халдварын эрт өртөх эрсдэл бүхий зорилтот бүлгийг мэдээллээр хангаж, эрт илрүүлэгийг хийх замаар "Эрүүл элэг" хөтөлбөрийг хэрэгжүүлэх	100.0	52.2
4	Бага насны хүүхдүүдийн хоол тэжээлийн дутагдлаас хамгаалах, өсөлт хөгжлийг дэмжих зорилгоор "Сүү тараг" хөтөлбөрийг хэрэгжүүлэх	250.0	232.3
5	Хүн амыг харшлын өвчлөлөөс сэргийлэх, мэдлэг хандлагыг сайжруулах, оношилгоо эмчилгээний чанар хүртээмжийг сайжруулах зорилгоор "Харшлын эсрэг" хөтөлбөрийг хэрэгжүүлэх	50.0	15.2
6	Хавдрын химийн эмчилгээ, хавдрын эрт илрүүлэгийг орон нутагт хийх ажлыг зохион байгуулах	201.0	163.9
7	Хүн амын дунд урьдчилан сэргийлэх үзлэг оношилгоо эмчилгээг зохион байгуулах	260.5	246.7
8	Иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох, эрүүл зөв, хооллолт, стрессээ удирдах, идэвхтэй дасгал хөдөлгөөн бүхий зөв амьдралын хэв маягийг сурталчлах төсөл арга хэмжээг хэрэгжүүлэх	150.0	146.2
9	Иргэдэд эрүүл мэндийн зуучлах үйлчилгээг үзүүлэх Өмнөговь аймгийн иргэдэд зөвлөн зуучлах төв-ийг Улаанбаатар хотод байгуулна	-	-
10	Үндэсний болон бусад орон нутгийн онцлогтой спортыг хөгжүүлэх	2,170.0	2,032.5
11	Нийтийн биеийн тамирыг дэмжин хөгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх	614.0	293.3
12	Үндэсний болон бусад орон нутгийн онцлогтой спортыг хөгжүүлэх хөтөлбөрийн хүрээнд улс, бүсийн чанартай уралдаан тэмцээн зохион байгуулах	645.0	641.0
13	Хүүхдэд Монгол ёс заншлаа дээдэлсэн, зөв төлөвшил хандлагатай, эх оронч, эрх чөлөөт, сэтгэлгээтэй, үндэсний бахархлыг төлөвшүүлсэн "Говийн ирээдүй хүүхэд" хөтөлбөрийг хэрэгжүүлэх	450.0	449.0
14	Хот, хөдөөгийн сэргэлтийн бодлогын хүрээнд салбар бүрийн чадварлаг мэргэжилтнүүдийг орон нутагтаа ирж ажиллахыг дэмжих "Эзэмшсэн мэргэжлээрээ эх нутагтаа ажиллая" хөтөлбөрийг хэрэгжүүлэх	450.0	314.4
15	Хот, хөдөөгийн сэргэлтийн бодлогыг эрчимжүүлж, багш өөрөө хөгжих "Чадварлаг багш" хөтөлбөрийг хэрэгжүүлэх	750.0	748.7
16	"Сурагч солилцоо" хөтөлбөрийг хэрэгжүүлж, ахлах ангийн сурагчдыг өндөр хөгжилтэй оронд сургах боломжийг бүрдүүлэх	350.0	283.1
17	Ерөнхий боловсролын сургуулийн 6 дугаар ангид "Үдийн хоол" хөтөлбөр хэрэгжүүлэх, цэцэрлэг, дотуур байрны хүүхдийн хоолны зардлыг нэмэгдүүлэх	2,808.0	2,056.6
18	Математикийн сургалтын чанарыг сайжруулах, арга зүй туршлага солилцох зорилгоор улсын математикийн олимпиадыг зохион байгуулах	840.0	608.0
19	Тусгай хэрэгцээт боловсролын анги бүлгийн хүртээмжийг нэмэгдүүлж, тусгай багш, мэргэжилтнийг бэлтгэн, хүүхэд бүрийг боловсролд тэгш хамруулах боломжийг бүрдүүлэх	30.0	28.8

Өмнөговь аймгийн Засаг даргын 2024 оны нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

20	Орон нутгийн хэрэгцээт боловсон хүчний хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор оюутан суралцагчдыг тэтгэлэгт хөтөлбөрт хамруулах	1,100.0	906.0
21	ШУТИС-ийн харьяа Өмнөговь аймаг дахь Технологийн дээд сургуулийн багш нарын цалин, томилолт	272.9	272.9
22	Иргэдийн цахим, инженерийн боловсрол, хүүхэд залуусын техник сэтгэлгээг хөгжүүлэх зорилгоор төсөл, арга хэмжээ төлөвлөн хэрэгжүүлэх	150.0	98.5
23	Хүүхэд, залуус, ард иргэдийн цахим боловсролыг дэмжих " <b>Цахим-Өмнөговь</b> " хөтөлбөрийн тухай жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх	650.0	548.4
24	Олон улс, дотоодын дэвшилтэт технологийг орон нутагт нутагшуулах, эцсийн бүтээгдэхүүн, үйлчилгээ болгоход тэтгэлэг олгох	500.0	24.0
25	Өмнөговь аймгийн шинжлэх ухаан, технологи, инновацийн зөвлөлийн 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх	50.0	15.0
26	Залуучуудын эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн харилцаа, сэтгэл зүй, хөгжлийн хэрэгцээг дэмжихэд чиглэсэн " <b>Залуус</b> " хөтөлбөрийг хэрэгжүүлэх	535.0	468.7
27	"Өсөлтийг өрх бүрд" хөтөлбөрийг хэрэгжүүлж, шинээр байнгын болон түр ажлын байрыг бий болгож, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх	2,000.0	1,140.7
28	Хүүхдийн эрхийг дээдлэн "Хүүхдэд ээлтэй орон нутаг" төслийг хэрэгжүүлэх	1,250.0	346.4
29	Хүүхдийн хөгжил, хамгааллын жилийн хүрээнд хийгдэх төсөл, арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх	780.0	496.2
30	Гэр бүл, эмэгтэйчүүд, хүүхэд хамгааллын үйл ажиллагааг дэмжих	180.0	180.0
31	Жендерийн эрх тэгш байдлыг хангах үйл ажиллагааг хэрэгжүүлэх	100.0	65.1
32	40-өөс дээш настай иргэд, хөгжлийн бэрхшээлтэй, зорилтот бүлгийн иргэдийн хөдөлмөр эрхлэлт, хөгжил хамгааллыг сайжруулах	1,000.0	924.4
33	Ахмад настан хөгжлийн бэрхшээлтэй, зорилтот бүлгийн иргэдийн хөгжил хамгааллыг сайжруулах	450.0	442.0
34	Иргэний нийгмийн байгууллагууд, мэргэжлийн холбоодыг чадавхжуулан, төрийн зарим чиг үүргийг гүйцэтгүүлж, хамтран ажиллах	180.0	112.4
35	Зорилтот бүлгийн иргэдийн амьдрах орчин, нөхцөлийг сайжруулах хүрээнд төсөл, арга хэмжээ төлөвлөн хэрэгжүүлэх	2,490.0	2,373.3
36	" <b>Хос сайхан бичигтэн-Өмнөговь</b> ", Утгын чимэг яруу найргийн наадам уламжлалыг сэргээн хөгжүүлэх	50.0	46.7
37	Соёл урлагийн салбарыг мэргэжлийн хүний нөөцөөр хангах, тэдний ур чадварыг сайжруулж, орон нутгийн уран бүтээлчдийн уран бүтээл, авьяас билгийг олон нийтэд сурталчлах	540.0	483.8
38	Батмөнх Даян хаан судлал, түүний түүхэн үйл хэргийг сурталчлах, алдаршуулах ажлыг зохион байгуулах	658.9	655.2
39	Өмнөговь аймгийн түүх, соёлын дурсгалын хадгалалт хамгаалалтыг олон улсын жишигт нийцүүлэн, соёлын өвийг олон нийтэд сурталчлан таниулж, түгээн дэлгэрүүлэх	320.0	298.5
40	Морин хуурын олон улсын VII наадам, Өмнөговийн онцлог морин хуурын эвэнт арга хэмжээ зохион байгуулах	317.5	310.2
41	Аймаг, сумдын баяр наадмыг зохион байгуулж, үндэсний ёс заншил уламжлалаа дэмжин хөгжүүлэх	1,160.0	1,158.5
42	Төрийн албан хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн " <b>Нутгийн дэм</b> " хөтөлбөрийг хэрэгжүүлэх	30,650.0	26,233.4
43	Санхүүгийн хувьд орон нутгийн бие даасан байдлыг бэхжүүлэх, татвар төлөгч нарын татварын боловсролыг дээшлүүлэх ажлын хүрээнд бүх сумдад хүрч ажиллах, уул уурхайн компаниудын туслан гүйцэтгэгчид болон тээврийн компаниудад сургалт сурталчилгаа хийх, үйл ажиллагаанд нь зөвлөн туслах замаар татварт хамрагдалтыг нэмэгдүүлэх, татварын орлогын бааз суурийг нэмэгдүүлэх	850.0	660.3

Өмнөговь аймгийн Засаг даргын 2024 оны нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

44	Орон нутгийн төсвийн зарлагын үр ашгийг дээшлүүлж, төсвийн урсгал болон хөрөнгийн зардлын санхүүжилт, тайлагнал, хяналтыг сайжруулж, хэмнэлтийн горимд шилжүүлэх, төсвийн сахилга батыг дээшлүүлэн, хариуцлагатай байх зарчмыг хэрэгжүүлэх	250.0	-
45	Аймгийн санхүү, нягтлан бодох бүртгэл, эдийн засгийн ажилтнуудын мэдлэг, боловсрол, чадавхыг дээшлүүлэх, нягтлан бодох бүртгэл хөтлөлт, олон улсын стандартын нэвтрэлтийг нэмэгдүүлэх	500.0	448.8
46	Төсөв санхүүгийн чиглэлээр орон нутагт дутагдаж байгаа боловсон хүчнээр хангах, нягтлан бодох бүртгэлийн эчнээ сургалтыг орон нутагтаа зохион байгуулах	250.0	202.6
47	Иргэд олон нийтийн санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх, хүүхэд, залуучуудад бага наснаас нь санхүүгийн мэдлэг, боловсролыг эзэмшүүлэх	300.0	47.2
48	Орон нутгийн бонд гаргах бэлтгэл ажлыг хангах, холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллах	100.0	85.5
49	Төсвийн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний төсвийн байгууллага орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн хөрөнгө, өр төлбөр, орлого зарлага, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт шалгалт, дотоод аудит хийж эрсдэлийн удирдлагаар хангах	10.0	10.0
50	Төсвийн санхүүгийн ил тод байдлыг хангаж Шилэн дансны хуулийг хэрэгжилтийг хангаж, сургалтыг зохион байгуулах	40.0	-
51	Дотоод аудитыг бэхжүүлэх, дотоод аудиторруудыг мэргэшүүлэх сургалтад хамруулах	10.0	-
52	Орон нутгийн өмчид бүртгэлтэй хөрөнгийн ашиглалт хамгаалалтыг сайжруулах, үр өгөөжийг нэмэгдүүлэх	170.0	130.9
53	Худалдан авах ажиллагаанд оролцох иргэний төлөөллийг идэвхжүүлж ил тод байдлыг нэмэгдүүлэх	20.0	19.4
54	Хариуцлагатай уул уурхайг хөгжүүлж, боловсруулалтын түвшнийг нэмэгдүүлнэ.	50.0	-
55	Уул уурхайн хамтын ажиллагааны гэрээний хүрээнд, жилийн төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх, хамтын ажиллагааны хорооны ажиллах журмыг боловсруулан ажиллах.	40.0	-
56	Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлыг хангаж, бичил уурхайгаар ашигт малтмал олборлох үйл ажиллагааг хуулийн хүрээнд дэмжиж ажиллах	40.0	35.0
57	Орон нутагт ашигт малтмал, газрын тосны чиглэлийн үйл ажиллагааг орон нутгийн иргэд, малчид, засаг захиргааны байгууллагууд, сум орон нутгийн удирдлагуудыг мэдээллээр хангаж, харилцан уялдаатай, нээлттэй ил тод ажиллах, цаашид уул уурхайн олборлолт, ашигт малтмалын хайгуул болон ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох, төрөөс эрдэс баялаг, уул уурхай хүнд үйлдвэрийн салбарт баримтлах бодлогыг орон нутагт хэрэгжүүлэх	50.0	42.5
58	Оюутолгой, Тавантолгой, Нарийн сүхайтын бүлэг ордыг түшиглэн зэсийн баяжмал хайлуулах, кокс химийн үйлдвэрийн болон метан хийг олборлох тээвэрлэх, үйлдвэрлэх, ашиглах төсөл, санаачилгыг бодлогоор дэмжих	50.0	-
59	Өмнөговь аймаг ашигт малтмал, газрын тосны салбарын ил тод байдал, дэд бүтцийн төслийн нэгдсэн чуулганыг зохион байгуулах	100.0	28.8
60	Шинээр байгуулагдах үйлдвэрийн газруудыг орон нутгийн өмчийн оролцоотойгоор болон төр хувийн хэвшлийн түншлэлээр орон нутгийн эдийн засаг, нийгмийн салбарт өндөр үр ашигтай төсөл хөтөлбөрийг хамтран хэрэгжүүлэх замаар өрхийн орлогыг нэмэгдүүлэх	25.0	-
61	Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох хууль, эрх зүйн орчны хүрээнд сайн туршлагад суурилсан бичил уурхайг хөгжүүлэх	1,500.0	965.4
62	"Хүнсний хангамж - аюулгүй байдал" үндэсний хөдөлгөөнийг орон нутагт хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх	2,300.9	620.4
63	"Говь+Ус" хөтөлбөр хэрэгжүүлж, Бэлчээр усжуулалтын хоёрдугаар аяны хүрээнд инженерийн хийцтэй худаг шинээр гаргах, хуучин худгийг засварлаж бэлчээр усжуулалтыг нэмэгдүүлэх	-	-
64	<b>Чинээлэг малчин хөтөлбөрийн 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх</b>	1,788.0	501.8

Өмнөговь аймгийн Засаг даргын 2024 оны нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

65	Мал, амьтны гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх арга хэмжээг хэрэгжүүлэх	200.0	134.5
66	Мал, амьтны халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх	415.6	404.8
67	Мал сүргийг бруцеллэз, ям, сүрьеэ өвчнөөс эрүүл бүсийг баталгаажуулах тандалт шинжилгээний ажлыг төлөвлөн хэрэгжүүлэх /Манлай, Ханбогд, Баян-Овоо/	61.6	-
68	Орон нутгийн бичил болон жижиг, дунд үйлдвэрлэлийг санхүү, хөрөнгө оруулалтын бодлогоор дэмжин өргөжүүлэн хөгжүүлэх, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг хөнгөлөлттэй зээл, төсөл хөтөлбөрт хамруулах	3,000.0	2,999.0
69	Өмнөговь аймгийн аялал жуулчлалыг хөгжүүлэх хэтийн зорилт төлөвлөгөөг хэрэгжүүлэх, орон нутгийн эвентүүдийг хөгжүүлэх, зохион байгуулах, аялал жуулчлалын олон улсын болон дотоодын үзэсгэлэн, уулзалт, зөвлөгөөн, сургалтад оролцох	905.0	724.2
70	Хил орчмын аялал жуулчлалыг хөгжүүлэх, байгалийн үзэсгэлэнт газруудыг сурталчлан таниулах	90.0	47.7
71	"Агаарын бохирдолгүй Өмнөговь" хөтөлбөрийг хэрэгжүүлж, айл өрх, байгууллагуудын тарифт болон дулааны тоолуурын хэрэглээг нэмэгдүүлэх, хэрэглээний зардал багатай, үр ашиг өндөртэй халаалтын шинэ техник, технологийн туршилт, хэрэглээг дэмжих	600.0	150.0
72	Нийтийн тээврээр ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хүүхдийг харьяалал харгалзахгүй, чөлөөтэй, үнэ төлбөргүйгээр зорчих нөхцөл боломжийг бүрдүүлж ажиллах	551.7	533.0
73	Орон нутгийн болон зорилтот бүлгийн иргэдэд олгох нөхөн олговортой нислэгийн зардал	990.0	813.5
74	Эдийн засгийн өсөлтийг дэмжих, экспортыг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн авто зам болон төмөр зам, тээврийн дэд бүтцийн төслүүдийг хамтран хэрэгжүүлж, зам дагасан дэд бүтцийг бий болгох ажлыг эхлүүлэх, тээвэр ложистикийн чуулган уулзалт зохион байгуулах	-	-
75	Цэгцтэй гэр хороолол хөтөлбөрийг хэрэгжүүлэх	912.0	694.3
76	Аймгийн хэмжээнд цэвэр, бохирын шугамд холбогдох хөнгөлөлт үзүүлэх бодлогыг хэрэгжүүлэх	900.0	807.5
77	Аймгийн төвийн төв цэвэрлэх байгууламжийн хэвийн үйл ажиллагааг хангах	320.0	280.0
78	"Шинэ мянган айл" орон сууцны хөтөлбөрийн хүрээнд аймаг сумын ерөнхий төлөвлөгөө болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан газарт амины орон сууцны хорооллын дэд бүтцийг байгуулах, хувийн хэвшлийг бодлогоор дэмжих төсөл хэрэгжүүлэх	1,740.0	1,737.0
79	Ашиглалтын шаардлага хангахгүй 1, 4, 5, 6, 7, 8 -р орон сууцны барилгыг буулгаж, дахин барилгажуулах ажлыг дуусгаж, орон сууцны дахин төлөвлөлтийн ажлуудыг эхлүүлэх	2,712.5	2,307.7
80	Нийтийн орон сууцны Сууц өмчлөгчдийн холбооны үйл ажиллагааг бодлогоор дэмжиж, гадна тохижилт, дээврийн засварын ажлыг хийж гүйцэтгэх	1,152.2	-
81	Нийтийн ахуй үйлчилгээний үйл ажиллагааг дэмжих, ур чадварыг сайжруулах	30.0	10.0
82	Аймгийн хэмжээний статистикийн тоо мэдээллийн хамралт, хэрэглээг нэмэгдүүлэх, чанарыг сайжруулахад орчин нөхцөлийг сайжруулах, мэргэжил арга зүйгээр хангах	97.0	96.9
83	"Нээлттэй Өмнөговь" хөтөлбөрийг хэрэгжүүлж, орон нутагт шилжин ирэгсдийн ажиллаж, амьдрах орчин, иргэд, ААН, байгууллагын үйл ажиллагаа явуулах нөхцлийг бүрдүүлэх, аймгийн тухай нэгдсэн ойлголт, мэдээллийн сан, нэгдмэл удирдлага, зохицуулалт бүхий төрийн үйлчилгээний цахим систем бий болгох төсөл, арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх	100.0	-
84	Өмнөговь аймгийн эдийн засаг, хөрөнгө оруулалт, бизнесийн орчны чуулган, хэлэлцүүлэг зохион байгуулах	150.0	-
85	Аймгийн хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, судалгаа, статистик мэдээллийн нэгдсэн цахим систем бий болгох	-	-
86	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын PMIS системд нэвтрүүлж, хөрөнгө оруулалтын талаарх цогц мэдээллийг олон нийтэд хүргэнэ	296.4	-

Өмнөговь аймгийн Засаг даргын 2024 оны нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

87	Аймгийн хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн товхимол, газрын зураг хэвлэх, олон нийтэд таниулах ажлыг зохион байгуулах	65.0	-
88	Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын үр өгөөж, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэрэгжилт, бодлогод иргэдийн оролцоог хангах, бодлогын хэрэгжилтийн эргэх холбоо бий болгох судалгаа, нэгдсэн мэдээллийн сан бий болгох	650.0	468.6
89	Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын чуулганд оролцох, туршлага судлах, сургалтад хамруулах	54.5	16.8
90	И-Монголиа, хур систем, цахим үйлчилгээ хариуцсан албан хаагчийн эрхийг сунгах болон анхан, дунд, мэргэшүүлэх шатны сургалтыг зохион байгуулах	150.0	102.6
91	Хүүхэд, залуус, ард иргэдийн цахим боловсролыг дэмжих "Цахим-Өмнөговь" хөтөлбөрийн хүрээнд Цахим аймаг платформ хөгжүүлэх	-	-
92	Хүүхэд, залуус, ард иргэдийн цахим боловсролыг дэмжих "Цахим-Өмнөговь" хөтөлбөрийн хүрээнд малчдад зориулсан платформ хөгжүүлэх	-	-
93	Шуурхай удирдлага, хяналт үнэлгээний нэгдсэн тогтолцооны мэдээллийн сан	350.0	-
94	Төрийн албан хаагчийн нийгмийн асуудлыг шийдвэрлэх, тусламж дэмжлэг үзүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх	2,500.0	2,493.5
95	Орон нутагтаа тогтвор суурьшилтай, амжилттай ажиллаж байгаа төрийн албан хаагч, иргэдийг гадаад оронд туршлага судлуулах, мэргэшүүлэх "Хөгжлийн гүүр" хөтөлбөрийг хэрэгжүүлэх	1,500.0	1,414.6
96	Ил тод, нээлттэй байдал, иргэдийн оролцоог хангах арга хэмжээг хэрэгжүүлэх, Сум, баг хилийн боомтод төрийн үйлчилгээг нэг цэгээс үзүүлэх "Явуулын оффис" ажиллуулах	200.0	36.4
97	Төрийн албан хаагчдыг мэргэшүүлэх, харилцаа хандлагыг сайжруулах, багийн дарга нарын нэгдсэн сургалт, дотоодод туршлага судлах, арга хэмжээ, зөвлөгөөн зохион байгуулах	299.7	155.6
98	Сумдууд ISO стандартыг шинээр нэвтрүүлэх болон баталгаажуулалт, туршлага судлах, магадлах аудит хийх	250.0	81.0
99	Гамшгаас урьдчилан сэргийлэх, гамшгийн хор хохирлыг арилгах, хариу арга хэмжээг зохион байгуулах, хэрэгжүүлэх	2,000.0	1,017.4
100	Аймгийн хэмжээнд гамшгаас урьдчилсан сэргийлэх, гамшигт тэсвэртэй орон нутаг бодлогын хүрээнд төсөл, арга хэмжээ төлөвлөн хэрэгжүүлэх	1,402.9	1,343.6
101	Гэмт хэрэг, зөрчил, зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх "Ээлтэй Өмнөговь" хөтөлбөрийг хэрэгжүүлэх	150.0	138.7
102	Архинд донтох эмгэгтэй хүнд үзүүлэх эмчилгээ, үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлж, архинаас татгалзсан иргэдийг ажлын байраар хангах бодлого хэрэгжүүлэх	382.8	255.1
103	Гэр бүл хүүхэд эмэгтэйчүүдийг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх	150.0	66.6
104	Хүүхдийн эрхийг хамгаалах хүрээнд хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны үйл ажиллагааг явуулах	30.0	24.4
105	Гэмт хэргийн гаралтыг бууруулах, иргэдийн хяналтыг нэмэгдүүлэх зорилгоор олон нийтийн цагдааг ажиллуулах	486.5	-
106	Хил хамгаалалтад туслах хүчний зөвлөлийн зөвлөгөөний зохион байгуулж, төлөвлөгөөг хэрэгжүүлэх	20.0	20.0
107	Иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх, орон нутагт шударга өрсөлдөөнийг зохицуулах, Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, шүүх болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа, өмгөөлөгчтэй хамтран ажиллах	120.0	110.0
108	Орон нутагт хүний эрхийг хангах ажлын төлөвлөгөөг хэрэгжүүлэх	30.0	21.5
109	Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай тогтоомжийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх замаар цаашид хэрэгжүүлэх оновчтой бодлогыг тодорхойлж, үйл ажиллагааны үр нөлөөг дээшлүүлэх	20.0	20.0

Өмнөговь аймгийн Засаг даргын 2024 оны нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

110	Олон улсын байгууллагын зээлийн төлбөр, шүүхийн шийдвэрийн дагуу төлбөрийг төлөх	1,169.8	1,169.3
111	Монгол Улсын гадаад бодлого, харилцааны нэгдмэл байдлыг хангах, төр, засгийн байгууллагын гадаад харилцааг нэгдсэн байдлаар зохицуулах	90.0	90.0
112	Ундны усны аюулгүй байдлын 2024 оны төлөвлөгөөг хэрэгжүүлж, сав газруудын зөвлөгөөнийг зохион байгуулах	94.0	43.1
113	"Эко жорлон" хөтөлбөрийг хэрэгжүүлж аймаг, сумын гэр хорооллын айл өрхийг эко жорлонтой болгох ажлыг хэрэгжүүлэх	40.0	28.5
114	"Говь+Ус" хөтөлбөрийг хэрэгжүүлж, Даланзадгад сумын Шинэ цэвэрлэх байгууламжийн саарал усыг ойжуулалт, газар тариаланд ашиглах байгууламжийг барьж ашиглалтад оруулах	303.8	19.9
115	Аймгийн хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний дагуу хоёрдогч түүхий эд худалдан авах, энгийн хог хаягдлыг цэвэрлэх, ялгах, дахин боловсруулах бүхий үйл ажиллагааг бий болгох, бодлогоор дэмжин ажиллах	811.0	405.0
116	Улсын төсвийн байгууллагын албан хаагчдад орон нутгийн нэмэгдэл олгох	12,862.6	9,764.0
117	"Түрээсийн орон сууц хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх хүрээнд орон сууцны хотхон байгуулах зорилгоор газар чөлөөлөх, нөхөн олговор олгох	1,000.0	665.6
118	Нутгийн үйлдвэрлэгч хөтөлбөрийг хэрэгжүүлж арьс шир боловсруулах, сүү боловсруулах, сав баглаа боодлын үйлдвэрийг байгуулах, ашиглалтад оруулах	1,281.9	219.9
	Дүн	108,133.0	81,956.2